



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-8
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-80
1.Хууль, тогтоолын төслийг эцэслэн батлах	9-10
2.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	10-34
3.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар/	35-61
4.Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт	61-78
5.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	78-80

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 69 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 01 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Жаргалсайхан, Ц.Мөнхбат, Да.Цогтбаатар, Ж.Чинбүрэн;
Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан;
Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Х.Баттулга, Б.Батцэцэг,
П.Батчимэг, Э.Батшугар, Х.Болормаа, Д.Бум-Очир, Л.Гантөмөр,
Н.Наранбаатар;

Тасалсан: З.Мэндсайхан, Н.Номтойбаяр, О.Саранчулуун, Б.Энхбаяр,
Ж.Энхбаяр, Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: Н.Алтаншагай -18 минут, С.Амарсайхан -1 цаг 11 минут, Ч.Анар -02 минут, Ц.Баатархүү -01 минут, М.Бадамсүрэн -36 минут, Р.Батболд -18 минут, Ж.Батсуурь -02 минут, Н.Батсүмбэрэл -1 цаг 00 минут, Ж.Баярмаа -1 цаг 26 минут, Ш.Бямбасүрэн -02 минут, А.Ганбаатар -28 минут, Г.Ганбаатар -10 минут, Д.Ганбат -20 минут, П.Ганзориг -13 минут, Д.Ганмаа -10 минут, Ц.Даваасүрэн -02 минут, Т.Доржханд -1 цаг 17 минут, Б.Жавхлан -1 цаг 40 минут, Х.Жангабыл -04 минут, Б.Жаргалан -19 минут, Ж.Золжаргал -07 минут, Ц.Мөнхтуяа -16 минут, С.Одонтуяа -01 минут, Б.Пунсалмаа -40 минут, Б.Пүрэвдаваа -14 минут, Б.Түвшин -01 минут, Н.Учрал -08 минут, Б.Уянга -01 минут, Г.Уянгахишиг -58 минут, Б.Чойжилсүрэн -22 минут, С.Эрдэнэбат -18 минут.

Нэг.Хууль, тогтоолын төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Д.Амарбаясгалан: 1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 14

Бүгд: 79

82.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.“Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 15

Бүгд: 80

81.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

3.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 13

Бүгд: 80

83.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

4.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 13

Бүгд: 80

83.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 14

Бүгд: 80

82.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 13

Бүгд: 81

84.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 14

Бүгд: 82

82.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 16
Бүгд: 82
80.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

9.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 15
Бүгд: 82
81.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

10.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 11
Бүгд: 82
86.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, мөн газрын ахлах шинжээч Ө.Мөнхбаяр, Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч С.Эрдэнэцэцэг, хуульч М.Энхмэнд, судлаач И.Бямбахуу нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Хүүхдийн баяр”-ын өдрийг тохиолдуулан мэндчилгээ дэвшүүлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 10 цаг 30 минутаас хуралдааныг даргалав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Х.Баасанжаргал, Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, С.Ганбаатар, Д.Рэгдэл, Б.Уянга, Д.Пүрэвдаваа, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, судлаач И.Бямбахүү нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Ганмаа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу үдээс хойших хуралдаанаар явуулахаар хойшлуулав./11:41/

Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 40 минут үргэлжилж, 11 цаг 41 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 05 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үдээс хойших хуралдааныг даргалав.

Хуралдаан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 96
Бүгд: 102
5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Тамираа, Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Нийслэлийн боловсролын газрын дарга Б.Амартүвшин, Боловсролын үнэлгээний төвийн дарга Г.Гантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн газрын ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх мэдээллийг хийв.

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа, Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар нар индрээс үг хэлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, С.Эрдэнэболд, Ц.Мөнхтуяа нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11-д заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Үндэсний аудитын газрын Чанарын удирдлагын газрын ахлах аудитор Г.Жавхлан, мөн газрын Тамгын газрын менежер Б.Ариунзаяа,

Эрсдэлийн удирдлагын газрын менежер Л.Эрдэнэчулуун, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга Т.Баярхүү, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Даваасүрэн, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, “Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” ОНӨААТҮГ-ын дарга Б.Баттулга, мөн газрын ерөнхий инженер Ч.Буянжаргал, “Тавантолгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбаяр, мөн компанийн ерөнхий инженер Д.Өлзийбат, Санхүүгийн газрын дарга Х.Ариунзаяа, Экологийн цагдаагийн албаны дарга М.Батсайхан, мөн албаны Эрүүгийн цагдаагийн хэлтсийн дарга Г.Батжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, Х.Баасанжаргал, Д.Рэгдэл, Ө.Шижир нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Үндэсний аудитын газрын Эрсдэлийн удирдлагын газрын менежер Л.Эрдэнэчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Үндэсний аудитын газрын Чанарын удирдлагын газрын ахлах аудитор Г.Жавхлан, мөн газрын Тамгын газрын менежер Б.Ариунзаяа, Эрсдэлийн удирдлагын газрын менежер Л.Эрдэнэчулуун, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга Т.Баярхүү, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Даваасүрэн, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, “Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” ОНӨААТҮГ-ын дарга Б.Баттулга, мөн газрын ерөнхий инженер Ч.Буянжаргал, “Тавантолгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбаяр, мөн компанийн ерөнхий инженер Д.Өлзийбат,

Санхүүгийн газрын дарга Х.Ариунзаяа, Экологийн цагдаагийн албаны дарга М.Батсайхан, мөн албаны Эрүүгийн цагдаагийн хэлтсийн дарга Г.Батжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу дараагийн долоо хоногийн хуралдаанаар явуулахаар хойшлуулав./16:53/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 28 минут үргэлжилж, 126 гишүүнээс 104 гишүүн хүрэлцэн ирж, 82.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 01 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Чуулганы хуралдааны ирц хүрсэн байна. 69 гишүүн бүртгэгдэж, 54,8 хувьтай болсон байна. 2025 оны Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанаар нийт 5 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт хуулийн төслүүдийг эцэслэн батална. 2 дугаарт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Үдээс хойших хуралдаанаар Боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг Монгол Улсын Шадар сайд Амарсайхан хийнэ. 4 дүгээрт Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсоно. 5 дугаарт Засгийн газарт чиглэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалд оръё.

Нэг.Хууль, тогтоолын төслийг эцэслэн батлах

Хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийт 10 төсөл байгаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын өрийн удирдлагын 2026-аас 28 оны стратегийн баримт бичиг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батална. Хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах хувилбарыг Байнгын хороод бэлтгэн гишүүдэд тараасан байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе, хурууны хээгээ уншуулна. Санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Хурууны хээгээ уншуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байгаа. Тэгэхээр хуулийн төслүүд 64 гишүүнээр дэмжигдэж эцэслэн батлагдах нь. Бэлтгэл хангагдсан уу?

Санал хураалт. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Байж байгаарай. Санал хураалт. 65 гишүүн дэмжиж, 82,3 хувиар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын Өрийн удирдлагын 2026-аас 28 оны стратегийн баримт бичиг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 65 гишүүн буюу 81,3 хувиар санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 67 гишүүн дэмжиж, 83,8 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 67 гишүүн буюу 83,8 хувиар санал дэмжигдлээ.

3.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 66 гишүүн буюу 82,5 хувиар санал дэмжигдлээ.

4.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 68 гишүүн буюу 84 хувиар санал дэмжигдлээ.

5.Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 68 гишүүн буюу 82,9 хувиар санал дэмжигдлээ.

6.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 66 гишүүн буюу 80,5 хувиар санал дэмжигдлээ.

7.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 67 гишүүн буюу 81,7 хувиар санал дэмжигдлээ.

8.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 71 гишүүн буюу 86,6 хувиар санал дэмжигдлээ. Хуулийн төслүүдийг эцэслэн баталлаа. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийнхэнд талархал дэвшүүлье.

10.13 цаг

Хоёр.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд оръё. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Салдангийн Одонтуяа танилцуулна. Индэрт урьж байна.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Их Хурлын 24 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.13-д заасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулж, бизнес дэх байгаль орчны үнэлгээний ангиллын цөөрүүлж, төрийн оролцоог бууруулах зорилтыг үндэслэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр хүргүүлэн батлуулсан. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог ханган 3 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, саналыг тусгалаа. Мөн Монгол Улсын ЗГ-ын гишүүдээс санал авч тусгасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Сангийн яам, ХЗДХЯ-наас ЗГ-ын хуралдаанд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авч, ЗГ-ын 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэн батлуулахаар өргөн бариад байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь 1998 онд батлагдаж 2012 онд шинэчлэгдсэн найруулга хийгдсэн. Уг хуулийг хэрэгжүүлж ирсэн хугацаанд хуулийн зарим зүйл, заалт хоорондоо зөрчилдөх, зохицуулалтын хувьд давхцах, тодорхой бус хоёрдмол утга илэрхийлэх, төсөл хэрэгжүүлэгчид эдийн засгийн болоод цаг хугацааны хүндрэл учруулах зэрэг бэрхшээл гарах болсон тул асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг боловсронгуй болгох ажлын хүрээнд холбогдох судалгааг хийж, эдийн засаг, хөгжлийн хувьд харилцан адилгүй боловч байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийх эрх зүйн ижил түвшний 5 улс, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг үйл ажиллагаандаа ашигладаг 5 Олон улсын байгууллагын туршлагыг судлан, харьцуулсан шинжилгээ хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр гарсан нөхцөл байдлыг хянан үзээд зарим шаардлага тодорхойгүй, бичиг баримтын бүрдлийн ангилал ойлгомжгүй, давхацсан шинжтэй, үүрэг хариуцлагын зохицуулалт тусгагдаагүйн улмаас хууль хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлийг арилгах үүднээс зарим хэсэг заалтыг шинээр нэмэх, зарим хэсэг заалтыг өөрчлөн найруулах зэргээр Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийг боловсруулж, эх бичвэрт 19 хэсэг, 6 заалтыг нэмж тусган, 12 хэсэг, 3 заалтыг өөрчлөн найруулж, нийт хуулийн 48 заалтыг өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар, 1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилт сайжирч, төсөл хэрэгжүүлэгч, хөрөнгө оруулагч нарт учирч байсан цаг хугацаа алдах, бичиг баримтын бүрдэл хангах, хүлээх зэрэг асуудлаас болж төслийн хэрэгжилт гацах, санхүүгийн алдагдал хүлээх зэрэг

асуудлыг цогцоор нь шийдэх эрх зүйн орчин бүрдэх юм. 2. Асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгаль орчны үнэлгээтэй холбоотой төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэх, цахим хэлбэрээр ажиллах, мэргэшсэн мэргэжилтэн ажиллуулах, ангиллыг сайжруулах замаар төвлөрлийг сааруулах, оролцогч талуудын ажлын уялдаа холбоо сайжрах нөхцөл бүрдэх юм. 3. Байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээний шинэчилсэн ангиллаар нийт төслийн 36 хувь нь ангилал буурч, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт хийлгэх болон шалгах хуудсаар бүртгүүлэх боломжтой болно. Мөн аймаг, нийслэлийн түвшинд хийгдэж байгаа байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийн 30 хувь нь шалгах хуудсаар бүртгүүлж үнэлгээ шаардахгүй болох юм. 4. Байгаль орчны үнэлгээний цахим шилжилт болон мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай нийцүүлнэ. 5. Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний мэдэх эрхийг хангахтай холбоотой зохицуулалтууд тусгагдсан юм.

Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсан баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Хуулийн төслийн талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Уянга: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 3Г-аас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг БОХХАА-н байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хууль санаачлагч байгаль орчныг хамгаалах, иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын шаардлагад нийцүүлж, үнэлгээ хийх үе шатад төрийн оролцоог бууруулах, төвлөрлийг сааруулах, холбогдох хууль тогтоомж, хөгжлийн бодлоготой уялдуулах зорилгоор уг хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөлд тусгагдсан нэмэлт, өөрчлөлтүүд нь тухайн зохицуулалтыг боловсронгуй болгосон зарим нэмэлт үүрэг нь одоо мөрдөгдөж байгаа хуулийн зохицуулалтын зардлын хүрээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлж болохоор байх тул хууль батлагдсанаар төсөвт ачаалал нэмэгдэхгүй, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд аливаа нэмэлт зардал гарахгүй байхаар байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн ангилал, босго үзүүлэлт, шалгуурыг тодорхой болгох, орон нутагт хэрэгжүүлэх төслийн мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй хүргэх, иргэд, ТББ болон мэргэжлийн байгууллагын

саналыг тусгах, байгаль орчны үнэлгээний тайлангийн баталгаажуулалтыг мэргэжлийн зөвлөл хариуцах, худал тайлагнасан тохиолдолд хариуцлагын тогтолцоог тодорхой болгох, байгаль орчны үнэлгээнээс гадна нийгмийн үнэлгээ хийх асуудлыг төсөлд тусгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдийн нийтийн хурлын саналыг авахгүй байхаар тусгасан нь Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдөж байгааг анхаарах, нутгийн иргэдийн санал авахгүйгээр байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийх боломжгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга өргөн мэдүүлсэн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа боловч нэмэлт, өөрчлөлтийн төслийн зохицуулалт дутуу, тухайн орон нутагт хэрэгжүүлэх төслийг зэрэглэлд ангилан тогтоохдоо журмаар зохицуулахаар байгаа нь хуульд нийцэж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хуулийн төсөлд туссан байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг 3 зэрэглэл тогтоосныг тодорхой болгох, ангиллаас шалтгаалж тухайн үнэлгээнд нэмэлт тодотгол хийхийг шаардахгүй байгаа нь төсөл хэрэгжүүлэгчийн менежментийн төлөвлөгөөг жил бүр дүгнэж байх заалттай уялдаж байгаа эсэх, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх заалтыг өөрчлөх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд төслийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэлийг авахаар заасныг төсөлд иргэдийн саналыг тусгахаар өөрчилж байгаа нь бодит байдалд нийцэж байгаа эсэх, нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар орон нутагт хэлэлцүүлэг явуулах эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэгж гэж аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороог хэлнэ гэж, мөн тус хуульд аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороо нь нийтийн эрх зүйн этгээд байна гээд тодорхой заагаад өгчихсөн атал хуулийн төсөлд багийн иргэдийн нийтийн хурлаас санал авахгүйгээр төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн саналыг авахаар тусгасан байгаа нь хуулийн зөрчилтэй асуудал байгааг анхаарах, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд тусгай хамгаалалттай газар нутагт ашигт малтмал хайх, олборлохыг хориглосон атал хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт Тусгай хамгаалалтын захиргааны даргын саналыг үндэслэн тусгай хамгаалалттай газар нутагт ашигт малтмал хайх, олборлох боломж нээгдэж байгаа эсэх, төсөл санаачлагч хуулийг төслийг татаж аван, холбогдох заалтуудыг сайжруулан, дахин өргөн мэдүүлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар байгаль орчинд нөлөөлөх байдлын зэрэглэлээр төслийг ангилж байгааг дэмжиж байгаагаа илэрхийлж, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн боловсруулж байгаа төсөлтэй танилцсан эсэх талаар асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар төслийн хэд хэдэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн асуудал байх тул хууль санаачлагч төслөө татаж авах, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан Үндсэн хуульд заасан Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэсэн заалттай зөрчилдсөн хуулийн төсөл оруулж ирснийг дэмжихгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга хуулийн төслийн үзэл баримтлалаас харахад нэлээдгүй дэвшилттэй санаанууд туссан боловч тодорхойгүй байгаа асуудлыг засаж сайжруулаад оруулж ирэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж

төслийн ангилал зэрэглэлээс хамааруулаад багийн Иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг авах асуудлыг тусгах тал дээр анхаарах, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр хуулийн төслийг хэлэлцүүлгийн явцад сайжруулах, төслийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн Иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэлийг авах заалт зайлшгүй байх шаардлагатай, Улсын Их Хурлын гишүүн С.Замира төсөл хэрэгжүүлэгч үнэлгээний мэргэжлийн байгууллага багийн Иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг хүлээж цаг хугацаа, эдийн засгийн алдагдалд орж, хөрөнгө оруулалтаа алдах эрсдэл үүсдэг тул өргөн мэдүүлсэн төслийг засаж, сайжруулаад явах боломжтой учраас хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн санал хэлсэн болно.

Байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 35,3 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих дэмжиж, төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр хүүхдийн баярыг тохиолдуулаад Улсын Их Хурлын урилгаар хүүхдүүдийн төлөөлөл парламентын хуралдааны танхим, Төрийн ордонтой танилцаж ирсэн байна. Энэ удаагийн Хүүхдийн баяр Монгол Улсад Хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой тохиож байгаагаараа онцлог. Манай парламентын хувьд хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоо, эрхийг хамгаалах, хууль тогтоомжийг сайжруулах чиглэлээр Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байгааг дүү нартаа дуулгахад таатай байна. Та бүхний оролцоо, дуу хоолой маш чухал байдаг.

Эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоох ирээдүйн эзэд болох хүүхдүүд та бүхэнд болон Монголынхоо нийт хүүхэд багачууддаа Улсын Их Хурлын нийт гишүүдийн өмнөөс болон хувиасаа хүүхдийн баярын мэндийг дэвшүүлж эрдэм номдоо шамддаг, хөгжил дэвшилд тэмүүлдэг, эх оронч, бүтээлч, ёс суртахуунтай иргэн болохын ерөөлийг өргөн дэвшүүлж байна. Монголын бүх хүүхэд, багачууд, эцэг, эхчүүддээ эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Сайхан баярлаарай.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Ганболдын Энхмөнх Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Сугарын Эрдэнэцэцэг Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Байгаль орчны нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Өлзийбаярын Мөнхбаяр Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын Орчны бохирдлын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Мягмарсүрэнгийн Энхмэнд хуульч, Ишгалдангийн Бямбахүү судлаач, доктор.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Нийт 15 гишүүний нэр ирсэн байна. Баярмагнайн Баярбаатар, уучлаарай. Батын Батбаатар. Энэ нөгөө суудлын дугаар уншигдаагүй байна. Ирээгүй байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууж.

Б.Бат-Эрдэнэ: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хүүхдийн баярын мэндийг бас дэвшүүлье. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл орж ирж байгаа. Харамсалтай байгаа. Орон нутгийн иргэдээс санал бараг аваагүй, байгаль орчиндоо амьдарч байгаа иргэдийн амьдрах нөхцөл байдалтай холбоотой асуудлаа ч бас бүрэн дүүрэн судалж шийдвэрлээгүй байдалтай орж ирж байгаа юм. Хэд хэдэн асуудлууд байгаа юм.

1 дүгээр асуудал ингээд зэрэглэл 1, 2, 3 гээд хуваачихсан. Энэ зэрэглэлүүдийнх нь томъёолол нь байхгүй. 7.9 байгаль, төслийг байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзан дараах байдлаар ангилна гээд 7.9.1 зэрэглэл 1, 7.9.2 зэрэглэл 2, 7.9.3 зэрэглэл 3 гээд л ангилчихсан. Ямар ч томъёолол байхгүй. Зэрэглэл 1 нь ямар газар нутаг, ямар цар хүрээнд яах юм бэ гэдэг нь тодорхойгүй. Яаж шийдвэрлэх нь ойлгомжгүй байдалтай 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал зэрэглэл 1, 2, 3 гэж ангилчихаад эндээ нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийх болон тодорхой хэмжээний ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээтэй холбоотой асуудлуудыг аминдаа заах гэж оролдсон байгаад байгаа юм. Гэтэл менежментийн төлөвлөгөөгөө мартчихсан. Менежментийн төлөвлөгөө чинь жил тутам үйл ажиллагаа явуулж байгаа хамгийн чухал нь. Гэхдээ нэгэнт ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээг ААН-үүддээ ээлтэй, урт хугацаанд байлгая гэж оруулж ирж байгаа бол менежментийн төлөвлөгөөгөө ч гэсэн тэр хэлбэр лүүгээ оруулж өгөх ёстой. Тэр заалтаа ерөөсөө хөндөөгүй. Өөрөөр хэлбэл уул уурхайн компаниуд өнөөдөр ажил эрхэлье, аялал жуулчлалын компаниуд ажил эрхэлье, дэд бүтэц, барилга байшинтай холбоотой үйл ажиллагаа явуулъя гэвэл энэ менежментийн төлөвлөгөөгөөр жил тутамдаа тодорхой хэмжээнд байгаль орчинд нөлөөлөх зардал, хөрөнгө мөнгөний асуудлуудыг шийдвэрлэж гарч байгаа юм. Гэтэл энэ дээрээ хөндөөгүй орхичихсон, жил болгон батална. Хэрвээ тэр батлагдахгүй бол тухайн компанийн үйл ажиллагаа, тухайн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа явахгүй ийм сөргөлдөөнтэй заалтууд энэ дотор байгаа юм.

Дээрээс нь олон улсын банкны баталгаа гэдгийг анх бид minning week-р оруулж өгөөд, уул уурхайн компани бусад компаниуд дэмжиж байсан. Яахаараа компанийн хөрөнгийг, мөнгөн хөрөнгийг үйл ажиллагаа явуулах зардалд нь тусгуулахгүйгээр барьцаа хөрөнгөөр авч үлдээд байдаг юм бэ? Банкны баталгаа гэж байгаа шүү дээ ялгаа байхгүй. Хэрвээ ямарваа нэг эрсдэл үүсвэл банкны баталгаагаар хангах үүрэг нь байдаг. Гэтэл энэ харилцааг тэр чигт нь орхичхож байгаа юм. Байгаль орчны яам байгаль орчинд нөлөөлөх Байдлын үнэлгээний тухай хуулиар төсөв бүрдүүлэх үүрэг хүлээхгүй шүү дээ. Яагаад өнөөдөр заавал ААН-үүд өөрсдөө бэлэн мөнгөө, мөнгөн хөрөнгөө эргэлдүүлээд, үйл ажиллагаагаа явуулаад, эдийн засгийн эргэлтээ бий болгож байх ёстой байтал барьцаанд авч үлдээд байгаа юм бэ гэдэгтэй холбоотой асуудал байгаад байгаа юм. Тэгээд энийгээ шийдээгүй.

Уул нь энэ хуулиар илүү тодорхой л болгож өгөх ёстой. Өнөөдөр төр болон иргэний хооронд олон зөрчилдөөнтэй асуудлууд бий. Энэ зөрчилдөөнийг шийдвэрлэж чадахгүйгээр оруулж ирж байгаа юм. Зүгээр нэг ганц, хоёр үг үсгийнх нь өөрчлөлтийг хийх хэлбэр дээр 10.4, 10.5. Яг орон нутагт амьдарч байгаа иргэд, энэ төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулаад санал авах ажлыг зохион байгуулна гээд оруулчихсан. Энийг нь нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан эсэх, үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ гээд заачихсан. Нөгөө сөргөлдөөнтэй байдал байхгүй, эцэслэн шийдвэрлэгдээгүй ийм л байгаа. Тэгэхээр энийг дэмжих боломжгүй гэж үзэж байгаа.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 10 цаг 30 минутаас хуралдааныг даргалав.

Х.Булгантуяа: Бат-Эрдэнэ гишүүн үг, асуулт асуугаагүй үг хэллээ. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Хуулийн төсөл боловсруулагчдаас 2 зүйлийг асуугаадахъя. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнээс гадна нийгмийн болоод соёлын нөлөөллийн үнэлгээг ер нь хийх талаар танай яамны хувьд ямар бодлого барьж байгаа вэ? Энэ дээр нэг тодорхой санал, тодорхой төлөвлөгөө байгаа юу гэдэг дээр нэг асуулт.

2 дахь нь ер нь аль ч төрлийн үнэлгээг хийсэн байсан иргэдийн оролцоог хэрхэн хангая гэж төлөвлөж байгаа вэ? Иргэдийн оролцоогоо та хэд маань юу гэж харж байгаа вэ? Ер нь Их Хурлын гишүүдээс голдуу багийн хурлын түвшинд энэ асуудлыг хэлэлцэх тухай Байнгын хороон дээр нэлээн яригдсан байна. Тэгэхээр та бүхний хариулт бас яг энэ дээр юу байдаг вэ гэсэн ийм 2 асуулт асууя.

Х.Булгантуяа: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Маш чухал асуулт хөндлөө. Ер нь өмнө нь энэ зөвхөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэж дандаа хийгддэг байсан. Өөрөөр хэлбэл амьтандаа, ургамалдаа ямар нөлөөтэй юм гээд байхаас тухайн бүсэд төсөл хэрэгжүүлбэл нөлөөллийн бүсэд орж байгаа иргэдэд энэ төсөл хэрхэн нөлөөтэй юм бэ гэдгийг ер нь төдийлөн бас хөнддөггүй байсан. Тэгэхээр манай энэ хуулийн төсөлд бол 3.1.6-д байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээнд нийгмийн нөлөөллийн үнэлгээг тусгах зохицуулалтыг бол нэмэлтээр оруулж өгсөн. Мөн хуулийн төслийн 7.7-д үнэлгээнийх нь журам, ангиллын агуулгад нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийхийг тусгасан байгаа. Ингэснээрээ бид бас энэ ОУБ-ын шаардлага стандарттай нийцэх нөхцөлийг бүрдүүлж байгаа.

Жишээлэхэд саяхан бид Эгийн голын усан цахилгаан станцын төслийнхөнтэй танилцахаар тухайн баг дээр очсон. Энэ багийн иргэдийн нийгмийн нөлөөллийн маш том асуудлууд байгаа. Энийг Ерөнхий сайд газар дээр нь өөрөө очоод, ер нь энд нийгмийн энэ нөлөөлөл маш чухал юм байна, энэ багийн иргэдийн тэр жишиг баг болгоё, энэ яах аргагүй нөлөөллийн бүсэд орсноороо олон жил бас хохироод явсан юм байна гэдгийг гаргаад, ингээд энэ дээр жишиг багийн төслийг хийж байгаа. Тэгэхээр ер нь энэ ОУБ-ын шинжээчид ажиллахдаа хамгийн гол өөрчлөлт нь юу байсан бэ гэхээр нийгмийн нөлөөллийн үнэлгээг сайн энэ хуульд тусгаж өгвөл энэ

бол олон улсын стандартад нийцэх юм байна. Янз бүрийн гаднын хөрөнгө оруулалт орж ирэхэд ч гэсэн яг энэ асуудал их чухал юм гэж үзсэн учраас энийг хийсэн байгаа.

Ер нь зүгээр энэ хуулийн хамгийн чухал ач холбогдол юу юм бэ гэхээр нэг төсөл хэрэгжүүлэгч үсчин ч бай, нэг барилгын материалын жижиг дэлгүүр ч бай, том уул уурхайн компани ч бай бүгдээрээ яг ижил шаардлага тавьдаг учраас энэ төслүүд маш хүндрэл учруулдаг. Тэгээд нийт үнэлгээ хийлгэх хугацаа 152 хоног. Тэгэхээр энэ 152 хоногийг хэрхэн буулгах вэ гэдэг дээр манай хуульд 3 зэрэглэл оруулж өгсөн. 3 дугаар зэрэглэл зайлшгүй энд ийм зөвшөөрөл шаардаад байхгүй энэ барилгын материал, үсчин ч гэдэг юм уу, жижиг лабораториудыг 3 дугаар зэрэглэл. 2 дугаар зэрэглэл нь аймаг, орон нутаг нь өөрөө шийдээд хяналтаа тавих. 1 дүгээр зэрэглэл нь яах аргагүй том, том уул уурхайн төслүүд, химийн том байгууламжууд гэдэг ч юм уу ийм зүйлээр ангилж өгсөн ийм чухал зүйл болсон юм. Тэгэхээр энэ хууль батлагдсанаар нэг.../минут дуусав/

Х.Булгантуяа: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Дахиад л хэлье дээ. Бизнес явах ёстой, үсчин, эмийн сангийн зөвшөөрлийг нэг их багийн иргэдийн хурлаар хэлэлцүүлээд байх шаардлагагүй. Цахимаар авч болно, авч болно. Тэгвэл нөгөө заалт нь яах юм бэ, Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдраад өөрийнхөө эрүүл орчинд амьдрах эрхийг хамгаалуулах ёстой гэсэн Үндсэн хуулийн энэ заалт буруу юу, буруу юм уу? Нөлөөллийн бүсэд өнөөдөр хар даа эцэг өвгөдөөсөө хойш амьдраад, дасаад идээшээд ирчихсэн нутгийг нь аваад бид уул уурхай явуулах гэж байгаа юм. Тэр иргэнээс асуухгүй юу, хөөгөөд явуулах уу? Тэгчхээд энийгээ бизнесээр тайлбарлах юм уу? Би байгаль орчныхноос асууя. Монгол Улсын Үндсэн хуульд Монгол улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах тэр эрхээ хамгаалуулах эрхтэй гэдэг буруу юу? Яагаад багийн иргэдээс асуудаггүй юм бэ? Та нарыг өөрсдийн чинь байранд амьдарч байхад орж ирээд байрны чинь хажууд том трактор авчирч ухаад, та наад байраа өгөөд яв, танаас асуухгүй гэвэл та өөрсдөө тэрэнд тухтай сайхан амьдарч чадах уу?

Олон улсын сайн туршлагуудыг зөндөө авч үзлээ. Хүмүүсээс асуулаа. Юу гэж байна гээч хэзээ ч уул уурхайн төсөл явахдаа орон нутгийн иргэдээс асуухгүйгээр, тэдний үгийг сонсохгүйгээр явдаггүй юм. Энэ мөнхийн зөрчил дагуулдаг. Цаашдаа иргэний дайны хөл рүү татан оруулдаг юм гэж хэлж байна. Тэгэхээр багийн иргэдийг үл тоосон энэ заалтаа авч хаяж чадах уу та нар? Энийгээ засаж залруулж чадах уу? 2 асуулт.

Х.Булгантуяа: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Энэ маш чухал асуудал яах аргагүй мөн. Энэ манай хуульд яг саяын асуусан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга байгаа. 6.2 нэг нь энэ иргэдийн мэдэх эрхтэй холбоотой маш чухал заалт байдаг. Манай дээр нийт төслийн 14.1.5, 18.6, 18.7, 18.8 гэсэн энэ 4 заалтаар яг таны саяын асуусан асуултыг зохицуулж өгсөн байгаа. Гол зохицуулалт нь тухайн төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын явц, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг төрийн байгууллага, Засаг дарга төсөл хэрэгжүүлэх мэдээллийг гаргуулж авах эрхийг нарийвчлан зааж өгсөн. Мөн цахим мэдээллийн системээр энэ мэдээллийг нийтэд ил тод болгохтой холбоотой асуудлууд туссан.

Баг, хорооны Иргэдийн нийтийн хурлын асуудал бол бид энийг нэг ойлгомжтой болгох ёстой юм. Хуучин хуулиар Иргэдийн нийтийн хурал нь жилдээ 3 удаа хуралдах ийм зохицуулалттай байсан юм. Гэтэл 20 оны шинэчилсэн найруулгаар энэ 3 удаа гэдгийг аваад хаячихсан чинь одоо хэзээ хуралдах нь тодорхойгүй болчихсон. Тэгэхээр манай дээр ирж байгаа энэ жишээлэхэд яаман дээр ирж байгаа гомдол бол манайх төслөө ингээд багийн Иргэдийн нийтийн хуралд танилцуулах гээд 6 сар хуралдсангүй, бүүр 3 жил хуралдсангүй гэдэг ийм зүйл байдаг учраас энийг шууд тодорхой болгож өгөх ёстой. Тэгээд би бол хэлэлцэх эсэхийг дэмжсэний дараа ажлын хэсэг яг энэ 1 дүгээр ангилалд орж байгаа зүйлийг яг яаж нарийвчлах вэ гэдгээ манай гишүүд бас нарийвчлаад энэ дээр нэмээд саналаа оруулах боломжтой байгаа юм. Одоо ийм ойлгомжгүй. Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчид яадаг вэ гэхээр ерөөсөө ойлгомжгүй, тэгээд л 6 сар хүлээх юм уу, жил хүлээх юм уу, 3 жил хүлээх юм уу гэдэг нь ийм тодорхой байгаа юм.

Иргэдийн тэр мэдэх эрхийг харин чиг өргөн хүрээтэй оруулж байгаа. Хуучин жишээлэхэд нэг Чингэлтэй дүүргийн иргэд гээд аваад үзэхэд 855 өрхөөс 42 өрх ирж байж энэ Иргэдийн нийтийн хурал хуралдаж байсан бол одоо энэ төсөлд хамрагдах иргэдийг оролцуулж санал авна гэдэг нь өөрөө их өргөн хүрээгээр орж байгаа юм. Тэгэхээр 14 дахин нэмэгдэж гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл энэ иргэдийн энэ төсөлтэй танилцах асуудал маш чухлаар ингээд орчихсон байгаа. Энийг хэлэлцүүлэх явцад нэлээд нарийсгаад оруулахад бололцоотой гэж харж байгаа. Хамгийн гол нь бид энэ 1, 2, 3 дугаар зэрэглэлээ бүгдийг нь нэг саванд хийчихээд л энэ дээр маш их цаг алддаг.../минут дуусав/

Х.Булгантуяа: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя. Энэ хуулийн үзэл баримтлал хэсэгт байна шүү дээ иргэний мэдэх эрхийг хангасан заалт орсон байгаа, сайт дээр тавьчихна, танай нутагт ийм юм хийж байгаа ингээд тавьчихна ок. Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ, хамгаалах байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн гэсэн үүргийн хэсэг орсон байгаа. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, түүнийгээ хамгаалуулах эрх нь байхгүй, иргэний оролцоог хасчихсан гишүүдээ. Иргэний оролцоо энэ хууль дээр байхгүй үзэл баримтлал нь зөрчигдчихсөн. Тийм учраас би Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн гээд байгаа юм. 18 дугаар зүйлийн энэ чинь иргэний оролцоотой хэсэг байхгүй юу 18.4, 18.5-д та нар энийг журмаар нөгөө ангиллаар зохицуулна гэж байгаа шүү дээ иргэний оролцоог, ангилал дээр чинь байхгүй. Тэрийг ЗГ тогтооно, одоо зүгээр дарга нартай л ярина. Тэгээд Үндсэн хуулийн үзэл баримтлалын энэ хэсгийг зөрчсөн байна гэхээр зөрчөөгүй байна гээд байхаар дахиад ажлын хэсэг дээр.../минут дуусав/

Х.Булгантуяа: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр би сая таны хэлсэн энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 6.2-ыг бид нийт 4 заалтаар оруулсан. Хууль, ажлын хэсэг ажиллах явцад энэ хуулиуд дээр бас нэлээд нарийвчилж оруулах боломжтой. Зүгээр ер нь энэ дээр ямар асуудал үүсээд байдаг вэ гэхээр ер нь аливаа хуулийг бид бас энэ үнэлгээ хийхдээ аль болохоор арын хаалгагүй, аль болохоор авлигагүй, хүнд сурталгүй байгуулах нь их чухал байгаа юм. Яагаад гэхээр зарим багийн дарга сайн ажилладаг багийн дарга нар байна. Үнэхээр иргэдээ цуглуулаад саналыг нь аваад, энэ төслийнхөнтэйгөө хамтарч ажиллаад ингээд иргэдийнхээ төлөө ажиллаж байгаа байна. Зарим нь ерөөсөө хуралдуулдаггүй, шантаажлаад суучихдаг ийм

багийн дарга байна. Маш их ирсэн гомдол байна. Амарбаясгалан дарга ч хүртэл бичгээр ирчихсэн гомдлууд байна л даа. 6 сар хуралдахгүй байна, 3 жил хуралдахгүй байна. Тэгээд л юу ярьдаг вэ гэхээр зарим хүмүүс миний хүүхдийн сургалтын төлбөрийг төл эсвэл өөр янз янзын.../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж тодруулъя Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Багийн иргэдийн хурал хуралдах эсэх нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт хийж байгаа яг энэ танхимд одоо ярих хүчин зүйл биш. Наадах чинь байна шүү дээ аймгийн дарга, сумын Засаг дарга, багийн Засаг дарга тэд нар өөрсдөө яриад хурлаа хийгээд, ажлаа хийчих л юм байхгүй юу даа. Өмнө нь байсан ганц нэг муу туршлагыг хараад багийн хурал ерөөсөө хуралддаггүй юм, тийм учраас багийн иргэд ямар газар амьдрах нь хамаагүй, тэд нараас асуухгүй, шууд ингээд оруулна гэж яриад байгаа чинь таалагдахгүй байгаа байхгүй юу. Энэ чинь буруу шүү дээ тийм биз дээ? Энд багийн хурлыг бид хуралдуулдаггүй юм гээд зүгээр тэнд амьдарч байгаа иргэний оролцоог, иргэний амьдрах орчныг эрүүл орчинд амьдрах эрх рүү нь халдаж болохгүй. Би уг нь энийг хэлэлцэх дээр нь дэмжээд, цаашаа ажлын хэсэг дээр нь.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс нэмж хариулъя. 4 номерын микрофон дээр албан тушаалаа, нэрээ хэлээд. Микрофон нь асчихсан байна.

Г.Энхмөнх: Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Энхмөнх. Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Таны асуулт асуусан Үндсэн хуультай холбоотой иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрахтай холбоотой бүхий асуудал нэн чухал.../үг тасрав/

Х.Булгантуяа: Асуулт асуусан байхад асуултаа сонсьё. Пүрэвдорж гишүүнээ.

Г.Энхмөнх: Нэн чухал асуудал, энэ дээр яг энэ эрүүл, аюулгүй орчинд нийгэм талаасаа нөлөөлж байгаа асуудлыг нийгмийн нөлөөллийн үнэлгээгээр тогтоож өгсөн. Энэ дээр нийгмийн нөлөөллийн үнэлгээг бий болгосноороо гомдлын механизм чиглэсэн бүлэг рүү чиглэсэн гэдэг юм уу ийм олон нийгмийн нөлөөлөл, эрүүл, аюулгүй орчинтой амьдрахтай холбоотой асуудлыг тусгаад явах бүрэн боломжтой гэж харж байгаа. Нөгөө талаасаа хуулийн төсөл дээр 10.5, 10.4 дээр иргэдээс санал авахтай холбоотой зохицуулалт, мөн энэ иргэдээс гарсан саналыг харгалзан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалт мөн туссан байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбын Сэддорж.

Р.Сэддорж: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчны зөвлөл болон төсөл хэрэгжих газар нутгийн багийн Иргэдийн нийтийн хуралд танилцуулдаг байх нь зайлшгүй шаардлагатай. Энэ хууль дээр 7.14-д 10 хоног Засаг дарга 10 хоногт хариу өгөхгүй бол зөвшөөрсөнд тооцно гэсэн ийм заалт орж байгаа юм байна. Тэгэхээр энэ бол болохгүй. Ийм учраас энэ хуулийг энэ удаа дэмжээд, хэлэлцэх эсэхийг нь дэмжээд ажлын хэсэг гаргаад ажиллаж болох уу Одонтуяа сайдаа? Ажлын хэсэг гаргаад, тэгээд тэн дээрээ ингээд гишүүд оролцоод, бүс болгоноос гишүүд оролцоод ингээд явбал цаашдаа их зүгээр болов уу гэж бодож байна. Тэгээд энэ дээр оруулж ирсэн төсөлд чинь өөрчлөлт орж болно

тийм ээ? Тэгээд энэ дээр нэг хариулт хэлээдхээч: Ажлын хэсэг гаргаад хэдий хугацаанд ажиллаж болох вэ? Энийг ултай суурьтай ажиллах хэрэгтэй байна, судлах хэрэгтэй байна, хэлэлцүүлэг явуулах хэрэгтэй байна. Тэгээд энэ дээр хариулт авъя.

Х.Булгантуяа: Их Хурлын гишүүдээс ер нь нэлээдгүй саналууд байна гэж байгаа учраас Ариунхур дарга бэлдэж байгаарай асуултад хариулахад. Хэр удаан ажиллаж болох вэ, хэр хэмжээнд өөрчлөлт оруулж болох вэ? Ажлын хэсэг хэрвээ гараад Улсын Их Хурлаас ажиллавал Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс гэж байна. Эхлээд Одонтуяа сайд хариулчхаад, тэгээд дараа нь хэн Ариунхур дарга хариулаадхаач.

С.Одонтуяа: Сэддорж гишүүнд баярлалаа, энийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд ажлын хэсэг ажиллая гэдэг дээр. Тэгэхээр өмнө нь жишээлэхэд би ЭМД-ын хуулийн ажлын хэсэгт ажиллаж байхад бас нэг бараг 2-оос 3 жил ажиллаж байсан, Гэр бүлийн тухай хууль дээр ч гэсэн бас 2 жил энэ тэр гээд ажиллаж байсан. Энэ дээр юу гэдэг юм заавал тэдэн сарын дотор хийх ёстой гэсэн юм бол ажлын хэсэгт байхгүй байх. Тэгэхээр манай гишүүд энэ асуудал дээр өөрсдөө ажлын хэсэг, даргаа сонгоод, ажлын хэсэг, дэд хэсэгтэйгээ хамтраад ажиллах ийм боломжтой.

Сэддорж гишүүний 10 хоног гэдэг хэтэрхий бага байна гэдэг дээр болно. Энийг өөрчлөөд хуучин хуульдаа 30 хоног байсан. Тэгэхээр яах вэ ер нь энэ хугацааг бид бас багасгая гэдэг үүднээс л 10 хоног гээд оруулчихсан. Тэгэхээр энэ 10 хоногийг нэмэгдүүлээд, өөр хоногийг бид ажлын хэсэг дээр Их Хурал чуулганаараа яриад шийдэж болох байх. Хамгийн гол нь энэ бол бас зөвхөн уул уурхайн компаниудтай холбоотой хууль биш юм. Би түрүүн хэлсэн бүх л бизнес эрхэлдэг хүмүүстэй холбоотой хууль учраас хурдхан шиг тэр ангиллыг нь гаргаад, яах аргагүй тэр байгаль орчинд хүчтэй нөлөөлөх гээд байгаа хэсэг дээр нь ажилласан шиг ажиллаад, шаардлагагүй юмнуудыг зүгээр цахимаар мэдээлээд л зөвшөөрөл шаардахгүй явуулчихдаг болъё гэж байгаа юм. Яагаад гэхлээр ер нь манай улсад энэ аль олон гарын үсэг, энэ хүнд суртал бас их байдаг гэж манай бизнесийнхнээс байнга манай яаман дээр гомдол ирдэг. Ялангуяа энэ Байгаль орчны үнэлгээний хууль дээр дандаа танай яам энэ бизнесийг гацаадаг гэдэг. Гэтэл манай яаман дээр 700-аас 800 ийм үнэлгээ хийх хүсэлт ирдэг. Энийг 8 хүн хурдан шуурхай хийх гэхээр алдаа, оноо гардаг хүндрэлтэй зүйлүүд байгаа. Тэгэхээр энэ бол аль болохоор бас нэг ангилаад хурдан шуурхай хэсэгт нь хурдан шуурхай үйлчилье, аль болохоор хурдан бид бас цахимжилт руу шилжиж үед нь шилжүүлье гэсэн ийм зүйл байгаа.

Багийн Иргэдийн нийтийн хурал бол гол нь тэр хугацааг бас нөгөө хуулиар зааж өгөхгүй болохоор хугацаагүй болгочихсон, Ажлын албагүй болгочихсон. Тэгэхээр багийн Иргэдийн нийтийн хурлын дарга нь өөрөө энэ олон хүнээ цуглуулаад хуралдуулаад ингэхэд хүндрэлтэй байдаг юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ хууль, бусад хуульдаа ч гэсэн бид бас өөрчлөлт оруулаад ингээд явах бүрэн боломжтой байгаа. Тэгээд би гишүүдийг кнопдоо хүрэхгүйгээр энэ хуулийг дэмжээд, Их Хуралдаа ажлын хэсэг гаргаад хэдэн жил ч бас ажилласан болно л гэж үзэж байгаа. Тэгээд нэмээд шинэ дэгээр ямар болсон юм тайлбар л хэлчихгүй юу.

Х.Булгантуяа: Тэгье. Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ариунхур. Хэр удаан хэлэлцэх вэ, ямар түвшинд өөрчлөлт хийж болох вэ Дэгийн тухай хуулийн дагуу? Ариунхур даргын микрофоныг өгье.

Ч.Ариунхур: Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн дагуу төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэсний дараа төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх Ажлын хэсэг байгуулахаар байгаа. Ажлын хэсэг ажиллах хугацаа, Байнгын хороо төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх тусгайлсан хугацаа байхгүй. Энд яг хуулиар батлах хугацааг заагаагүй төсөл. Хэлэлцэх хүрээ хязгаарын тухайд Дэгийн чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлээр нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хувьд хууль санаачлагчийн яг өргөн барьсан хүрээнд төслийн зүйл, заалт өргөн барьсан төслийн зүйл, заалт хэсгийн хүрээнд яг нэмэлт, өөрчлөлтийн санал гаргах боломжтой байгаа. Тэр хүрээнээс хязгаар хальсан санал, дүгнэлт, мөн тэр төсөлд тусгагдаагүй бусад төсөл өргөн мэдүүлэхтэй холбоотой тийм өөрчлөлт оруулахыг хориглож байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж горимын санал гаргах үг хэлэх, микрофоныг нь өгье.

Б.Пүрэвдорж: Зарим нэгэн гишүүдэд тодорхой ойлголтыг хүргэх нь зүйтэй гэж бодож байна. 2017 оноос хойш 5 удаагийн өөрчлөлтөөр, дээрээс нь Төсвийн тухай хуулийг батлахад хэд хэдэн өөрчлөлтөөр нийтдээ 8 удаагийн өөрчлөлтөөр, гол нь 2020 оны 12 сарын 6-ны өдөр батлагдсан нутгийн өөрөө, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний нэгж, түүний удирдлагын тухай хуулиар энэ нутгийн өөрөө удирдах ёсонд маш их хүчтэй халдсан. Энүүгээр урьд нь багийн иргэд өөрийнхөө нутаг дэвсгэр дээр уул уурхайн хайгуулын болон ашиглалтын арга хэмжээ явуулахад багийн иргэдийн 50 хувийг цуглуулаад, 50-аас дээш хувийг цуглуулаад 50-аас дээш хувийн саналаар тухайн баг дээр уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн тохиолдолд зөвшөөрлийг нь олгодог байсан. Тэгээд энийг бүгдийг нь байхгүй болгосон. Өнөөдөр багийн иргэд ерөөсөө энэ уул уурхайн лиценз авахад ямарваа нэгэн нөлөөгүй болсон. Нутгийн иргэд тэндээ өөрийнхөө мянга мянган жилийн туршид хадгалж ирсэн тэр өвөг дээдсийнхээ нутаг дээр сайхан амьдрах, мал ахуйгаа адгуулаад амьдрах тэр боломжийг нь хааж байсан юм. Энэ маш том ноцтой хохирлыг Монголын ард түмэнд авчирсан.

Тэгээд зарим нэгэн гишүүд бас өөрсдөө энэ хууль яагаад ингэж батлагдсаныг нь мэдэхгүйгээр энэ хууль нь өөрөөр хэлбэл тэр нутгийн өөрөө удирдах ёсонд халдсан тэр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг зөрчихгүйгээр орж ирэх байхгүй юу даа. Тийм учраас зарим нэгэн жоохон асуудал байж магадгүй түүнийгээ хэлэлцүүлгийн явцад засах ёстой. Хамгийн гол нь энэ нутгийн өөрөө удирдах ёсонд багийн иргэдийн эрхэд 7 удаагийн хуулийн өөрчлөлтөөр нийтдээ 20 гаруй эрхийг нь авч тэдний эрхийг юу ч үгүй болгосон ийм л хуулийн өөрчлөлтүүдийг өнгөрсөн 8 жилийн туршид хийсэн шүү гэдгийг бас энэ зарим гишүүдэд энэ парламентад сууж, энэ хуулиудыг бүгд дээр нь эсэргүүцэж байж, эсэргүүцэж тэр багийн иргэдийн төлөө тэмцэж байсан хүнийхээ хувьд би хариуцлагатайгаа хэлье гэж бодож байна.

Х.Булгантуяа: Пүрэвдорж гишүүн та уг нь горимын санал гаргана гэсэн шүү дээ. Энэ чинь хэлэлцэх асуудалтай холбоотой үг хэлнэ гэж хэлээгүй шүү дээ. Улсын Их Хурлын дэд даргын хувьд Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулиа бүгдээрээ баримтлахгүй бол болохгүй. Ингээд л горимын санал гаргая гээд л хэлэлцэх асуудалтай холбоотой үг хэлээд байвал 126 гишүүн чинь барагдахгүй байлгүй дээ. Хэлэлцэх асуудалдаа орохгүй байх. Ингээд чиний, миний, танай үед, миний үед батлагдсан гээд ингээд байвал болохгүй байх л даа. Зүгээр Их Хурлын

гишүүдээс тэр өөрчлөлтөө хийгээд оруулаад ирэхгүй дээ л гэдэг санал хэлж байх шиг байна. Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар, Сэддорж гишүүн тодруулах уу?

Р.Сэддорж: Тэгвэл энэ багийн Иргэдийн хурлаас асууна гэдэг нь энэ төсөл дээр байгаа ийм учраас өөрчлөлт орж болох юм байна гэж ойлголоо зөв үү? Тэрийг нэг микрофон дээр хэлж өгөөч.

Тэгээд энэ байгаль орчны үнэлгээ хийлгэж байгаа энэ компани төсөл хэрэгжүүлэгч бол мөнгөө төлж хийлгэж байгаа. Тэгэхээр тэр мөнгө авч үнэлгээ хийж байгаа тэр нэг үнэлгээний компани бол тэр төсөл хэрэгжүүлэгчийнхээ талд талтай тийм шийдвэр гаргаж бас төлбөр тооцоогоо авдаг байх. Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлтийг маш чамбай, сайхан хийгээд, энэ өнгөрсөн хугацаанд тулгамдсан сөрөг асуудлуудыг энэ өөрчлөлтөөрөө жоохон ч гэсэн шийдээд явчихвал маш хэрэгтэй байна. Энэ бол нийт гишүүдийн зайлшгүй хамгийн ихээр анхаарах.../минут дуусав/

Х.Булгантуяа: Одонтуяа сайд хариулъя, микрофон дээр хэлүүлмээр байна гээд тэгсэн, хугацааг нь өөрчилж болох уу, үгүй юу гэдэг.

С.Одонтуяа: Тэгэхээр 1 дүгээрт сая бас яг Пүрэвдорж гишүүний хэлснээр энэ өнөөдрийн мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд бид энэ хуулиа оруулж ирэх гэж үзсэн байгаа. Тэгэхээр энэ багийн Иргэдийн нийтийн хурал нь ажлын албагүй болчихсон, жилдээ 3-аас 4 удаа хуралддаг байсан заалт нь байхгүй болчихсон. Тэгээд л хөөрхий багийн дарга гүйгээд л хүмүүсээ цуглуулах гэхээр би малаа хариулж байна, завгүй ийм, ийм гээд маш их асуудлууд гарч байгаа. Тэгэхээр энэнтэй холбоотой заалтуудыг бид бас бусад хуулийн өөрчлөлттэй ингээд хамтраад явах нь зөв байх. Тэр түрүүн Бат-Эрдэнэ гишүүн асуугаад байсан нөгөө 1, 2 энэ зэрэглэлүүдээ та нар ерөөсөө энэ дээр тодорхойлоогүй байна. Уг нь манай яамнаас нарийвчлаад оруулж ирсэн байсныг нь нөгөө бусад яамнууд санал авах хугацаанд эд нар нь бас хасагдчихсан ийм тал бий. Тэгэхээр Сэддорж гишүүний хэлдгээр энийг дэмжээд, ажлын хэсэг энэ дээр хэдэн ч.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар.

С.Ганбаатар: Би та бүхэнд хуулийн заалтыг уншиж өгье. Хуулийн төслийн 7.12-т зарим төсөлд байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэхийг шаардахгүй гэдэг үг орж ирсэн байгаа. Энэний үндэслэл нь гэсэн чинь төслийн үзэл баримтлалын 5А-н буюу хуудас 2-т байгаа 5А1-д төсөл хэрэгжүүлэхэд багийн нийтийн хурлын тэмдэглэл авахад нутаг дэвсгэрийн захиргаа болон Иргэдийн нийтийн хурлын гэсэн 2 нэгжээс санал авахад Иргэдийн нийтийн хурал нь жилдээ 1-ээс 2 хуралддаг учраас хугацаа их алддаг. Том их төсөл их хойшилж байна гэж байгаа юм. Иргэдийн нийтийн хурал нь хуралддаггүй учраас ерөөсөө эднээс хэзээ ч асуухгүй байя гэдэг энэ том тэнэглэл орж ирж байгаа нь Үндсэн хуулийн 6 дугаар заалт зүйлтэй эрх зүйн дүгнэлт гарсан уу, нийцэж байгаа юу? Энэ чинь Үндсэн хуулийн 6 дугаар зүйл дээр газрын хэвлийн баялаг гагцхүү гэж үг байгаа шүү дээ. Гагцхүү ард түмний мэдэлд. Тэр мэдэлд нь байгаа хүмүүсээс асуухгүйгээр 7.12-т орж ирье гэж байна.

Дараагийн асуулт 7.13, 7.14 төслийн товч танилцуулга дээр ингэж заасан байгаа. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, ерөнхий үнэлгээг үндэслэн сум,

дүүргийн зөвхөн Засаг дарга орон нутагтаа төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэж байхаар зохицуулахаар байна гэж. Нөгөө авлигал аваад гэдийгээд байдаг сумын дарга нараасаа 100 хувь шууд шийдүүлчихье. Авлигалаа өгөөд хурдан шийдье гэсэн санаа юм уу? Ингэж болох уу? Энэ иргэдийн бүхий л эрх ашгийг ганцхан дүүрэг, сумын Засаг дарга төлөөлж хариуцаж болдог юм уу? Энэ нөгөө Үндсэн хуулийн 6 дугаар заалтаа тэгээд дагаж байгаа юм уу? Эрх зүйн дүгнэлт гарсан уу энэ дээр миний асуулт?

2-т нь Үндсэн хуулийн заалт 6 дугаар заалтын үндсэн баримтал, үндсэн үзэл санаа нь ямар нэгэн том төслийн тэр том ашиг, эдийн засгийн үр өгөөжөөс илүү иргэдийн эрх ашиг хамгийн чухал шүү гэж заасан байгаа шүү дээ. Тэгсэн тэрийгээ уландаа гишгээд, үндсэндээ зэрлэг капитализм руу бид чинь 30 жил гайхалтай гоё явж байгаа л даа. Зэрлэг капитализмаар хүн, байгаль 2 л хамгийн их хохирдог. Өөрийгөө өмгөөлөх чадваргүй хүн, байгаль 2-ыг өмгөөлөх гэж төр байдаг болохоос биш олигархуудад үйлчлэх гэж байдаггүй юм. Миний ахан дүүс арай л андуураад байна даа. Үндсэндээ төрийн шийдвэр гарахдаа энэ шийдвэрээс болж нөлөөлөгдөх, хохирох хүмүүстэй заавал хэлэлцэж, заавал ярилцаж, заавал шийдвэрт оролцуулах ёстой гэдэг зарчмаа алдагдсан байна. Үндсэндээ ард иргэдээс асуухгүй гэдэг бол үндсэндээ иргэний дайн шиг юм болно. Одоо хөдөө орон нутагт уул уурхайн компаниуд та нар очоод үз. Буутай цэргээр мануулж байгаа, зуудаг нохойгоор зуу зуугаар нь мануулж байгаа. Өнөөдөр ард иргэд амьжиргааныхаа төлөө тэр нарийн ширхэгтэй өвс чинь тэдний амьжиргаа, тэднийхээ төлөө тэмцэж байгаа. Тэднийг нугачин дарах гэж байгаль орчинд нарийвчилсан үнэлгээг та нараас авахгүй, ярихгүй, үгүй ээ бүүр гоё орж ирсэн байгаа юм.

Төслийн 7.14-д сум, дүүргийн Засаг дарга төсөл хэрэгжүүлэгчийн хүсэлтийг хуудас 19-д байгаа шүү 7.13-д заасан хүлээн авч ажлын 10 хоногт багтаан хариу өгөх бөгөөд энэ хугацаанд шийдвэрлээгүй тохиолдолд хариу өгсөнд тооцно. 10 хоногоо тоолуур тооцоод сууж байх нь байна шүү дээ. Нөгөө хүмүүс хариу өгөхгүй л дээ, хуралддаггүй улсууд чинь. Тэгэхлээр та нар яах вэ энэ 10 хоногт хариу өглөө гялай, шууд ухаж болно гэсэн хариу болж байна шүү дээ. Миний асуулт зөв үү? Та нар энэ дээр хариулж өг дөө. Хүмүүсийг ингэж дээрэмдэж болох уу? Тэгэхлээр миний ахан дүүсээ төр өөрийгөө өмгөөлөх чадваргүй энэ байгаль, хүн 2-т арай хатуу хандаж байна. Үндсэндээ өнөөдөр 7800 лиценз байгаа Монголд.

Х.Булгантуяа: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Яах вэ дээ юмыг тэгээд ингээд дандаа ингээд ард түмний нэр бариад байх ч бас хэрэггүй л дээ. Тэнд хэдэн мянган баялаг бүтээгчид байна. Хөөрхий нэг барилгын материал оруулж ирэх гээд өнөөдөр 152 хоног хүлээж байгаа хүн байна. Нэг үсчин ажиллуулах гээд, эсвэл нэг уламжлалын эмнэлэг, нэг лаборатори байгуулах гээд энэ хүмүүс чинь үнэхээр цөхөрчихсөн байна шүү. Монгол Улсад бизнес хийх ямар хүндрэлтэй байгааг та ойлгож байгаа. Таны саяын уншсан заалт чинь тэр 1 дүгээр зэрэглэлд хамаарах орохгүй хүмүүст огт хамаарахгүй заалт байхгүй юу. Та хууль дээр харж л байгаа шүү дээ. Би түрүүн зөндөө тайлбарласан. Поппрох амархан шүү дээ, сайхан шүү дээ энэ рейтинг өсөөд явна. Гэхдээ энэ баялаг бүтээгч, татвар төлөгчдийг чинь бид дэмжиж байж, энэ хүнд суртлын арилгаж байж, тэр шат шатны авлигыг арилгаж байж улс орон чинь хөгжинө шүү дээ. Энэ 126 дотор 1 ч энэ байгаль орчноо сүйтгэчихье, энэ уул уурхайг нь замбараагүй явуулчихъя гэсэн нэг ширхэг ч гишүүн байхгүй гэж би итгэлтэй байна.

Би Байнгын хороон дээр зөндөө тайлбарласан. Тэр 2, 3 дугаар зэрэглэлд орсон юмнууд чинь зайлшгүй энэ юманд ордоггүй юм. Харин иргэдээс асууж байгаа тоо чинь бүүр илүү 14 дахин нэмэгдэж байгаа байхгүй юу. Яг орон нутаг дээрээ. Тэгэхээр энэ заалтыг бас ингэж гуйвуулж болохгүй. Таны саяын асуучихсан юм чинь 7.7-д заасан энэ хэсэгт энэ байгаль орчны үнэлгээ шаардахгүй л гэж байгаа шүү дээ. Үгүй ээ энэ 32 хувийг нь цуглуулж байгаад л та нар цахимаар мэдүүлчих, тэр мэдүүлснийг чинь л бид аваад бүртгэе. Тэрнээс биш энэнд заавал ингээд 152 хоног очерлоод байх шаардлагагүй гэсэн ийм л заалт шүү дээ. Одоо энэ хууль хэрэв ингээд буцаагдвал дахиад л 2 жил орж ирэхгүй, дахиад л нөгөө бизнес эрхлэгч чинь 152 хоног 1 литр химийн бодис оруулж ирсэн ч, хэдэн тонноор нь оруулж ирж байгаа уул уурхайн компани бүгд адилхан явах байхгүй юу. Харин тэр байгаль сүйтгээд байгаа хүмүүс чинь илүү хождог байхгүй юу. Дандаа арын хаалгаар ярина, авлигыг нь өгнө, тэгээд л хийж байна. Нөгөө муу хөөрхий жижиг юунууд чинь ингээд л ард хоцордог байхгүй юу. Тэгэхээр бүгдийг сайхан ангилаад өгье, цахимжуулаад өгье, мэдэх эрхийг нь ил тавиад өгье гэсэн ийм л хууль шүү дээ. Тэгээд энийг та нар ингээд зөндөө тайлбарлаад, Байнгын хороон дээр би зөндөө тайлбарласан. Ингээд хамаа алга тэр буцаах гээд байгаа бол дараа нь тэгээд дахиад 2, 3 жил болоход энэ чинь улс оронд л хохиролтой байхгүй юу.

Х.Булгантуяа: Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Би Одонтуйа сайдыгаа хүндэтгэж байна. Тэгэхдээ би хувь хүн яриагүй. Би яг асуудал ярьсан. 7.14-д 10 хоног тоолуур гүйгээд л дууссан бол бандан тас шууд явах уу гэж асуусан.

2-т нь болохлоор энэ хуулийн заалтыг орж ирсэн заалтыг дараа нь зөвхөн Засаг дарга мэднэ гэж орж ирсэн. Маргарет Тэтчерийн нэг хэлсэн үг байдаг юм л даа. Би асуудал ярихлаар өөдөөс миний хувь хүн рүү их ярих юм. Би асуудал дээрээ ялчихсан юм байна гэж нэг хэлж байсан шиг би өнөөдөр энэ танхимд ард түмний нэрийг барьж ярих эрхтэй. Би яг ард иргэдийн зовлон зүдгүүрийг бодож байгаад л энэ дээр гарц гаргалгаа юу байна, ийм бэрхшээл байна л гэж ярьсан шүү. Би тэр эрхээ эдэлж байгаа.

2 дугаарт янз бүрийн попрох нэр хүнд рүү дайрч болно. Зүгээр яг асуудал дээр, асуудал дээр л хариулт авахыг би хүссэн. Тэгэхлээр би ажлын хэсэг хариулт өгнө гэж.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс индэр дээрээс хариулт өгье.

И.Бямбахүү: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн судлаач Бямбахүү байна. Тэгэхлээр энэ заалт 1 дүгээрт 10 хоногтой холбоотой асуудал. Тэгэхлээр энэ нөгөө нэг шууд нөгөө нэг Засаг даргаас нь санал авна гэдэг хуучин хуулиараа зохицуулалт маань байж байгаа. Гол нь нөгөө нэг хугацааг богиносгохтой холбоотойгоор энэ 10 хоногийг оруулж өгсөн. Энийг цаашдаа бид хэрвээ энэ хууль маань цаашдаа хэлэлцэгдээд явахаар болбол 10 хоногоо бид буцаагаад нэмээд явах ийм боломж байгаа гэж харж байгаа. Биш, биш ухна гэсэн үг биш шүү дээ. Өөрөөр хэлбэл, тийм, энэ ерөөсөө ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргахад анхан шатын нэгжээс авч байгаа л баримт бичиг буюу Засаг даргаас авч байгаа. Энэ Засаг даргын бичиг дээр үндэслээд ерөнхий үнэлгээний дүгнэлт гарна.

Ерөнхий үнэлгээний дүгнэлтээр нарийвчилсан үнэлгээ маань хийгдэнэ. Нарийвчилсан үнэлгээний хүрээнд бүх нөлөө.../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмэлт минут өгье. Ажлын хэсгийн микрофонд 4 номерын индэр. Микрофон нь асчихсан байна шүү.

И.Бямбахүү. Тийм шууд ухна гэсэн үг биш. Өөрөөр хэлбэл энэ чинь шат дамжлагатай явж байгаа. Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулахад л тэр Засаг даргын санал маань орж ирж байгаа шүү дээ. Энэ санал дээрээ үндэслээд ерөнхий үнэлгээний дүгнэлтээр гарна. Энэ дээрээ нарийвчилсан үнэлгээ хийнэ. Нарийвчилсан үнэлгээнийхээ явцад тэр орон нутагт үзүүлж байгаа төслийн зүгээс үзүүлэх бүх тэр байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг үзнэ. Энэ нь буцаад ард иргэддээ очиж хэлэлцүүлнэ, хэлэлцүүлсэн үр дүнгээ бид баталгаажуулна. Баталгаажуулсан үр дүнгээ буцаагаад бид Мэргэжлийн зөвлөлдөө оруулж ирээд танилцуулаад, энэ нь шийдвэр маань гараад явж байгаа. Дээрээс нэмж хэлэхэд 2021 онд Монгол Улсын ЗГ Австрали улсын ЗГ-аас хамтарсан А... төслийн хүрээнд ер нь энэ хэд хэдэн аймгууд дээр суурь судалгаа хийсэн байгаа. Энэ нь өөрөө энэ судалгааны үр дүнгээс ямар үр дүн гарсан бэ гэхлээр ер нь 500 орчим хүн хамрагдсан. Эндээс 70 орчим хувь нь буюу тэр бидний баг дээр амьдарч байгаа ард иргэд маань энэ нөлөөллийн үнэлгээтэй холбоотой асуудлыг мэдэхгүй байна гэсэн ийм үр дүн.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ганбаатар гишүүн нэмж тодруулъя.

С.Ганбаатар: Яг саяын зүйл дээр би зүгээр тодруулаад асуучихъя. Ингээд 10 хоногт, ажлын 10 хоногт багтаан хариу өгөх маш давчуу хугацаа байгаа. Тэгээд энэ дээр хугацаандаа шийдвэрлээгүй тохиолдолд хариу өгсөнд тооцно гэдэг нь байна шүү дээ зөвшөөрсөн гэсэн үг юм уу, татгалзсан гэсэн үг юм уу л гэж би маш энгийн тодорхой асууж байна шүү дээ? Тэгэхлээр аль нь ч биш юм уу, эсвэл татгалзсан, эсвэл зөвшөөрсөн 3 хувилбараас аль нь юм бэ? Маш тодорхой асуулт шүү дээ.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон маш тодорхой асууж байна, маш тодорхой хариулмаар байна.

И.Бямбахүү: Шууд зөвшөөрсөн гэж үзнэ.

Х.Булгантуяа: Дүгэрийн Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Баярлалаа. Тэгэхээр энэ ингээд надад 3, 4 асуулт байна, цаг яваад байна шүү.

Х.Булгантуяа: Рэгдэл гишүүн асуултаа асууя.

Д.Рэгдэл: 1 дүгээр асуулт Их Хурлын нэг ажлын хэсэг дээр Байгаль орчны яам хуулийн төслүүдийг танилцуулга хийсэн. Тэгээд түүн дээр ажлын хэсгээс ер нь энэ Байгаль орчны хууль багц хуулийг багцаар нь оруулж ирэх нь зүйтэй гэсэн чиглэл өгсөн. Багцаар нь оруулж ирэхдээ тодорхой хүндрэл байвал үндсэн суурь хуулиудынхаа өөрчлөлтийг оруулж ирээч, тэрнийгээ дагуулаад бусад хуульдаа ингэж нэмэлт, өөрчлөлт оруулаад явах бол илүү боломжтой гэж үзсэн юм байгаа юм. Тэгэхээр яагаад тэр багц хууль дундаас ганцхан энэ хуулийг тасалж гэнэтхэн оруулж ирж байгаа юм бэ гэсэн энэ 1 дүгээр асуудал?

2 дугаар асуулт энэ үнэлгээний шинэчилсэн ангилалтай холбоотой байгаа юм. Энд төсөл хэрэгжүүлэгчийн эрх ашгийг их хамгаалсан, саадгүй бизнесийн үйл ажиллагаа саадгүй явуулах энэ тэр гэдэг талаасаа зөв боловч нөгөө талд нь энэ байгаль орчныг хамгаалах, иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь хангах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх зэрэг асуудлыг ерөнхийд нь нэг их авч үзээгүй. Тэгэхээр зэрэг энэ байгаль орчны тэнцвэрт байдал гэдэг маань явж, явж Монгол улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь болох юм байгаа юм. Тэгээд одоо ингээд ангиллаа шинэчилчхээд, нийт үнэлгээ хийх тэр төслүүдийн 36 хувь нь ерөнхий үнэлгээ рүү шууд шилжиж байна гэж байгаа юм. Үгүй ээ энэ чинь болохгүй шүү дээ. Ингээд бараг 40 хувийг нь нарийвчилсан үнэлгээнээс чөлөөлдөг барьдаг чинь энэ байгаль орчныхоо хамгаалахынхаа эсрэг үйл ажиллагаа болчихвол яах юм бэ? Энэ яагаад ингэж зөвхөн ганцхан төсөл хэрэгжүүлэгчийн эрх ашгийг дээгүүр тавиад байгаа юм бэ?

Харин нөгөө талаас энэ Иргэдийн нийтийн хурлыг хасаад явчхаж байгаа юм бас дахиад. Энэ бас буруу. Энэ дээр Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэх ёстой. Хэлэлцэхдээ хэд хоног гэдэг юм Иргэдийн нийтийн хуралд материалаа өгөөд 10 хоногийн дотор хариу өгнө, 14 хоногийн дотор хариу өгөхгүй бол зөвшөөрсөнд тооцно гэдэг заалт нэмж өгөх нь зүйтэй. Энэ дээр тэр 10-ын хэд байна Ганбаатар гишүүнтэй бол би санал нийлэхгүй байгаа юм. Хугацаа зааж өгөөд, хариулт өгөхгүй тооцоод явчих бол зөв.

3 дугаарт энэ хууль дээр хэлэлцэж байхад ажлын хэсэг дээр би маш тодорхой санал хэлсэн. Нарийвчилсан үнэлгээг аж ахуйн нэгж мэргэжлийн байгууллага хийх ёстой. Тэр ААН гэдэг чинь эцсийн эцэст явж, явж ганц хүнтэй нэгж байж байдаг, компани байж байдаг. Тэгээд судалгааны байгууллагуудаар яваад юм хумыг нь гуйж яваад, цөөхөн хэдэн төгрөг өгөөд ингээд нэг юм гаргачхаад байгаа. Энэ олон жил явж байгаа. Байгууллага гэдэг үгийг нэмж оруулаагүйгээс болоод энэ шийдвэрүүд хүчингүй болох их том үндэслэл бий. Соёлын өвийг хамгаалах тухай хууль дээр төсөл хэрэгжүүлж байгаа тэр газрын түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах хайгуул хийнэ гэж заасан. Энэ нарийвчилсан үнэлгээний тухай энэ хуулийн заалт дээр төсөл хэрэгжих газрын түүх, соёлын үнэт зүйлсийн тухай материалыг оруулж өгнө гээд байгаа юм. Тэгэхээр энэ үнэт зүйлсийг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага хийнэ гээд Соёлын өвийн тухай хуульд заачихсан байхад энд аж ахуйн нэгж гээд хүчээр тулгаад байж болохгүй. Яагаад ААН гэдэг дээрээ мэргэжлийн байгууллага гэдэг үг, мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага гэдэг үг нэмэхгүй байгаа юм бэ гэсэн энэ 3 дахь асуулт байгаа юм.

Х.Булгантуяа: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр түрүүн бас хэлсэн. 2020 онд хүчингүй болсон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар баг, хорооны Иргэдийн нийтийн хурал жилд 3 удаа, 3-аас доошгүй хуралдах зохицуулалттай байсныг 20 оны шинэчилсэн найруулгаар энэ заалтыг аваад хаячихсан юм. Тэгэхээр одоо Иргэдийн нийтийн хурал жилд хэд хуралдах юм ямар ч зохицуулалтгүй болчихсон. Тэгэхээр бид хуулиа оруулж ирэхдээ өнөөдрийн мөрдөгдөж байгаа хуулийн дагуу л ингээд оруулж ирсэн байгаа.

Дээрээс нь энэ зөвхөн хөдөө орон нутгийн баг биш. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, үйлчилгээ нь бас энэ нутаг дэвсгэрийн хороо гээд зохицуулалтад орчхож байгаа. Хорооны Иргэдийн нийтийн хурал нь бас яаж хэлэлцэх юм, яаж, хэдэн удаа хуралдах юм, яаж хүн ам бүрдүүлэх юм гэдэг нь яг л одоогийн энэ хуулиар үйлчлээд байгаа болохоор энэ чинь Улаанбаатар хотод нэг ААН бүртгүүлье гэхэд заавал энэ хорооны Иргэдийн нийтийн хурал хэлэлцүүлдэг ийм зүйл нь бас бүрхэг болчихоод байгаа юм. Тэгэхээр хэлэлцэх явцад бас энийг бид Улсын Их Хурлын гишүүд энэ ангиллаар нь ингээд хийх боломжтой. Соёлын өвийн судалгааг Соёлын өвийн хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэй эрдэм шинжилгээний байгууллагаар хийлгэж байгаа. Тэр тайланг бол энэ үнэлгээнд татан оруулж, нөлөөллийг нь үнэлэх асуудлыг тусгасан. Одоогийн мөрдөж байгаа үнэлгээний журмаар мэргэжлийн зөвлөлийн нийт гишүүдийн 40 хувь нь их сургуульд шинжлэх ухааны байгууллагын төлөөллийг оролцуулахаар ингээд юуг нь төлөөллийг нь хангасан байгаа. Тийм учраас энэ дээр төлөөлөл сайн хангагдсан гэж үзнэ.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс 4 номерын микрофон дээрээс нэмж хариулъя.

Г.Энхмөнх: Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Энхмөнх. Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл гуайн асуултад хариулъя. Мэдээжийн хэрэг шинжлэх ухааны байгууллагын оролцоог оролцуулах энэ бол нэн чухал асуудал. Энэнтэй тантай санал нэг байгаа. Гэхдээ яг энэ өнөөдрийн түвшинд хийгдээд явж байгаа үнэлгээ дээр хөндлөнгийн шинжээчээр энэ шинжлэх ухааны байгууллагын эрдэмтэн докторууд оролцоод явж байгаа. Нөгөө талаасаа түрүүнд сайд тодруулаад л хэллээ. Бид энэ мэргэжлийн зөвлөл дээр хянагдаад явж байгаа тайлангууд дээр бид шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн эрдэмтэн судлаачдыг 40 хувь хүртэл оролцуулаад явж байгаа. Нөгөө талаасаа юун дээр мэргэжлийн байгууллагуудыг чадавхжуулахтай холбоотой асуудал байж байна. Чадавхжуулахтай холбоотой асуудлаар бид 2023 онд үнэлгээ хийх журмыг шинэчлээд, энэ журмын хүрээнд нийгмийн нөлөөллийн үнэлгээ, мөн энэ хуулийн төсөл дээр нийгмийн нөлөөллийн үнэлгээг маш тодорхой болгоод оруулж ирснээрээ бид энэ.../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж хариулъя, 4 номерын микрофоныг нэмж өгье.

Г.Энхмөнх: Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах бас нөхцөл нэг талаараа бүрдэнэ гэж харж байгаа. Энэ маань юу гэхээр та мэдэж байгаа байгаа одоо байгаа бол байгаль орчны нөлөөллийн үнэлгээ энэ дээр нэмэх нь нийгмийн нөлөөллийн үнэлгээ ороод ирснээрээ тухайн орчинд амьдарч байгаа иргэдийн нийгмийн асуудал, эрүүл мэндийн асуудал, цаашдаа орлого төвлөрүүлэлттэй холбоотой асуудал, магадгүй тэр төслийн үйл ажиллагаанаас хамааралтайгаар бэлчээр хумигдаж байгаа, талхлагдаж байгаа, тэгээд энэтэй холбоотой асуудлууд бүгд энэ гомдол барагдуулах механизм болоод, нөгөө талаасаа энэ олон улсын стандарт шаардлагатай нийцүүлээд явахлаар энэ бүх асуудал нэг талдаа гараад шийдээд явах энэ бас нөхцөл давхар бүрдэнэ гэж харж байгаа.

Х.Булгантуяа: Рэгдэл гишүүн тодруулъя.

Д.Рэгдэл: Тэгэхээр эхний тэр нийтийн хуралтай холбоотой би тодорхой санал хэлсэн шүү дээ. 10 хоногийн дотор, 14 хоногийн дотор хариу өгнө гээд, өгөхгүй бол түүнийг зөвшөөрсөнд тооцно гэж ингэж оруулж болно. Ингэхгүй

Иргэдийн нийтийн хурлаа хасчихаар их олон хууль зөрчих гээд байна. Гишүүд яриад байгаа чинь их ортой.

2 дугаарт та нар бол тэр нарийвчилсан үнэлгээг аж ахуйн нэгж байгууллага гүйцэтгэнэ гэдэг, байгууллага гэдэг үг нэмэхээсээ яагаад татгалзаад байгаа юм бэ? Тэртээ тэргүй зарим хэсгийг нь одоо хийлгэдэг л юм байна шүү дээ байгууллагаар. Тэгсэн мөртөө хуулийнхаа үндсэн заалт дээр аж ахуйн нэгж гэж оруулаад, байгууллага гэж нэмэхгүй гээд ер нь их олон жил гүрийж байгаа танай яамныхан. Та нар магадгүй шинэ учраас мэдэхгүй байгаа байх, 10 хэдэн жил гүрийж байгаа. Би энэ байгууллага гэдэг үг ялангуяа мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага гэдэг үг нэмэхгүй болбол.../минут дуусав/

Х.Булгантуяа: 4 номерын микрофон дээрээс нэмж хариулъя ажлын хэсэг.

Г.Энхмөнх: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Энэ дээр та саналын хүрээнд саналаа тусгаад оруулаад явах боломжтой. Нөгөө талаасаа одоо байгаа хууль, эрх зүй дээр стратегийн үнэлгээ болоод хуримтлах нөлөөллийн үнэлгээ дээр шинжлэх ухааны байгууллагуудыг татан оролцуулж, шинжлэх ухааны байгууллагуудаар хийлгэх ийм зохицуулалт байгаа. Тэгэхлээр үндсэндээ төлөв байдлын үнэлгээ, хуримтлах нөлөөллийн үнэлгээ, стратегийн үнэлгээ дээр шинжлэх ухааны байгууллагууд оролцоод явах боломжтой. Гагцхүү яг өнөөдрийн мөрдөгдөж байгаа хуулиар байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг л тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллагууд гүйцэтгээд явж байгаа. Тэгэхлээр яг энэ нөгөө хөндсөн заалт дээр нь таны саналыг тусгаад ингээд оруулаад явах боломжтой гэж харж байна.

Х.Булгантуяа: Рэгдэл гишүүн нэмж тодруулъя.

Д.Рэгдэл: Би тэр стратеги үнэлгээ, хуримтлагдах үнэлгээний талаар ерөөсөө яриагүй юм байгаа юм шүү. Зөвхөн нарийвчилсан үнэлгээ дээр тэнд чинь газрын хөрс шороо энэ тэр гээд л зөндөө юм судлах ёстой болдог байхгүй юу. Тэгээд тэр чинь хээрийн судалгааны материал бүрдүүлэх ёстой. Энийг зөвхөн мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага л хийж чадна. Тийм л учиртай юм шүү. Баярлалаа.

Х.Булгантуяа: Рэгдэл гишүүн санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга.

Б.Уянга: Байгаль орчны нөлөөллийн тухай нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй санал нэгдэж байгаа. Нэгдэхгүй байгаа зүйлүүд байгаад байгаа. Орж ирсэн төслөөр их олон зөв зүйтэй санаачилгууд гараад, тэгэхдээ бүрэн яг хуулийн төсөлдөө суугаагүй гэж харж байгаа. Тэгэхээр өнөөдөр яах вэ хэлэлцүүлэг дээр олон гишүүд энэ зөвхөн аливаа төсөл хэрэгжүүлэхэд орон нутгаас, хороодоос, дүүргээс санал авахдаа зөвхөн сум, дүүргийн Засаг дарга нараас хариу авъя гэсэн байдалтай ингэж хуулийн төсөл орж ирж байгаад эсэргүүцсэн дүр зурагтай байх шиг байна.

Гэхдээ энэ дээр нэг зүйлийг бас хэлэх нь зүйтэй. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай гээд хууль байгаа. Тэгэхээр сум, дүүргийн Засаг дарга бас өөрсдийнхөө дотоод зохион байгуулалтыг хийгээд, багийн болон хороодынхоо нэгжүүдээр холбогдох асуудлыг хэлэлцүүлээд,

саналыг нь авах бүрэн боломжтой, ийм үүрэгтэй байгууллага. Тэгэхээр бас манай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамныхан энийг бодож, энэ хуулийн уялдаа нь хангагдаж, санал нь хангалттай ирчих нь гэж үзсэн байх гэж найдаж байна. Тэгэхдээ энэ заалт бол 10 хоногийн дотор хариу өгнө гэдэг нь магадгүй жаахан богинохон байгаад байж магадгүй. Тэгэхээр энэ дээр нэгэнт хөндөгдөөд орж ирж байгаа заалт учраас сайжруулаад явах бүрэн боломжтой.

Санал нэгдэхгүй байгаа нэг зүйл болон заавал өнөөдөр чуулганы индэр дээрээс хэлэх шаардлагатай байгаа зүйл нь энэ байгаль орчны нөлөөллийн үнэлгээний, нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөвхөн уул уурхайн төсөлтэй холбоотой хууль биш. Энийг заавал тодруулж хэлэх хэрэгтэй байна. Энэ хуулийн заалт дээрээ өөрөө төсөл гэдгээ тодорхойлохдоо шинээр байгуулах болон ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, уул уурхай, барилга байгууламж гээд энэ бүгдийг оруулж өгдөг ийм том хууль байгаа. Тэгтэл жишээ нь иргэдийн хүсэлтээр байгаль орчинтой холбоотой мэдээллийг авах, ямар нэгэн үнэлгээ хийлгэх энэ шинээр энэ хуулийн төсөлд орж ирж байгаа 14.1.2, 14.1.4, 18.4 гээд энэ иргэдийн хүсэлтийн дагуу хийх аливаа асуудал нь дандаа газрын хэвлийн баялгийн ашиглалт гээд уул уурхай руу чиглэчихсэн зохицуулалтууд ороод ирж байгаа. Тэгэхээр энийг бас ингээд том зургаар нь бүгдээрээ харъя. Эгийн гол, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцууд, Улаанбаатар хотын агаарын бохирдлын асуудал, том төмөр, урт төмөр зам, авто зам бүгдээрээ л байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх шаардлагатай төслүүд. Тэгэхээр энэ дээр иргэдийн энэ саналыг яг яаж авах юм бэ? Яг энэ шинээр орж ирж байгаа зохицуулалтууд нь газрын хэвлийн баялаг гээд уул уурхай руу чиглэчихсэн байгаа нь учир дутагдалтай байгаа юм. Тэгэхээр эдгээр нь тэгэхдээ хөндөгдөөд орж ирсэн заалт учраас бас бид хэлэлцүүлгийн явцад сайжруулаад явчхаж болно.

Гэхдээ ер нь энэ хуулийн төслөөр одоо манай хууль, эрх зүйн орчинд дутагдаад байгаа хэрэгжиж байгаа төслийн нөлөөлөлд өртөж байгаа бүс гэж юуг хэлэх юм, нөлөөлөлд өртөж байгаа иргэн гэж яг хэнийг хэлэх юм гэдэг тодорхойлолт орж ирэх ёстой. Энэ орж ирээгүй. Тэгэхээр бид хэлэлцүүлгийг нь дэмжээд явлаа ч тодорхойлолтыг хаана оруулах юм бэ? Тэгэхээр энэ нөгөө дэмжихгүй байгаа асуудлын гол шалтгаан нь энд байгаа юм.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийдэг болно гэдэг дэвшил байгаа. Тэгэхээр энийг орж ирж байгаад их баяртай байгаа. Тэгэхдээ энэ дээрээ бүгдээрээ бас нэлээн сэтгэлээ гаргаад, сайжруулж орж ирэх орон зай байна гэж харж байна. Яагаад вэ гэхээрээ яг энэ нийгмийн нөлөөллийг ямар шаардлага хангасан шинжээч хийх юм. Байгаль орчны үнэлгээг 8 жил тухайн салбарт ажилласан хүн хийнэ гэж байгаа юм бол нийгмийн нөлөөллийг яг хэн хийх вэ гэдэг зохицуулалтууд бас байхгүй. Тэгэхээр энэ асуудлуудаас болоод хуулийн төсөл нэлээн тийм хүлээж авбал яах вэ, гишүүд дээр их ажилтай байгаа юм шиг харагдаад байна. Тэгээд Байгаль орчны байнгын хороон дээр бас энд саналаа хэлсэн байгаа.

Х.Булгантуяа: Уянга гишүүн санал хэллээ хуультай холбогдуулан. Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Ганмаа гишүүн байхгүй байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэнд хүргэе. Хуулийн төсөлтэй танилцаад хэлэлцэж эхлэх нь зүйтэй гэж бодож байна. Ер нь олон жил энэ хуримтлагдсан асуудал байгаа. Тэгэхээр үндсэн гол асуудал үндсэндээ иргэний оролцоо, төрийн

хяналт, орон нутгийн чадавхын асуудал гэсэн энэ 3 үндсэн асуудлын тэнцвэрийг хадгалах л асуудал байгаа юм. Тэгээд хөдөө орон нутагт ялангуяа энэ уул уурхайтай асуудал аягүй чухал хөндөгддөг учраас энэ иргэдийн оролцоо, дээрээс нь ил тод байдал аягүй чухал байдаг гэж ойлгож байгаа. Тэгээд хууль санаачлагчаас асуухад энэ Үндсэн хуульд олгогдсон төрийн бодлого нь одоо ба ирээдүй үеийн иргэнд үр өгөөжийг тэгш хүртээхэд чиглэнэ гэсэн зарчим байдаг. Энэ дээр та бүхэн маань ямар тооцоо судалгаа хийж, энэ ил тод байдлыг яаж хангаж ажиллаж байгаа юм бэ? Нөгөө сумд байгаа иргэд чинь энэ байгаль орчны үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ энэ мэдээллүүд нь ердөөсөө олж мэдэж авах тэр байдал нь аягүй хэцүү байдаг. Тэрийгээ та нар энэ хуульдаа тусгасан уу?

Дараагийн зүйл нь хэдийгээр төрийн хүнд суртлыг багасгах үүднээс цахимжуулж байгаа боловч шууд ардчиллын зарчим буюу иргэний оролцооны асуудлыг үгүй хийж байгаа санагдаад байгаа юм. Хөдөө орон нутагт учир зүггүй ингээд цахимаар хандаад, яг ингээд нөгөө малчин өрх тэгээд ингээд цахимаар оролцоод явна гэж би бодохгүй байна. Тэр нь оролцоо нь яг тийм орчин нь бүрдэхгүй байх гэж харж байна. Тэгэхээр аль болохоор энэ шууд ардчиллын зарчим буюу энэ шууд оролцох тэр Үндсэн хуулиараа олгогдсон тэр эрхийг нь ямар зүйл, заалтаар нээж өгсөн юм бэ гэдгийг асуумаар байна.

Дараагийн зүйл энэ хууль та бүхний энэ санал болгож байгаа хууль хэрэгжихийн тулд бусад дүрэм, журмууд чинь өөрчлөгдөөгүй байна шүү дээ. Тийм учраас энэ холбогдох дүрэм, журмуудаа ямар хугацаанд өөрчлөх энэ тэр төлөвлөгөө, тэр зүйлээ ойлгомжтой болгож энэ олон нийтэд танилцуулах нь зүйтэй байх гэж харж байна. Тэгээд ер нь энэ орон нутгийн бас тодорхой хэмжээнд энэ сум, дүүргийн, дүүрэг ч гайгүй дээ ашигт малтмал гээд байдаггүй, ялангуяа энэ аймаг, сумын, багийн бас оролцоог тодорхой хэмжээгээр хязгаарладаг, зөвшилцдөг, тохируулдаг тийм хэлбэрийг сонгож ажиллах нь зүйтэй учраас яг тэр нөгөө харилцааныхаа зарчмыг энэ хуульдаа бүрэн гүйцэд тусгаагүй юм уу даа гэж харагдаж байна гэж ойлгож байна. Түүн дээр бас нэмэлт мэдээлэл өгнө үү гэж хүсэх байна? Баярлалаа.

Х.Булгантуяа: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр манай ажлын хэсэг дараа нь нэмээрэй. Бид энэ төслөө ерөнхийд нь 3 ангилж байгаа үнэлгээ хийлгэх хүсэлтэй байгууллагуудын 1, 2, 3 гээд. 3 дугаар зэрэглэл нь ерөнхийдөө би түрүүн хэлсэн жижиг барилгын материал ч юм уу эсвэл нэг багахан манай шинжлэх ухааны байгууллагууд гэхэд нэг багахан, багахан химийн бодис оруулж ирдэг байж байгаа, үсчин ажиллаж байна, жижиг барилгын материалын дэлгүүр бүгд энэ үнэлгээг хийдэг ийм энэ хуулийнхаа дагуу яваад байгаа. Тэгэхээр бид 3 ангилаад энэ жижиг ААН-үүд нь зүгээр цахимаар мэдүүлээд зайлшгүй зөвшөөрөл шаардахгүй ингээд явчихдаг нэг хэсэг байна. 2 дахь хэсэг нь аймаг, орон нутаг бас ерөнхийдөө энэ зөвшөөрлийг нь олгоод, өөрсдөө энийг нь шийдээд, өөрсдөө хяналтаа тавьдаг нэг ийм 2 дахь хэсэг байгаа. 1 дүгээр зэрэглэл яах аргагүй голцуу уул уурхайн компаниуд, аюултай хог хаягдал ч юм уу, химийн бодис ийм зүйлүүд 1 дүгээр зэрэглэлийн ангилалд ороод эд нар нь яах аргагүй тэр иргэдээсээ санал авдаг процессыг маш нарийн оруулж өгсөн.

Зарим хүмүүс болохоор нөгөө иргэдээсээ ерөөсөө санал авахгүй болчихлоо гэж айгаад байгаа. Тийм зүйл байхгүй. Энд жишээлэхэд бид 21 онд Хэнтий,

Сүхбаатар, Өвөрхангай аймгуудаар явж маш нарийн судалгаа хийсэн байдаг. Энд 3 аймгийн 441 оролцогчийг хамруулаад нарийн судалгаа хийхэд 70 хувь нь ер нь энэ төслийн талаар ерөөсөө мэдээлэл мэдлэг байхгүй байсан. Тэгэхээр энэ бол хангалтгүй учраас бид нарийвчилж оруулж өгч байгаа. Нутгийн иргэдэд яаж энэ төслөө танилцуулах юм бэ, яаж эд нараас энэ төслийнх нь талаар илүү мэдлэг, мэдээлэлтэй болгох юм бэ гэдэг нарийвчилж ингээд орчихсон байгаа.

Дээрээс нь би түрүүн хэлсэн нөгөө Үндсэн хуулийн 6.2 дээр иргэдийн мэдэх эрх гэж байгаа. Тэгэхээр бид нийтдээ 4 заалтыг энд оруулж өгсөн байгаа. Яаж олон нийтэд мэдээлэл нээлттэй байх вэ гээд. Та түрүүн хэллээ шүү дээ нөгөө хөдөө орон нутгийн иргэд зарим нь цахимаар чадахгүй байх гээд. Тэгэхээр тэр зайлшгүй зөвшөөрөл шаардлагагүй хэсгийнхийг иргэд мэдээд ч хэрэггүй, тэр бол тэгээд үйл ажиллагаагаа явуулаад хийнэ. Уул уурхайтай холбоотой том төслүүд дээр иргэдэд яаж энэ мэдэх эрхийг хангах вэ гэдэг дээр нарийвчилсан заалт орсон байгаа. Тэгэхээр яах вэ дутуу гэж үзвэл бид хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг энэ дээр нэмээд 1 жил, 2 жил, хэдэн жил ч ажиллаад гаргаад ирэх ийм боломжтой байгаа юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат. Ганбат гишүүн байхгүй байна. Би уг нь үг хэлэхээр цаг авсан байсан. Энд нөгөө хуруугаа уншуулсан чинь алга болчихоод байх юм Тамгын газрынхан. Би нэг асуулт асуух гэсэн юм. Энэ хуулийн төслийн хувьд жижиг бизнес эрхлэгчдийн хувьд, ялангуяа энэ байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх процессыг хөнгөвчилсөн энэ тэр энэ бас давуу тал, сайн тал болжээ. Лагерийнхаа газрыг зарахад хүртэл, эзэмшлийг нь шилжүүлэхэд хүртэл байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийдэг. Үүнийг ингээд бүүр дүүргээс бараг хэлээд өгчихдөг юм байна лээ. Тэр компаниар хийлгээрэй гээд. Тэгээд тэр компани нь очиж хийж амжихгүй болохоороо танайх хаана гэнэ вэ, бичээд өгчихье би наадхыг чинь гээд бичээд өгчихдөг юм байна лээ. Тэгээд тэрүүний төлөө энэ чинь бүүр нэг бодлын авлигын сүлжээ шиг юм үүсчихсэн байсныг арай хөнгөвчилж оруулж ирж байгаа нь сайшаалтай, сайн тал болж байна гэж үзэж байгаа юм.

Нөгөө талдаа нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийдэг болж байгаа нь бас их сайн. Тэгэхдээ та бүхэн ялангуяа аймаг, орон нутагт энэ уул уурхайтай холбоотой хэлэлцүүлэг явуулах дээр Улсын Их Хурлын гишүүд бас нэлээн тогтож яриад байна. Үүн дээр анхаараач. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг багийн иргэдийн дунд нөлөөлөлд өртөж байгаа иргэдийн дунд хийнэ гэхэд аймаг, орон нутагт сум дээр байгаль орчны байцаагч 1 байгаа, байгаль хамгаалагч 2 хүн байна уу, үгүй юү тийм ээ, 1-ээс 2 хүн байгаа байх. Энэ хүмүүс ийм зузаан хэдэн боть ном шиг байгаль орчны нөлөөллийн байдлын үнэлгээг уншаад, тэр аймгийнхаа иргэдтэй энэ бүгдийг танилцуулаад явах тийм нарийн мэргэжлийн хүмүүс бас биш. Ингээд сумаас бол бараг тэр байгалийн байцаагч, байгаль орчныг хамгаалах байцаагч оролцдоггүй тэр хэлэлцүүлэгт, зарим үед оролцож магадгүй, зарим үед бол үгүй. Тэгээд багийн иргэдийн дунд энэ хэлэлцүүлгийг хэн явуулж байна гэхээр нөгөө судалгаа хийсэн компани, судалгаа хийсэн захиалагч нь хийж байгаа юм чинь захиалагчийн өмнөөс мөнгийг нь төлөөд хийж байгаа юм чинь нөгөө хүмүүс л үүнийг батлуулахын төлөө хэлэлцүүлэг яваад өрнөдөг. Тийм ээ. Тэгэхээр ийм биш, нөгөө талдаа энэ чинь хэрвээ ийм байгаль орчинд, иргэдэд ийм нөлөөтэй асуудлыг ярих гэж байгаа бол иргэдийг төлөөлж тэнд мэргэжлийн ямар хүн оролцох юм бэ?

Дээрээс нь нэмээд манай бүх сумын, орон нутгуудын байгаль хамгаалагчийн тоо ч, байгаль орчны байцаагчийн тоо ч бараг адилхан. Хэдэн тэрбум долларын төсөл хэрэгжүүлж байгаа Оюу толгой байгаа Ханбогд сум ч адилхан орон тоотой. Тэгээд тэнд бараг ямар ч уул уурхайн төсөл хөтөлбөр явдаггүй, ямар ч бараг жижиг, том бизнест нэг их байхгүй сумын орон тоо ч бараг адилхан орон тоотой. Тэгээд ийм байгаа цагт наад иргэд нийтийн хэлэлцүүлгүүд чинь үр дүнтэй байж чадах юм уу? Иргэдийн дунд ийм нарийн байгаль орчны үнэлгээг, үнэнийг хэлэхэд бид уншаад ойлгохооргүй тийм том хэдэн боть ном шиг юм байдаг юм байна лээ. Тэгээд тэрүүнийг уншаад, тэрүүнд санал өгч байх хүн нарийн саналуудыг өгч чадах уу? Танилцуулъя гэсэн өнцгөөсөө л танилцуулгаа хийдэг юм байна лээ. Яг танилцуулъя өөрөө батлуулъя гэсэн өнцгөөсөө танилцуулаад л, тэгээд л нэг хэдэн цаг иргэд жоохон бухимдаж байгаад л ганц, хоёр саналаа хэлээд л, эндээс бол дэмжсэн, дэмжээгүй гэдэг санал авдаггүй. Зүгээр л иргэдээс санал аваад л, тэрүүнийг нь тусгасан байдлаар явуулдаг. Танилцуулга тэр бол хэдэн боть номыг танилцуулъя гэсэн хүрээндээ танилцуулаад л, хэдэн саналуудыг аваад л, нэгтгэсэн болоод л ингээд л явуулдаг. Тэгээд ийм байгаа цагт яг үнэнийг хэлэхэд энд олон том уул уурхай байгаль орчинд нөлөөтэй, иргэдийн амьдралд нөлөөтэй ийм том төсөл, хөтөлбөрүүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ үр дүнтэй явагдаж чадах уу, үгүй юү гэдэг ийм хэдэн асуултуудыг асуух гэсэн юм. Ажлын хэсэг хариулах уу?

Г.Энхмөнх: Булгантуяа даргын асуултад хариулъя. Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Энхмөнх. Түрүүнд бас сайд танилцууллаа. Бид энэ 3 аймагт түүвэрчилсэн байдлаар энэ тухайн Иргэдийн нийтийн хуралд оролцож байгаа иргэд болоод холбогдох албан тушаалтнууд дээр ингээд судалгаа шинжилгээ хийж үзсэн. Ингээд үзэхэд нийт судалгаанд хамрагдсан хүмүүсийн 70 хувь нь энэ үнэлгээний талаар тодорхой ойлголтгүй, яг энэ үнэлгээ гэдэг зүйл дээр ямар байдлаар санал өгөх юм, яаж энэ дээр яг энэ өөрсдийнх нь эрх ашиг хөндөгдөх асуудал дээр санал өгөх юм гэдэг юм уу энэ асуудал дутмаг байгаа учраас бид хэд түүвэрчилсэн байдлаар судалгаагаа хийгээд, энэ дээрээ үндэслээд холбогдох мэргэжлийн байгууллага, ОУБ-тай хамтраад загвар цахим ном, цаасан байдлаар хэвлүүлээд ингээд энэ дээр яг 2 жил гэдэг юм уу, сонгогдсон газрууд дээрээ яг тэр төслийн хүрээнд ажиллаад ирэхэд тухайн төсөл эхэлж байсан үе болоод дараачийн үе ингээд харьцуулаад үзэхээр тэр үнэлгээний талаар ойлголт нь шал өөр болж байгаа юм.

Ингээд явахаар яг тэр үүргийг хэн хүлээж байна гэхлээр үндсэндээ тухайн сумын Засаг дарга болоод Иргэдийн хурлын дарга, шинээр бүрдэж байгаа баг, хорооны Иргэдийн нийтийн төлөөлөл болоод иргэдэд энэ орж ирж байгаа хэлэлцэж байгаагаар холбоотой асуудлаар мэдээлэл өгөх, илүү соён гэгээрүүлэх, нөгөө талаасаа төслийг хэлэлцүүлэх явцад хуулийн одоогийн мөрдөгдөж байгаа хуулиараа төсөл хэрэгжүүлэгч болоод мэргэжлийн байгууллага танилцуулгыг хийгээд, энэ асуудал дээр гол нь зүгээр яг тухайн төслийн хувьд эрх ашиг нь яаж хөндөгдөх юм, байгаль орчин талаасаа ямар нөлөө үзүүлэх юм, нийгмийн нөлөөллийн үнэлгээ талаасаа ямар нөлөө үзүүлэх юм энэ талаар тодорхой ойлголт мэдээллүүдийг зөвхөн төсөл хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага гэхээсээ илүүтэйгээр, нөгөө талаасаа төр хамгийн анхан талын нэгж талаасаа тодорхой ойлголтыг өгөх, соён гэгээрүүлэх ажлуудыг үе шаттай хийх зайлшгүй шаардлага байна гэдэг ийм зүйл харагдаж байгаа юм.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон дээр нэмж минут өгье.

Г.Энхмөнх: Нөгөө талаасаа энэ багийн Иргэдийн нийтийн хурлын эрх оролцоотой холбоотой асуудал. Энэ дээр мэдээжийн хэрэг шууд иргэдийн оролцоог хангаад явах энэ нөхцөл тухайн хуулийн төсөл дээр хамрагдсан байгаа. Нөгөө талаасаа тухайн мэргэжлийн зөвлөл шийдвэр гаргахдаа иргэдээс гаргасан саналыг харгалзан шийдвэрээ гаргахаар заасан байгаа юм. Ингэхдээ тухайн иргэдээс гаргаж байгаа саналуудын хувьд хүрээлэн буй орчин болоод нийгмийн асуудал, нөгөө талаасаа гомдол барагдуулах механизмыг хэрхэн шийдвэрлэх гэдэг юм уу яг энэ гол, гол асуудлуудыг нь нарийвчилсан үнэлгээ дээр нь тусгаж өгөөд ингээд эцэслээд шийдвэрлээд явах энэ зарчим, энэ зохицуулалтыг тусгаад оруулж ирж байгаа юм.

Х.Булгантуяа: Үг хэлэхээр нэр өгсөн гишүүдийг индэр дээрээс үг хэлнэ үү хэмээн урьж байна. Батын Батбаатар гишүүн байхгүй байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн байхгүй байна. Даваасамбуугийн Ганмаа гишүүн, 1 номерын индэр дээрээс үг хэлэхэд, голын индэр дээрээс.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Уул нь асуулт байсан, асуултдаа хоцорсон байна шагнал гардуулж байгаад. Үг хэлэх, асуултаа үг болгож тайлбарлахад яах вэ сая бас Булгантуяа дарга ярьж байх шиг байна. Нэлээн хэдэн гишүүд ч энэ талаар ярьж байна. Бид өмнө ч гэсэн би байр сууриа илэрхийлж байсан. Яах аргагүй бид нарын эдийн засгийн нөхцөл байдал уул уурхай тэрийг тулгуурлахаас өөр арга байхгүй, ингэж байж бид цалин мөнгө, хангамж, бүх л асуудал шийдэгдэнэ одоогийн нөхцөл байдал дээр. Нэгэнт ийм гэдгээ бид мэдэж байгаа учраас байгаль орчны үнэлгээг харьцангуй сайн бас хийгээд явдаг юм. Байгаль орчны үнэлгээнүүдийг хийгддэг, овоо хийгдэж байгаа ажил байгаа. Энэ шинэ орж ирсэн хуулиар ч гэсэн олон, нэлээн хэдэн сайжирсан юмнууд байна.

Гэхдээ энд нэг зүйл дутагддаг нь сая энэ хуулиар ч гэсэн яг дутагдаж байна. Юу вэ гэхээр хуулийн төслийн 7.7-д зааснаар байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол, нийгмийн нөлөөллийн болон эрүүл мэндийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана гэсэн нэмэлт, өөрчлөлт орсон байна. Энэ нэмэлт, өөрчлөлтийг харахаар зэрэг бидэнд, надад тулгарч байгаа хэд хэдэн асуултууд нь юу вэ гэхээр 1 дүгээрт хүний эрүүл мэндийн талаар үнэлгээг хийхдээ энэ нь яг аль хэсэгт энэ үнэлгээгээ оруулахаар шийдэгдсэн бэ? Жишээлбэл энийг тодруулаад асуухаар зэрэг журмаараа заана гэж орсон байдаг. Журам руу нь ороод үзэхээр зэрэг Чинзориг сайдын үед хийсэн журам байна. Тэр журам дээр нь тодорхой яг авчихаар, хэрэглэхээр процесстой юм ер нь алга байна гэж хэлэхэд буруудахгүй гэж бодож байна. Хүнээ үзэх юм уу, оношлох юм уу, тодруулах юм уу, лабораторийн шинжилгээ хийх юм уу, хийвэл ямар, ямар лабораторийн шинжилгээ хийх юм, тэрийг хийх хүчин чадал нь байгаа юу, болохгүй юу? Одоо гараад л асуудал үүслээ, тэрийг яаж үнэлэх вэ гэдэг асуудал огт тусгагдаагүй. Тусгагдсан зүйлүүд нь маш тодорхой биш, тэрийг хараад хийх ямар ч боломжгүй байна. Ийм байгаа нөхцөлд ард иргэд бидний хийж байгаа үйл ажиллагаанд уул уурхайн асуудалд аюулгүй байна, тэрийг нь хамгаална, энэ дээр нь эрсдэлийг зохицуулна гэдэг итгэл үнэмшил хаанаас төрөх вэ гэдэг асуудал хурцаар тавигдаж байгаа юм шиг надад сэтгэгдэл төрж байна.

2 дугаарт надад бодогдож байгаа зүйл гэвэл бид нарын байгаль орчинд хийж байгаа үнэлгээгээ гадаадад байгаа улс орны энэ үнэлгээтэй яаж, хэрхэн зохицож байна вэ? Зохицохынхоо тэр чинь intensity level-ээр нь ингээд хуваачихсан байдаг. Энэ level-ийн хуваалт нь ч гэсэн надад харахад энэнтэйгээ зөрөөтэй харагдаад

байна. Магадгүй өөрчилсөн, шинэчилсэн асуудлуудаар энүүгээрээ засаад юм уу, дараа нь журмаар зохицуулалт орж ирье гэж төлөвлөж байгаа байж магадгүй. Тэгэхдээ бид хэд энэ Улсын Их Хуралд сүүлийн хэдэн сар ярьж байгаа асуудал бол хуулиа давсан журмууд байна, журмаар зохицуулахаар асуудлууд гарч байна, журмууд нь хуультайгаа нийцэхгүй байна, гарч байгаа тогтоолууд нь яг хөрсөн дээр буухгүй байна гэж олон удаа ярьсан. Тэгэхлээр энийгээ засаад, олон улсын жишигтэйгээ тааруулаад, тэрийгээ үнэлэх яг шалгуур үзүүлэлтүүдээ оруулаад, шалгуур үзүүлэлтүүд нь яг смарт буюу хэмжигдэхүйц, тодорхойлж, цаг хугацаандаа хамрагдсан ийм байдлаар хийхийг санал болгож байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ганмаа гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын дэгийн тухай, Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 10.12-ын дагуу санал хураалтыг үдээс хойш явуулъя. Ингээд үдээс өмнөх чуулганаар хэлэлцэх асуудал дууслаа. Үдээс хойших хуралдаан 14 цагаас.

11.41 цаг

2025 оны 05 дугаар сарын 30, Баасан гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 05 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үдээс хойших хуралдааныг даргалав.

Д.Амарбаясгалан: Тийм шүү дээ, гишүүд гараад л явбал дэлгэц хаагдана, орж ирж хурууны хээгээ уншуулна. Ирцээс хасагдахгүй шүү дээ, нээгдэнэ шүү дээ. Гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдааныг эхлүүлбэ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн төслийн талаар гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байна. Байнгын хорооны саналаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Хурууны хээгээ уншуулъя. Санал хураалт. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Улсын Их Хурлын гишүүд санал солилцож, Байнгын хорооны дэмжээгүй санал дээр дэмжээгүй байр суурьтай гишүүд үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжээд, хэлэлцүүлгийн явцад сайжруулаад явах нь зүйтэй гэсэн байр суурийг сая олон гишүүд хэлсэн байгаа юм байна. Ингээд Байнгын хорооны саналаар хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 6 гишүүн буюу 5,9 хувиар хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжсэнгүй. Тэгэхээр Улсын Их Хурал хэлэлцэхийг дэмжинэ гэсэн байр суурь илэрхийлж байна гэсэн үг. Тийм учраас Байнгын хороонд анхны хэлэлцүүлэгт буцаалаа, шилжүүлээ.

14.07 цаг

Гурав.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар/

Дараагийн асуудалд оръё. Боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

С.Амарсайхан: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр Монгол Улсын ЗГ-аас боловсролын салбарт баримталж буй бодлого, хөрөнгө оруулалтын үр дүн, цаашдын зорилтын талаар та бүхэндээ товч танилцуулъя. Монгол Улсын ЗГ 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарласан. Энэ зүгээр нэг уриалга биш, харин хүүхэд бүрийн сурч боловсрох эрх, чанартай боловсролын үйлчилгээ авах боломжийг тэгш олгох үндэсний хэмжээний зорилтот шинэ алхам юм. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд боловсролын салбарт бид бодит үр дүнтэй хөрөнгө оруулалтыг хийж, улсын хэмжээнд нийт 277 цэцэрлэг, 200 ЕБС ашиглалтад орууллаа. Боловсролын салбарын төсөв сүүлийн жилүүдэд 2,5 дахин нэмэгдэж, үүний үр дүнд цэцэрлэг, сургуулийн хувьсах зардал нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон малчин өрхийн нүүдэлчин амьдралтай төдийгүй эрх нь хязгаарлагдсан орчинд өсөж буй 8 мянга гаруй хүүхдийг сургалтад хамруулах боломжийг бүрдүүллээ. Мөн Мэдлээ цахим сургуулийн шийдлээр дамжуулан 36 мянга орчим хүүхэд хөдөө орон нутагт гадаадаас цахим хэлбэрээр хичээлээ үргэлжлүүлэх боломжтой болж, боловсролын хүртээмжид шинэ шийдэл нэмэгдсэн.

Гэхдээ бодит байдалд сургалтын орчны хүртээмж, боловсролын чанар, сургалтын ялгаа, багшийн тогтворгүй байдал, анги танхимын ачаалал зэрэг олон асуудал шийдэгдээгүй хэвээр байна. Боловсрол гэдэг зөвхөн анги танхим, ном сурах бичгийн асуудал биш, харин нийгмийн тэгш оролцоо, эдийн засгийн өсөлт, иргэний хөгжлийн үндэс суурь юм. Өнөөдөр Монгол Улсад нийт сургуулиудын 88 хувь нь 2 ээлжээр хичээллэж байна. Хот, хөдөө, төв болон алслагдсан бүс нутгийн хүүхдүүдийн боловсролын ялгаа 5-аас 7 жил болсон тооцоо байна. Багшийн тоо, тоон үзүүлэлтээр хангалттай мэт боловч сургуулийн менежмент, ажлын нөхцөл, нийгмийн баталгаа зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан багшийн ажлын тогтворгүй байдал өргөн хүрээнд үүсэж байна. Энэ нөхцөл байдлын гол шалтгаан нь ажлын ачаалал, байр, орон сууцын хүртээмж, урамшууллын тогтолцоо, нийгмийн баталгааны нөхцөлтэй шууд холбоотой гэж үзэж байгаа.

Нөгөө талаас багшийн ур чадварыг бодитой нэмэгдүүлэх, цалин үнэлгээний тогтолцоог шинэ стандарт, шалгуураар шинэчлэн зохицуулах зайлшгүй шаардлагатай тулгарч байна. Иймээс бид ирэх 3 жилд дараах томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

1 дүгээрт анги танхимын хүртээмжийг нэмэгдүүлж, сургуулийг нэг ээлжтэй болгох. Энэ хүрээнд 108 сургууль, 95 цэцэрлэг шинээр барьж ашиглалтад оруулна.

Ингэснээр хүүхдийн суудлын тоо 80 мянгаар нэмэгдэж, сургалтын ачаалал ч эрс буурна.

2 дугаарт сургуулийн орчны үдийн хоолны чанар, аюулгүй байдалд онцгой анхаарна. Одоогийн байдлаар хүүхдэд олгож буй хоол шаардлагатай илчлэг шим тэжээлийн дөнгөж 70 орчим хувийг хангаж байна. Бид энэ үзүүлэлтийг 100 хувь болгох зорилт тавьж, үдийн хоолны байр, талбай, түүхий эд хадгалалт, тээвэрлэлтийн орчин, хоол бэлтгэх, үйлдвэрлэх, үйлчлэх бүхий л шатад эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын нэгдсэн стандартуудыг мөрдүүлэх болно. Үүнээс гадна үндэсний үнэт баялаг болсон хүүхэд багачуудын хоол хүнсийг бэлтгэж буй тогооч нар дөнгөж сая төгрөгийн цалин авч байхад тэднээс бид чанартай хоол, тогтвортой ажиллах асуудлыг шаардах эрхгүй болж байна. Энэ нь бид боловсролын салбарын барилга байгууламж, багшлах боловсон хүчний асуудалд үе шаттайгаар анхаарч шийдвэрлэж ирсэн хэдий ч үйлчилгээний ажилчдын үнэлэмжийг орхигдуулдаг байсны тод илрэл юм. Үүнийг даруй засах шаардлага бидэнд байна. Үнэлэмжгүй боловсролын тогтолцоог үнэлэмжтэй боловсролын тогтолцоо болгох, бүрдүүлэх эхлэл нь үйлчилгээний ажилчдын үнэлгээнээс эхлэх ёстой гэж дүгнэж байна. Үүнтэй холбоотойгоор ЕБС-ийн Хоол, үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулж, энэ намрын чуулганаар Улсын Их Хуралд өргөн барина.

3 дугаарт багшийн нийгмийн баталгаа, ажлын нөхцөлийг бодитойгоор сайжруулах ажлууд хийгдэнэ. Багшийн 3 тулгуурт бодлогыг хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнд сургуульд ажиллах шинэ төгсөгчдийг татах тэтгэлэг, байр, зээл олгох зэрэг тэтгэмжийн асуудлыг шийдвэрлэх шаардлага байна. Гүйцэтгэлд суурилсан цалин нэмэгдүүлэлтийг шат дараатай үргэлжлүүлэх, ахмад багш нарыг дадлагажуулагч байдлаар тогтвортой ажиллуулах орчныг бүрдүүлэх, мэргэжилтэй ажилгүй байгаа 20 мянга гаруй багшийг дахин системд оруулж ажиллуулахаас гадна ур чадварыг нэмэгдүүлэх, сургалт, хөгжүүлэлтийн ажлыг оруулж байна.

4 дүгээрт сургалтын хөтөлбөрийг шинэчилж, хүүхдүүдийг цогц чадварт сургана. 2024 оноос эхэлж буй шинэ хөтөлбөр нь шинжлэх ухаан, эх хэл, англи хэл, кодчилал, бүтээлч сэтгэлгээ, төлөвшил зэрэгт суурилж байна. 2025 оноос бага ангийн түвшинд англи хэл, кодчилал, компьютерын хичээлийг албан ёсоор оруулна.

Үүний зэрэгцээ анхаарахгүй орхигдуулж болохгүй онцгой чухал асуудлыг та бүхний анхааралд оруулъя. Сүүлийн жилүүдэд ахуйн осол гэмтэл эрс нэмэгдэж байгаагаас гадна уур амьсгалын өөрсдөөс шалтгаалсан таахын аргагүй гамшиг осол, аюулт үзэгдэл, гал түймэр, салхи шуурга, үер ус, цаашлаад газар хөдлөлийн эрсдэл манай оронд эрс нэмэгдэж, хүн амын аюулгүй амьдрах орчны нөхцөлд заналхийлсээр байна. Энэ төлөв цаашдаа нэмэгдэх ийм эрсдэл ч улам бий болж байна. Иймд бүх шатын сургууль, боловсролын байгууллагын өдөр тутмын хөтөлбөрт ордог амьдрах ухааны хичээлийг чанаржуулж, хүүхэд бүр гамшиг ослын талаарх урьдчилан сэргийлэх, нийгмийн хариуцлагын мэдлэг мэдээллээс гадна, болзошгүй аливаа гамшиг эрсдэлийн тохиолдолд өөрийгөө болон өрөөлийг аврах, амь нас, эрүүл мэндийг хамгаалах анхан шатны чадавхтай байх асуудал хурцаар тавигдаж байна. Үүнийг салбарын яам, Улсын Их Хурлын эрхэм гишүүд шийдвэр гаргагчид та бид төдийгүй бүх шатны сургууль, цэцэрлэгийн удирдлагууд цаашид алхам тутамдаа анхаарч, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, төрийн бодлогын хүрээнд өдөр тутмын үйл ажиллагаа, бодлого шийдвэртээ тусгаж, ажил хэрэг болгож хэрэгжүүлж хэвшүүлэх шаардлагатай болж байна.

5 дугаарт боловсролын тэгш бус байдлыг цахим технологийн дэвшлээр арилгах ажлууд хийгдэнэ. Мэдлээ сурлагын туршлага дээр үндэслэн хөдөө орон нутагт заагддаггүй зарим хичээлийг цахимаар орлон зааж, хүүхэд бүрийг сайн хичээлийг, чадварлаг багшаар заалгах боломжтой болгоно гэж. Үүний хүрээнд цахим платформууд, интернэт холболт, хичээл заах хиймэл оюуны туслах хэрэгслүүд, ухаалаг хэрэглэгдэхүүнүүдийг боловсролын салбарт бүрэн нэвтрүүлнэ. Боловсрол зөвхөн нэг салбарын асуудал биш. Энэ бол төрийн суурь үүрэг, иргэний үндсэн эрх, улсын ирээдүйн хөгжлийн гол үндэс, Монгол хүний өрсөлдөх чадварын шалгуур юм. Боловсролд хийж буй хөрөнгө оруулалт нь Монгол Улсын ирээдүйд чиглэсэн хамгийн чухал хөрөнгө оруулалт, нэн чухал бүтээн байгуулалт. Иймд бид хүүхэд бүрийг эрүүл, аюулгүй тэгш орчинд суралцах боломжоор хангах, багш бүрийг тогтвортой ажиллах нөхцөлөөр хангах, сургалтын чанарыг ижил түвшинд хүртээмжтэй хүргэх зорилтуудыг тууштай хэрэгжүүлнэ.

Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Боловсролын шинэчлэл гэдэг нь зөвхөн суудлын тоог нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэг барих ахуйн шинж чанартай асуудал биш гэдгийг та бид маш сайн мэдэж байгаа. Боловсролын шинэчлэл бол Монгол хүүхэд бүрийг өв соёлоо дээдэлдэг, танин мэдэхүй, шинжлэх ухаанч хандлага төлөвшсөн, аж ахуй сэтгэлгээтэй, хариуцлагатай, чадварлаг Монгол иргэн болгон төлөвшүүлэх амьдралын ухаанд суралцуулах суурилсан цогц бодлого юм. Багш бүрийн үнэлэмжийг дээшлүүлэх, төрийн бодлогын суурь хариуцлагыг хэрэгжүүлэх, Монгол Улсын ирээдүйн хөгжлийн үндсийг бэхжүүлэх чухал үйл хэрэг. Боловсролыг дэмжих бодлогоор дамжин хүүхдүүд эрүүл, аюулгүй, тэгш орчинд суралцах бүх боломжоор хангагдах ёстой. Багш нар тогтвортой орчинд итгэлтэй ажиллах ёстой. Төр бодлогоо тууштай хэрэгжүүлж, ирээдүйн хойч үеийнхээ итгэлийг сэргээх шаардлагатай цаг үе юм. Анхаарал хандуулсан та бүхэндээ баярлалаа. Хэлэлцэн шийдвэрлэнэ үү, асуудлыг хэлэлцсэн үү, хэлэлцэж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Ханджавын Батжаргал Боловсролын яамны ТНБД, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын ерөнхий газрын дарга, Пүрэвдоржийн Оюунаа Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жаалжавын Ариунболд Дээд боловсролын газрын дарга, Хуягийн Тамираа Боловсролын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Эрдэнэ-Очирын Адьяасүрэн Боловсролын яамны Санхүүгийн хэлтсийн дарга, Очирбатын Сийлэгмаа Боловсролын зээлийн сангийн дарга, Болдын Амартүвшин Нийслэлийн боловсролын газрын дарга, Ганбүргэдийн Гантуяа Боловсролын үнэлгээний төвийн дарга. Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдын боловсролын салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын талаар танилцуулсан мэдээлэлд үндэслэн Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс дараах дүгнэлтийг танилцуулж байна. 2025 оны төсөвт боловсролын салбарт 4,5 их наяд буюу нийт Монгол Улсын нийт төсвийн 20 хувийг зарцуулахаар тусгасан нь 21 оноос хойш 2 дахин, 2,5 дахин өссөн дүнтэй үзүүлэлт. Хэдий тийм боловч энэхүү нэмэгдэл нь боловсролын чанарт дорвитой ахиц дэвшил

авчирсангүй. Хөрөнгө оруулалт нь оновчгүй хуваарилагдаж, удирдлагын бодлого тодорхой бус байсаар байна. Өнөөдрийн байдлаар ерөнхий боловсролын сургуулиудын 66 хувь нь 2 ээлжээр хичээллэж, хот, хөдөөгийн боловсролын хүүхдийн боловсролын ялгаа улам их гүнзгийрсэн байдалтай байна.

Хот байгуулалт, газар зохион байгуулалтын бодлогод сургуулийн газрын асуудал тусгагддаггүй нь ирээдүйн боловсролын хүртээмжид эрсдэл учруулж байна. Сургуулийн зориулалттай газрыг өөр зориулалтаар ашиглах явдал байсаар байгаагаас сургууль, цэцэрлэгүүдийг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан барьж байгуулах нөхцөл бүрдээгүй хэвээр байна. Сурагчдын эрүүл өсөлтийн суурь нь зохистой хоол тэжээл бөгөөд сургуулийн үдийн хоолны чанарыг сайжруулах бодлого, зохион байгуулалт хангалтгүй байгаагаас бага, дунд ангийн сурагчдын хоолны чанар шаардлагад нийцэхгүй байгаа гомдол тасрахгүй байна. Багшийн дутагдлыг арилгах зорилгоор олон жил ярьсан ч үр дүнтэй бодлого хэрэгжээгүй. Тэтгэлгээр багш бэлтгэх хөтөлбөрүүдийн үр дүн хангалтгүй. Төгсөгчдийн 2/3 нь багшийн мэргэжлээр ажиллахгүй байна. Энэ нь багшийн цалин хөлс, өрсөлдөх чадваргүй, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангалтгүй байгаатай холбоотой.

Сүүлийн жилүүдэд бага ангийн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх ажлыг эхлүүлсэн ч 3-аас 5 дугаар ангийн хөтөлбөрийн шинэчлэл зогсож, хэрэгжих боломжгүй байдалтай байна. Энэ нь боловсролын салбарт шинэчлэлт хийгдээгүй, бодлогын тодорхойгүй байдал үргэлжилж байгааг илтгэнэ. 2024 онд нийтлэгдсэн PISA үнэлгээнд Монголын сурагчдын 66 хувь нь уншсан зүйлээ бүрэн ойлгох чадамжгүй, 51 хувь нь математикийн анхан шатын түвшнээс доогуур үнэлгээ авчээ. Байгалийн ухаанд 0,2 хувь нь л ахисан түвшний ойлголттой байгаа нь суурь боловсрол бүхэлдээ хямралд орсныг харуулж байна. Энэ үнэлгээ нь манай улсын боловсрол дэлхийн түвшинд хаана явааг харуулсан ч ЗГ-аас тодорхой бодитой дүгнэлт шинэчлэлт, бодит шинэчлэлт хийгдээгүй хэвээр байна. ЮНЕСКО 2019 онд Монголын боловсролын системд хийсэн үнэлгээндээ хэлэхдээ хэсэгчлэн өөрчлөлт хийх нь үр дүнгүй, эрс шинэчлэл явуулах шаардлагатай, үгүй бол том сорилтуудтай нүүр тулна гэж анхааруулсан. Мөн тус байгууллага Монголын боловсрол өрсөлдөөнт эдийн засгийн хэрэгцээг хангаж чадахгүй байна гэсэн дүгнэлт нь өнөөдрийн хөдөлмөрийн зах зээл дээр ил тодоор илэрч байна. Ийм нөхцөлд боловсролын суурь асуудлыг зөвтгөх бус, эрс шинэчлэх шаардлагатай байна. Бодлогын уялдаа, сургалтын чанар, багшийн ур чадвар, удирдлагын хариуцлагыг цогцоор нь сайжруулах цогц бодлогыг эрх баригчдаас бодит байдал шаардаж байгааг сануулъя. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл үг хэлнэ. Индэрт урьж байна.

Б.Мөнхсоёл: Юуны өмнө Боловсролын сайд Наранбаярт энэ жилийг боловсролын жил болгож зарласантай холбогдуулаад нэлээн олон шинэ ажлыг санаачлаад, хүүхэд бүрд боловсрол зайнаас үл хамааран чанартай боловсрол, сургалт, сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр олон ажил санаачилж хийж байгаад талархаж явдгаа үүгээр хэлье гэж бодож байна.

Ерөнхий сайдын мэдэгдэлтэй холбогдуулаад хэд хэдэн асуудлыг хөндөх ёстой юм болов уу гэж бодож байна. Саяын танилцуулсан мэдээлэлд 2026-аас 28 онд улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 108 сургууль, 95 цэцэрлэг шинээр барина гэж гарлаа. Үүнд 2,8 их наяд төгрөгийг хөрөнгө оруулалтад

зарцуулахаар төлөвлөж байгаа юм байна. 2025 онд төсвийн тухай хуульд нийт хөрөнгийн зардал 3,5 их наяд төгрөг, үүнээс Боловсролын сайдын төсвийн багцад хөрөнгийн зардал 472,7 тэрбум төгрөг байхаар батлагдсан. Энэ их хэмжээний хөрөнгө оруулалт бусад салбарын хөрөнгө оруулалтыг шахах вий, бусад салбарын зайлшгүй хөрөнгө оруулалт хойшлогдож, санхүүжилтгүй төсөл, арга хэмжээний тоо нэмэгдэж, үнэ цэнээ алдах вий гэсэн болгоомжлол байгаа юм. Би өөрөө төсөв цаглаврын ажлын хэсэгт байгаа. Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл бодож санаачлахаар бэлдэж байгаа юм. Үүнтэйгээ холбогдуулаад энэ талаар асуулт юу хөндөж хэлмээр байгаа юм. Төлөвлөлтийг бодитоор хийх шаардлага байгаа учраас энэ дээр улсын төсөв, нийслэлийн төсвөөс хэдэн төгрөг зарцуулагдах, эх үүсвэр нь яг юунаас гарах вэ гэдгийг нарийн бодитой төлөвлөх шаардлага байгаа юм.

2 дугаар хөндмөөр байгаа асуудал бол дээд боловсролын чанартай холбогдуулан асуудал хөндмөөр байна. Ойрын жилүүдэд 2007 оноос хойш нэмэгдсэн төрөлттэй холбоотойгоор их, дээд сургуульд элсэгчдийн тоо нэмэгдэхээр байгаа. Гэтэл манай дээд боловсролын чанаргүй байгаа тухай олон жил яригдсаар байгаа боловч саяын хийсэн Ерөнхий сайдын мэдээлэлд дээд боловсролын чанарыг сайжруулахтай холбоотой дорвитой шийдлийг хангалттай хөндөж чадсангүй. Тэгэхээр манай дээд боловсролын салбарт реформын шинжтэй олон өөрчлөлт хэрэгтэй байна. Ганцхан жишээ дурдахад хувийн цэцэрлэг, сургуулийн жилийн төлбөрөөс хэд дахин бага ийм хэмжээний төлбөртэй учраас их, дээд сургуулиудаас чанарын тухай ярих, мундаг боловсон хүчин татах боломж хомс байна гэдгийг хэлмээр байгаа юм.

3 дугаар нэг хөндмөөр байгаа асуудал мэдээж мэргэжил, техникийн боловсрол, сургалтын салбарын асуудал байгаа. Тэгээд Шинэ сэргэлтийн бодлого мега төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах хүчнийг бэлтгэх чухал салбар энэ мөн байх. Тэгэхээр энэ салбар олон жил гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төсөл хөтөлбөрөөр л илүү урагшилж эхэлсэн. Өөрөөр хэлэх юм Герман улсын GMIT гээд нэг сургууль байна. Мөн 2 жилд сургалт явуулдаг Коосэн сургалтын хөтөлбөр гэж байна. Үүнээс гадна яг манай дотоодын боломж нөөц, төлөвлөлт стратеги, алсын хараа юу байгаа бол. Энэ тал дээр анхаарч ажилламаар байна гэж асуудал хөндмөөр байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа Цөөнхийн төлөөлөл Агваанлуvsангийн Ундраа гишүүн үг хэлнэ, индэрт урьж байна.

А.Ундраа: Та бүхний өдрийн амгаланг айлтгая. Ерөнхий сайдын хийх мэдээллийг Шадар сайд уншиж танилцууллаа. Энэ мэдээлэлтэй уншиж танилцаад, сонсож танилцаад дараах саналууд, дүгнэлтийг Улсын Их Хурал дахь Үндэсний эвслийн зүгээс гаргаж байна. Ерөнхий сайдын мэдээллээс үзэхэд энэ бэлдсэн үг зөвхөн албан боловсролын тэр дундаа сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд боловсролын хүрээний асуудлуудыг хөндөж тавьсан байна. Мэдээж боловсролын шат шатын боловсролын шатлалд бага, дунд боловсрол эзэмших явдал өсвөр насны хүүхдийн асуудал, хүүхдийн үдийн хоолны асуудал, сургууль, соёлын, засвар үйлчилгээний асуудал, байр хүртээмжийн асуудал нэн чухал. Хэлсэн зүйлсийг үгүйсгэх гэсэнгүй. Харин үүнээс цааш анхаарал хандуулах шаардлагатай хэд хэдэн асуудлын талаар хөндөж хэдэн үг хэлье.

1 дүгээрт Монгол Улсын хувьд үйлдвэржиж буй үйлдвэржих зорилго тавьж буй олон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилт тавьж буй энэ цаг хугацаанд Монгол Улсын дунд боловсрол, түүний дараах мэргэжлийн боловсролын, дээд боловсролын түвшний сургалтын чанар, хамрагдалт, төгсөгчдийн ажлын олдоц, мэргэжлээрээ ажиллах боломж, мэргэжлээ мэргэжлээрээ ажиллах хүсэл сонирхолд одоогийнхоос илүү анхаарал хандуулж, чанартай боловсрол эзэмшсэн, чадварлаг мэргэжилтний шинэ үеийг бий болгох бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг анхаармаар байна. Үйлдвэржилтийн бодлого, хүний нөөцийн бодлого, Боловсролын бодлогын хоорондын уялдаа холбоог сайжруулж, ажлын талбар дээр шаардлагатай байгаа мэргэжлээр хүүхэд, залуучуудыг суралцуулдаг бодлого руу шилжихгүй бол зарим мэргэжлээр хүн амын дунд хэтийдсэн олон хүнтэй болсон атлаа чухал мэргэжлээр тэр дундаа шинжлэх ухааны тулгуур мэргэжлээр салбарын цөөн залуу эрдэмтэд гадагш дүрвэж, жишээлэхэд хавдрын эмчилгээний doze бодох физикч байхгүй. Хөдөө орон нутагт математик, физик, хими, биологи, заах багш байхгүй. Үйлдвэрүүдэд техник, технологийн чиглэлээр багаж, тоног төхөөрөмжийн шинээр дизайн хийх нь битгий хэл байгаа тоног төхөөрөмжийнхөө тохиргоог хийх, calibration хийх мэргэжилтэн, шинэ төгсөгч ажилд олдохгүй, олдсон мэргэжилтнүүдээ ажлын байран дээр нь дахин сургаж, үйлдвэрүүд, бизнесүүд өндөр өртгөөр мэргэжилтнээ өөрсдөө бэлтгэх давхар зардлын дарамтад орж байгааг анхаармаар байна. Энэ нь боловсролын бодлого алдагдсаны тод жишээ. Өнөөдөр Монгол Улсад бодлого нь боловсролын бодлого, философи тодорхой тогтоогүй байгааг харуулж байна.

2 дугаарт Боловсролын асуудал хариуцсан ЗГ-ын гишүүд нь зарим үед хэрэглээний шинжлэх ухаан, суурь шинжлэх ухааны ялгаагаа ч мэдэхгүй байна. Энэ нь боловсролын салбарын хөгжлийн тушааг холоос хайх хэрэггүй гэдгийг харуулж байна. ЗГ-аас энэ жилийг боловсролын жил болгон зарласан. Угтаа боловсролын бус жил гэж байх ёсгүй бөгөөд жил бүр боловсролын жил байх учиртай төдийгүй Монгол Улсын хамгийн том, хамгийн тэргүүн зэргийн мега төсөл бол хүүхэд бүрийг нэг ээлжээр хичээллэдэг чанартай сургалттай сургуульд боловсрол эзэмших боломжоор хангах учиртай юм.

Өнөөдөр өгөгдсөн тоон мэдээлэл дунд өнгөц дүгнэлтүүд цөөнгүй байна. 2 ээлжээр хичээллэж байгаа гэдэг баримтуудын цаана ганцхан жишээ дурдахад Баянгол дүүргийн 141 дүгээр сургууль дээр бодит хүчин чадал нь 960 хүүхэдтэй сургууль одоогоор 4200 хүүхэдтэй хичээллэж байна. Төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийн тайланг сайн сайхан харагдуулахын тулд коридор, багш нарын өрөө, номын сан гээд боломжит бүх газраа хана босгож хичээлийн анги танхим байгуулсан. Тэгсэн хэдий ч багтахгүй, зарим хичээл цахим хэлбэрээр нэр төдий додомдож байж, додомдож байгаа нөхцөл байдал үүсээд байна. Түүнчлэн хүүхдийн бие бялдрын хөгжил чухал хичээл болох биеийн тамирын хичээлийг нэг зааланд 4-өөс 5 анги нэгэн зэрэг давхцан орж байгаа нь бид хүүхдүүдээ хөгжүүлэх гэж сургаж байгаа юу, сургууль байгуулж байгаа юу, эсвэл 2 ээлжээр хичээллэж байгаа гэсэн нэр зүүх гэж ажиллаж байна уу гэдгийг асуух нөхцөл үүсээд байгааг харуулж байна.

3 дугаарт төгсөгчдийн мэргэжлийн ур чадвар, иргэний төлөвшил, ёс суртахууны хүмүүжлийн байдлыг сайжруулж, хариуцлагатай, санаачилгатай ажиллах, ачаалал даах төлөвшилтэй төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл өгүүлж байна. Их, дээд сургуулиудын хөтөлбөрт шинэчлэл хийх шаардлагатай байна. Онол практикийг хослуулсан хөтөлбөрөөр төгсөгчдийг ирээдүйн ажилд нь бэлддэг

үйлдвэр, ААН байгууллагууд их сургуулиудтай судалгаа шинжилгээ хамтран ажилладаг тогтолцоог бүрдүүлж, ойрын ирээдүйд их, дээд сургуулиудын орлогын эх үүсвэрийг солонгоруулж, санхүүжилтийн зарим хэсгийг төрөөс гаргадаг бол судалгаа шинжилгээнээс бусад орлогын эх үүсвэрээ бүрдүүлж чаддаг судалгааны их сургуулиудтай болгох зорилтыг тавьж ажиллах цаг хэдийн болсон байна. Аливаа улсын хөгжлийн цөм нь их, дээд сургуулийн судалгаа шинжилгээ, түүнийг тойрсон ажлууд дээр үндэслэдэг байх нь чухал бөгөөд цаашдаа Шинжлэх ухааны академийн судалгааны хэсгийг Их, дээд сургуулиудтай нийлүүлж, илүү судалгааны хүрээллийн хэлбэрээр хүчирхэгжүүлэх шаардлагатай байна гэдгийг энэ нөхцөл харуулж байна.

Дараагийн асуудал 4 дүгээрт ажиллагсдын суралцах эрэлт хэрэгцээнд нийцсэн насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлэх, тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна. Тасралтгүй суралцаж мэргэжил эзэмших, хөрвөх бололцоо бүрдүүлэх, их, дээд сургуульд бакалаврын зэрэг аваад цаашдаа насан турш тэр мэргэжлээрээ ажилладаг цаг үе өөрчлөгдөж байна. Үүнд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут сунгаж өгье.

Д.Амарбаясгалан: Цаг болсон байна. Боловсролын судалгааг зөвхөн сургууль доторх сургалтын хүрээний асуудалд чиглүүлдгийг өргөжүүлж, төгсөлтийн дараах шатын боловсрол, эдийн засгийн өсөлт, боловсрол, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн гэмт хэрэг, боловсрол гэр бүл төлөвлөлт зэргээр боловсрол судлалын ахисан түвшний асуудлуудад анхаарч судалгааг санхүүжүүлэх зэрэг асуудлуудыг хөндөх хэрэгтэй байна. Ерөнхий сайдын мэдээллээс үүн дээр одоогоор хариулт олж харсангүй. Үндэсний эвслийн зүгээс боловсролын салбарын бодлогын судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд цаашдаа боловсролын философитой болох, дүн шинжилгээнд суурилсан бүтээлч шүүмж өрнүүлэх аливаа талуудтай хамтран ажиллах боломж нээлттэй байгааг дурдахыг хүсэж байна. Анхаарч хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Иргэний Зориг ногоон намын дарга, Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар үг хэлнэ. Индэрт урьж байна.

Б.Батбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

ЗГ-аас хэрэгжүүлж буй боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд туссан томьёоллын талаар сөрөг хүчний хувьд Иргэний Зориг ногоон намыг төлөөлөн байр сууриа илэрхийлье. Иргэний Зориг ногоон нам бид Монгол хүний өнөө болон хойч үеийнхний сайн сайхан амьдрах баталгааг хангах зорилгын үүднээс тэдний амьдралыг тэтгэх тогтолцоог найдвартай хамгаалах, эдийн засгийн хүртээмжтэй, нийгмийн даацтай, байгаль экологийн тэнцвэртэй хөгжлийг бий болгох нь улс орны хөгжлийн үндсэн тулгуур гэж үздэг нам юм. Төр засгийн бодлого бол хүний сайн сайхан, аз жаргалтай амьдралын төлөө л байх ёстой. Үүний суурь нь боловсролын бодлого, түүний хөрөнгө оруулалтаар илэрхийлэгдэнэ.

Боловсролын чанар, хүртээмж, тэгш байдлыг сайжруулах нь эдийн засаг, нийгмийн бүх салбарын хөгжилд хүчтэй түлхэц болдог. Бид хүнийхээ хөгжилд суурилсан, урт хугацааны тогтвортой хөгжлийг нягт төлөвлөх нь хамгаас чухал гэж үзэж байна. Хүний хөгжил гэдэг нь хүний мэдлэг, ур чадвар, амьдралын чанар,

эрүүл мэнд, орлогын түвшин, оролцооны боломж зэрэг олон үзүүлэлтээс хамаардаг. Тэр дундаа боловсрол бол хүний хөгжлийг дэмждэг хамгийн чухал үзүүлэлт юм. Гэхдээ бид боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ боловсролын чанарыг орхигдуулж хэрхэвч болохгүй. Иргэдийн боловсролын түвшин, чанарыг нэмэгдүүлснээр хөдөлмөрийн зах зээл дээрх ажиллах хүчний бүтээмж, чанарыг нэмэгдүүлснээр хөдөлмөрийн зах зээл дээрх ажиллах хүчний бүтээмж хэд дахин нэмэгдэж инновац, технологийг нэвтрүүлэн, эдийн засгийн хөгжлийг хурдасгах боломжтой.

Түүнчлэн боловсрол нь ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, иргэдийн орлого, амьдралын чанарыг сайжруулан, нийгмийн дунд давхаргыг нэмэгдүүлэх гол хөшүүрэг юм. Боловсролын хүртээмж чанарыг нэмэгдүүлэхэд боловсролд зарцуулж буй улс орны төдийгүй хувь хүний хөрөнгө оруулалт, цаг хугацаа нь ирээдүйд өсөн нэмэгдэх үр өгөөж, бүтээмжийг хэд дахин нэмэгдүүлдэг нь олон судалгаагаар нотлогдсон. Өөрөөр хэлбэл ирээдүй хойч үе, хүүхэд залуус, иргэдийнхээ боловсролд оруулж буй хөрөнгө оруулалт бол хамгийн зөв бөгөөд өндөр үр өгөөжтэй хөрөнгө оруулалт билээ. 2024 оны байдлаар боловсролын салбарын урсгал зардал 4,2 их наяд төгрөг болж энэ нь ДНБ-ий 5 хувьтай тэнцэж байна. Түүнчлэн 21 онд 915 тэрбум төгрөг байсан багш нарын цалингийн сан 2024 онд 2,3 их наяд төгрөг болж нэмэгдсэн. Багшийн тасралтгүй хөгжил, сургалтын хэрэглэгдэхүүн, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж зэрэгт суурилсан зардал нэмэгдэж, 2024 онд 113,6 тэрбум төгрөг болсон. Гэвч улс орны эдийн засгийн хөгжил, инфляц, төгрөгийн худалдан авах чадвар зэргээс хамааран багш боловсон хүчний орлогод чанарын өсөлт гарч чадсангүй.

Дэлхийн улс орнууд байшин барилга, зам гүүрт хөрөнгө оруулахаас илүүтэй хүндээ хөрөнгө оруулалт хийхийг чухалчилдаг болоод удаж байна. Энэ нь ч хөгжлийн үндэс нь. Гэтэл бид төсөв мөнгөнийхөө хэдэн хувийг зарцуулж байгаа билээ. Бодох л ёстой асуудал. Түүнчлэн хот, хөдөөгийн төдийгүй улсын болон хувийн сургуулийн сургалтын чанар ялгаатай, багш, боловсон хүчний хөгжих боломж, сургалтын хэрэглэгдэхүүн, суралцах, хөгжих орчин нь зөрөөтэй хэвээр байна. Энэ нь хөдөө орон нутгаас хот суурин газар луу чиглэсэн дотоод болон гадаад хүн амын шилжилт хөдөлгөөний үндсэн шалтгаан болдог. Монгол Улсын хамгийн том баялаг бол газрын дор хэвлийд байгаа байгалийн баялаг бус хүн баялаг, хүмүүн капитал юм гэдгийг бид мартаж болохгүй. Иргэний Зориг ногоон нам нь төрийн аливаа төлөвлөгөө, бодлого, шийдвэр, хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа нь иргэдийн өдөр тутмын амьдралд эергээр тусаж, иргэдийн амьжиргаа, эрүүл мэнд, боловсрол, аюулгүй байдал зэрэг бүхий л нөхцөлийг сайжруулсан иргэн төвд байвал тэр төлөвлөгөө, тэр бодлого шийдвэр, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг бид зөв гэж хардаг.

Тиймээс Иргэний зориг ногоон нам нь хүртээмжтэй, тэгш хамран сургах боломжийг бүрдүүлэх, боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тус салбар дахь технологи, инновацын хөгжлийг дэмжих, сургалтын хөтөлбөрийг салбарын өндөр хөгжиж буй туршлагатай уялдуулах, сургалтын олон талт нөхцөлийг бүрдүүлэх, багшлах боловсон хүчний мэргэжлийн бэлтгэлийг гадаад, дотоодын өндөр түвшинтэй сургуулиудад дээшлүүлэх, үүнд тэтгэлэгтэй хамрагдах давуу боломжийг бүрдүүлэх зэрэг төлөвлөгөөг мөрийн хөтөлбөртөө тусган, боловсролын салбарт хийгдэж буй аливаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжин ажиллаж байна. Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулахад төрөөс сургалтын бодлогын тогтвортой байдлыг хадгалах, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт,

өрхийн амьжиргаа, нөхцөл, суралцагчийн онцлог, сурахуйн чадамжид нийцсэн олон улсын болон бүс нутгийн шат шатын боловсролын хөгжил, бодлого, эрэлт шаардлагад тохирсон өөрийн орны уламжлал сэтгэлгээний ондоошлыг шингээсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг тогтмол үнэлж, үнэлгээнд суурилсан ялгаатай дэмжлэгийг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Түүнчлэн суралцагчдын сургалтын хэрэглэгдэхүүн, байгалийн ухааны хичээлүүдийн лабораторийн тоноглол хэрэглэгдэхүүний тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхийн хамт багш, боловсон хүчний хөгжил, сургалтын шинэлэг арга зүйг сургалтад нэвтрүүлэх, багшийн ёс зүй, харилцаа, нийгмийн болон эрүүл мэндийн баталгааг хангах чиглэлд мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах ёстой. Шат шатны сургалтын байгууллагын байршил, өмчлөлийн хэлбэр, суралцагчдын тоо, хөтөлбөрийн ялгаатай байдлаас үл хамааран сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хангалтад анхаарах. Байгалийн ухаан, мэдээллийн технологийн хичээлийг лабораторид, технологи, хөгжим, биеийн тамирын хичээлийг зориулалтын кабинет, спорт зааланд хичээллэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын чанар, хөтөлбөрийн биелэлтэд нэгдсэн хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

Сайн боловсрол ирээдүйн сайн сайхан амьдралын урилга болдог. Өнөөдрийн боловсролд оруулж буй нэг төгрөг бүр ирээдүйн хөгжлийн хөрөнгө оруулалт байдаг. Маргаашийн нийгмийн даацтай хөгжил, эдийн засгийн хүртээмжтэй байдал бол өнөөдрийн боловсролын сайн бодлого, зөв шийдэл, оновчтой хөрөнгө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх цөөнхийн төлөөлөл нэрсээ өгье. 5 гишүүнээр тасаллаа. Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Г.Ганбаатар: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Улсын Их Хурлын даргаа энэ Ерөнхий сайдын мэдээллийн цагийг ер нь Шадар сайдын мэдээллийн цаг гээд нэрлэхивэл яасан юм бэ? Би өнгөрсөн 10 сарын хугацаанд Ерөнхий сайд мэдээллийнхээ цаг дээр гуравхан удаа орж ирэхийг л үзлээ. Нэг удаа орж ирэхдээ Баярмаа гишүүнийг Баярцогт гээд бөөн дуулиан тариад явчихсан. Тэгээд үндсэнд нь тэрнээс хойш Гантөмөр дарга Эдийн засгийн хөгжлийн сайд байхдаа, Амарсайхан сайд хөдөө аж ахуй хийгээд өнөөдөр бас нэг асуудал дээр 3 удаа мэдээлэл хийсэн. Та Ерөнхий сайдыг бодвол ЗГ-ын хуулийн ЗГ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу орж ирж байгаа байх л даа. Ер нь энэ өндөр хөгжилтэй парламент ёс хөгжсөн орнууд чинь Ерөнхий сайд нь тэр дээр ч биш, яг энэ өөдөөс харж суугаад, сөрөг хүчнийхээ лидерийн өөдөөс харж сууж байгаад, дээрээс нь өнгөрсөн хугацаанд гарсан алдаа оноо хийгээд, мөрийн хөтөлбөрөө ингээд мэтгэлцэж ярилцдаг байхгүй юу. Тэр индэр дээр суучхаад нэг мэдээлэл хийсэн болоод, тэгээд тэр нь бид нар нэг асуусан болоод, тэгээд нэг ийм өнгөрөөд байхлаар өнөөгийн байгаа байдал чинь ийм.

Нийгмийн суурь салбар болсон эрүүл мэнд, боловсролын энэ ийм чухал асуудлууд яригдаж байхад өнөөдөр Ерөнхий сайд байхгүй. Тэр огцрох ч байна уу, огцрохгүй ч байна уу одоо энд орж ирээд ярьж байх ёстой байхгүй юу. Ямар бэрхшээл боловсролын салбарт тулгараад байгаа юм. Бид ний нуугүй парламенттайгаа ярилцаад, хүндрэл нь юундаа байгаа юм, эрх зүйн орчиндоо байгаа юм уу, эдийн засаг, санхүү нь дутаад байгаа юм уу энэ бүгдийгээ ярьж байх

ёстой шүү дээ. Тэгээд нэг Шадар сайдыгаа оруулчихаад нэг мэдээлэл хийсэн болоод, нөгөөдөх нь нэг юм уншсан болоод. Өнөөдөр хөдөө орон нутагт байдал ямар байгаа юм. Багш нар байхгүй, ажиллах орчин байхгүй, үндсэндээ хөдөө орон нутагт англи хэлний багш, математикийн багш заасан нэртэй явж байна шүү дээ. Сая тойрогт ажиллаж байхад Өмнөговь аймгийн Цогтцэций сум Монгол Улсын хамгийн их төсвийг бүрдүүлдэг Өмнөговь аймаг энэ жилийнх нь төсөвт бүрдүүлэх орлого нь та нар бодоорой 1,7 их наяд. Тэгэхэд Цогтцэций сумд сургууль нь нэг сургууль нь нурчихсан. Борын нэрэмжит 1 дүгээр сургууль нь нурчихсан, аль 19 онд 6 жилийн өмнө тендер авсан тэр Грийн ресурс констракшн гэж хариуцлагагүй компани одоо хүртэл сургуулиа ашиглалтад оруулаагүй. 3 мянга гаруй хүүхэд подвал болоод анги танхим хэсээд 3 ээлжээр хичээллээд байж байна. Өнөөдрийн энэ мэдээллийн цаг дээр чинь нийт сургуулийн 66 хувь нь 2 ээлжээр хичээллэж байна гэж байгаа юм. Тэгвэл говьд Монгол Улсын говьд 3 ээлжээр хичээллэж байгаа газрууд зөндөө байж байна. Багш нар алга байна, хүрэлцэхгүй байна. Тэгээд ийм байж байхад ядаж өөрийнхөө цаг дээр орж ирээд жаргал, зовлонгоо яриад, парламенттайгаа энэ асуудлуудаа ярьж чадахгүй ийм л байна шүү дээ энэ Ерөнхий сайд.

Тэр одоо Ерөнхий сайд байхгүй юм чинь Боловсролын сайдаас асууя. Наранбаяр сайдаа Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг яаж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Энэ дээр дэгээрээ минут байхгүй. Наранбаяр сайд хариулт өгөх үү?

П.Наранбаяр: Тэгэхээр багшийн дутлын асуудал мөн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын өнөөдрийн сургуулийн байдлыг та ярилаа. Өнөөдөр яг энэ 2 ээлжээр хичээллээд олон ээлжээр хичээллэж байгаа энэ нийт бүлгүүдийн 88 бараг мянган, 88 хувь нь тийм байдалтай байгаа. Юуны хувьд таны хэлдэг үнэн. Энэ багшийн дутагдал нэлээн ноцтой хэмжээнд хүрсэн. Тэгэхээр бид ноднин жил 4500 орчим багшийн дутагдал байсан яг 9 сард. Ингээд 11 сард нь 1500 болсон. Тэгээд энийг арилгахын тулд 6 ийм багц арга хэмжээг ЗГ-ын тогтоолоор оруулаад хэрэгжүүлж байгаа. Цаашдаа энэ олон сургууль, цэцэрлэгийг шинээр бариад явахад 20 орчим мянган багш дутна гэсэн ийм тооцоо явж байдаг. Тэгэхээрээ энэ багшийн дутагдлыг арилгахын тулд орон нутагт ажиллаж байгаа багшийг дэмжих иж бүрэн бодлого хэрэгтэй. Бид орон нутагт багш, ялангуяа сумын түвшинд очиж ажиллавал шууд 40 хувийн нэмэгдэл болгож эхэлсэн. Энэ хүрээнд зарим хэмжээнд амжилттай явсныг үгүйсгэхгүй. Гэхдээ одоо сумд очоод ажиллаж байгаа багш нарт орон байр хэрэгтэй байна. Барилга, хот байгуулалтын яамтай яриад багш нарыг ипотекийн зээлд хамруулах, мөн орон нутагт очиж ажиллах ийм залуучуудад зориулсан, багш нарт зориулсан ийм байруудыг барьж байгуулах ийм шаардлага байгааг хэлье.

Юуны хувьд энэ Өмнөговийн энэ сургуулиуд энэ таны хэлж байгаа ийм тохиолдлууд байгаад байгаа. Тэгэхээр бид өнөөдөр 108 сургууль, 95 цэцэрлэгийг энэ ойрын хугацаанд 2028 оноос өмнө 26, 27 онуудад ингээд эрчимтэй барья гэсэн энэ бодлого бол энэ асуудлыг бүрэн шийдэхэд л чиглэж байгаа юм. Энэ асуудлыг бүрэн шийдэхэд. Мөн хуучирчихсан ийм барилгууд дээр бидний хийсэн тооцоогоор 79 ийм байршил дээр бид энэ хуучирсан сургуулиудыг бид шинэчлэхээр ингэж ярьж байгаа. 25 оны төсвийн хөрөнгө оруулалтаар байгалийн ухааны хичээлүүдэд зориулсан физикийн биологи, дизайн, технологийн 4 төрлийн лабораторийг бид нийт 2,9 тэрбум төгрөгөөр бий болгож санхүүжүүлэхээр ингэж явж байгаа. Монгол Улсын хаана ч сурсан, хүүхэд хаана ч энэ хичээлээ хийж байх, бүх ийм тохиолдолд

яг л тэгш хүртээмжтэй ийм боловсролын үйлчилгээг авдаг байх ёстой юм. Үүний төлөө л боловсролыг дэмжих жилийг бид зарлуулж ингэж хийж байгаа.

Мөн түрүүнд ярьж байна. Жил болгон л боловсролын жил байх ёстой гээд үнэн. Бид энэ нийт оруулж байгаа хөрөнгө оруулалт юмнууд чинь тийм их хэмжээний хөрөнгө оруулалт биш. Энэ бүрэн боломжтой. Жишээлбэл энэ эх үүсвэрээ яаж харж байна гэхээрээ боловсролын хөрөнгө оруулалтад шаардлагатай нийт 3,9 их наяд төгрөг байж байгаа. 26 онд бид төсвөөс 1,7 их наядыг нь, энэ 26 онд 1,7 их наядыг нь шийднэ. Үүний 1 их наяд буюу 58,8 хувийг улсын төсвөөс, 27 хувь буюу 460 тэрбум төгрөгийг нийслэл, орон нутгийн төсвөөс, 9,1 хувь буюу 160 тэрбум төгрөгийг Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээс шийдвэрлэхээр ингээд төлөвлөөд ажиллаж байгаа. Тэгэхээрээ шууд төсөв рүү ингэж дарамт орж ирнэ, нэмэгдлээ гэж хэлэх юм байхгүй. Бид ер нь дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 5,7 хувийг л юуны түрүүнд энэ боловсрол руугаа зарцуулъя. Тэгвэл 2030 он гэхэд 88 мянган хүүхэд нэмэгдэх гээд байгаа өнөөдөр сурч байгаа дээрээ, яг энэ ерөнхий боловсролын салбарт. Тэгэхээр энэ асуудлаа энэ боловсролыг дэмжих жилийнхээ хүрээнд ингээд шийдчихье гэсэн ийм юу яригдаж байгаа.

Мөн энэ жилийн хүрээнд бид шийдвэрлэх ёстой нэг зүйл бол багш ажилтнуудын цалин хангамжийн асуудал. Үндсэн цалинг өсгөх асуудал байгаа. Үйлдвэрчний эвлэлтэй ярилцаж байна. Цалин өсгөхөөр шууд инфляц юм шиг яриад байдаг. Тэгэхээр энэ дээр бид цалин бол өөрөө хөрөнгө оруулалт, хэрэглээг дэмжих, мөн салбарын асуудлыг шийдвэрлэх нэг хөшүүрэг гэж харж байгаа.

Тэгэхээр Цогтцэций сум 2 сургуультай байгаа. Эндээс ер нь сургуулийн барилга 2019 оноос эхэлсэн боловч ажил нь удаашралтай хэрэгжиж байгаа учраас цуцлах арга хэмжээг авсан. Гэвч шүүхдээд, шүүх дээр энэ асуудал нь шийдэгдэхгүй ингээд яваад байгаа ийм барилгын ажил удаашралтай байгаа. Тэнд олон 2886 хүүхэд төрийн өмчийн 2 сургуульд суралцаж байгаа нь үнэн. Үнэхээрийн нөхцөл байдал хүнд байгаа. Ингээд орон нутагтай ярилцаад энэ асуудлыг шийдэхийн тулд Боловсролын яам хамтдаа асуудлыг шийдэхийн тулд ажиллана гэдгээ энэ индэр дээрээс хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя. Дэгийн тухай хуулиар асуулт асуух нь 3 хүртэл, хариулт өгөх нь 5 минутаас тус тус хэтрэхгүй гээд Дэгийн тухай хуулиараа. Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр нэг багш нарын чадавхыг дээшлүүлж байж л бид нар хүүхдүүдээ илүү сайн мэдлэг, боловсролтой болгоно. Тэгээд энэ хүрээндээ яг энэ Ховд их сургуулийг илүү сайн сургалт сургууль болгохын төлөө ажлуудыг хийж эхэлж байгаа. 13 орчим тэрбум төгрөг тавьж 5 давхар оюутны орон сууц барьж байгаа. Энэний 3 давхарт нь оюутнууд байна. Дээд талын 2 давхарт нь 2 өрөө байруудтай. Тэн дээр нь сайн багш нар ирж ажиллах тэр боломжийг нээж өгнө. Ховд аймгаас аймгийн төсвөөс тодорхой хэмжээний цалинг нь илүү нэмэгдүүлж өгөх тэр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Ингэсний үр дүнд сайн багш нар Ховдод байртай, өндөр цалинтай ажиллах ийм боломжийг нээж өгөх юм. Энэ байр барих ажил маань 2 жилийн дотор дуусна. Энэний дараагаар орон нутгийн болон улсын төсвөөс үндсэн хичээлийн байр болон хуучин 2 оюутны байрыг засаж, илүү оюутнуудыг олон оюутан сургах тэр боломжийг нээж өгнө. Энэний дараагаар нэг хийх ёстой юм

оюутнуудыг тэтгэлэгтэй болгох тухай асуудал байгаа. Өөрөөр хэлбэл багшаар сурч байгаа оюутнууд бараг төлбөр төлөхгүй байгаа.

Тийм учраас оюутнуудыг тэтгэлэгтэй болгохын тулд ААН-үүдтэй хамтарч ажиллаж, баруун бүсийн сум болгоны бизнес хийж байгаа тэр хүмүүс Ховд аймгийн Ховд их сургуульд сурч байгаа баруун бүсийн их сургуульд сурч байгаа салбар сургуульд сурч байгаа тэр оюутнуудад тэтгэлэг өгөх энэ ажлыг хийнэ. Ховд их сургуулийг тусад нь бие даалгана. Ингэсний үр дүнд санхүүгийн өндөр чадавхтай одоо 400-гаад, уг нь бол маш их олон намайг Удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байхад 2 мянга гаруй оюутантай байсан, одоо 400-хан болсон байгаа. Энийг буцаагаад 4 мянга болгох ийм зорилтыг тавина. Ингэсний үр дүнд манай Ховд аймаг залуусын хот болох ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа гэдгийг хэлье.

2 дугаар асуудал нь боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлээд, үүний үр дүнд яг энэ хөтөлбөрийн үр дүнд нэлээн олон жил 12 оноос хойш Гантөмөр сайдын хийсэн тэр ажлаас хойш өнөөдрийг хүртэл тэрүүгээр нь мөлжөөд л ингээд явж байгаа. Өнгөрсөн хугацаанд Монгол Ардын намын 5, 6 сайд солигдсон. Одоо энэ боловсролын систем нуран унасан гэдэг ийм зүйл яривал Наранбаяр сайд тан дээр л юмнууд ирнэ шүү. Ер нь бухаад л өнгөрнө, манай эрх баригч нар бол коммунист үзэл суртлаараа ёстой гайхалтай сайхан хийнэ шүү дээ тэрийгээ. Тийм учраас бодолтой байгаарай гэж би танд зөвлөө.

Тэгээд 1 зүйлийг асууя ингээд chromebook хуучин Гантөмөр сайдын үед өгсөн dell, lenovo дээр багш нар ажиллаад сурчихсан. Тэгэхээр энэ chromebook-ийг нэлээн гайгүй үнэтэй8 дээрээс нь бүх нөгөө хайлтын аппликэйшнүүдийг нь бүгдийг нь үнэгүй хэрэглэх боломж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэгэхээр ер нь энэ багш бүрд компьютер, хүүхэд бүрд компьютер гэсэн ийм хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ЗГ-ын мөрийн хөтөлбөрт орчихсон, хөтөлбөрт нь орчихсон явж байгаа. Chromebook бол өнөөдөр яг энэ dell тэр бусад компьютероо бодвол хамаагүй хямд 2 дахин хямд ийм байгаа. Яг үнэ нь яг миний юун дээр 880 мянган төгрөгөөс 1 сая 50 мянган төгрөгийн хооронд chromebook байгаа, 1 ширхэг тийм. Тэгэхээр энэ нөгөө dell бусад юунаасаа хямд байгаа. Харамсалтай нь манай багш нар ажиллаж сураагүй. Яагаад гэвэл өөр дээрээ хардгүй учраас багш нар өөрсдийнхөө хичээлийг авч явах эд нар дээрээ үүлэн технологи дээрээ ажиллахад нэг жоохон нөгөө нэг юу гэдэг билээ нөгөө сануулдаг нөгөө юу нь дутдаг тийм ээ, датанууд нь. Тэгээд ийм нэг тал байгаад байгаа. Тэгэхээрээ бид энэ google-н иж бүрэн лицензийг ашиглаж байгаа энэ дээр. Яг ингээд бүрэн ашиглаад явах боломжтой. Chromebook бүрэн ашиглаад ингээд явбал энэ илүү хямд ийм шийдэл гэж харж байгаа юм. Зүгээр энэ дээр бид энэ давхар сургалтуудаа явуулах хэрэгтэй, багш нарыг сайн ажиллуулж сургах ийм шаардлагатай байна гэж харж байгаа юм. Зүгээр харахад тэр яг л компьютер шиг харагддаг ийм болсон байгаа. Тэгээд хэрэглэх программууд дээр нь зарим нэгэн программуудыг нь хаачихсан байгааг нь шууд багш хүн хэрэглэж болохуйцаар бүх программуудыг нь нээж өгөх ийм шаардлагатай байгаа гэж харж байгаа. Энийг google-тэй яриад явж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: ЗГ-аас, төсвөөс, Их Хурлаас ер нь сүүлийн жилүүдэд боловсролын салбарт төсөв мөнгөний тухайд нэлээн боломж бололцоогоороо дэмжиж ажиллаж байгаа. Гэхдээ 2019 оны энэ ЮНЕСКО-оос гаргасан үнэлгээний тайлангаас би нэг өгүүлбэрийг танд дахин уншиж, уншъя. Монголын боловсролын системд хэсэгчлэн өөрчлөлт хийх нь үр дүнгүй, эрс өөрчлөлт хийх шаардлагатай, үгүй бол илүү том сорилтуудтай нүүр тулна гэж тухайн тайлан дээр нэг дүгнэлт дээр гарч байсан байна лээ. Тэгэхлээр яг энэ зүйл болоод байна л даа. Төсвөөс, төрөөс мөнгө төгрөг анхаарал тавиад байдаг. Гэтэл яг бодит байдал яг энэ байгууллагын хэдэн жилийн өмнөх дүгнэлт яг бид нарт том суурь өөрчлөлт, зарчмын өөрчлөлт ирж байгаа энэ зах зээлийн тэр ачаа даалгаварт бид нийцэхгүй, тогтолцооны өөрчлөлтүүд бидэнд байхгүй байгаа учраас жишээ нь өнөөдөр нөхцөл байдал яг ямар байна вэ. Ажлын байран дээр их, дээд сургууль төгсөж байгаа залуучууд нь ажлын байран дээр шаардлага хангадаггүй. Нөгөө талд нь ажлын байр байгаад байдаг ийм нөхцөл байдалтай. Тэр мэргэжилтэй ажиллах хүч нь олон, олон салбарын бодлого дээр өөрчлөлт байдаггүй.

10 жилийн суурь боловсролын сургалтын үр дүнг үзэхэд PISA-аас ноднин жил гаргасан PISA-ийн үнэлгээ дээрээс би гуравхан тоо л дурдъя. 3 хүүхэд Монголын 9 дүгээр ангийн 3 хүүхэд тутмын 2 нь уншсанаа ойлгох чадваргүй байна. Монгол Улсын 2 хүүхэд тутмын 1 нь байгалийн ухааны хичээлд хангалтгүй дүн авч байна. Хангалттай дүн авч байгаа хүүхэд нь 100 хүүхэд тутамд 2-хон хүүхэд байна буюу ижил түвшний Вьетнам зэрэг орнуудаас манайхаас бага мөнгө зарцуулж байгаа. Төсвийнхөө бага хувийг манайхаас зарцуулж байгаа орнуудаас танай Монгол Улсын энэ 9 дүгээр ангийн хүүхдүүдийн үнэлгээ чинь ийм доошоо орчихлоо буюу дунд сургуулийн тогтолцоог бидний яг бодит олон улсын үнэлгээ нь ингээд гарчихсан.

Тэгэхлээр эндээс бид нарт тэр ЮНЕСКО-ийн хэсэгчлэн өөрчлөлт хийх биш, энэ томоохон өөрчлөлт хийхгүй бол том сорилтуудтай нүүр тулна гэж байсан маань хөдөлмөрийн зах зээл дээр илрээд эхэлчихлээ. Олон улсын үнэлгээ, дүгнэлтээр илрээд эхэлчихлээ. Тэгэхээр энэ дээр яг ямар бодол саналтай, яагаад ийм суурь асуудал руугаа, тогтолцоо руугаа ингэж хандахгүй нэг л төсөв, төлөвлөгөө, Улсын Их Хурлаас мөнгө батлах ёстой гэдэг хандлагаар л яваад байдаг. Энэ дээр нэг тодорхой бодлогын ямар бэрхшээл байдгийг нь тайлбар өгмөөр байна. Уг нь энэ ЗГ-аас Монгол Улсын боловсролын тогтолцоонд хийх ажил бол жинхэнээсээ тэр 14 мега төслийн чинь хамгийн эхэнд нэгд эрэмбэлэгдэх ёстой мега төсөл уг нь энэ боловсролын салбарт л байсан. Саяын суурь өөрчлөлтүүдийг бид нараас нийгэм нөхцөл байдал бид нараас нэхээд байна.

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайдад хариулт өгье.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр яг л хэсэгчилж хэсэг бусгаар нь биш, яг ингэж системтэйгээр шинэчлэл хийх шаардлагатайг та яг хэлж байна. Ийм шаардлага байна. PISA-ийн шалгалт 2022 онд ингэж Монголд болсон. Энэ дээр Монгол Улсын хүүхдийн математикийн ур чадвар 425 оноо байсан байгаа юм. Энэ нь OECD-н орнуудын дундаж 472, Азийн дундаж нь 451. Унших чадварын хувьд 378 оноо авсан нь OECD-н 476 оноо, Азийн дунджийн тэр 427 онооноос доогуур байгаа юм. Байгалийн ухааны чадвар 412 оноо авсан нь OECD-н орнуудын дундаж нь 485, Азийн дундаж 449 ийм байдалтай байгаа. Тэгээд яах вэ PISA-н шалгалтаар энэ ингээд гарсан энэ дүнгийн хүрээнд бид энэ унших чадварыг сайжруулах чиглэлээр

нэлээн ажиллаж байгаа. Тэгээд ер нь энэ боловсролын салбарт 6 ийм иж бүрэн шинэчлэл явуулж байгаа.

1 дүгээрт хөтөлбөр. Энэ бол сургалтын хөтөлбөрийг яг энэ Боловсролын ерөнхий хуулиараа нэг хүүхдийн сурах 10-аас 12 жил нь цикл дотор нь өөрчилнө гэсэн ийм хуулийн заалттай. Тэгэхээр 2014 оноос хойш өөрчлөгдсөн энэ цөм хөтөлбөр маань ингээд 2025, 2026 онд өөрчлөх цикл рүүгээ ороод явж байгаа. Энэ жил бид нар энэ хөтөлбөрөө шинэчлэхдээ бага сургууль дээр ялангуяа унших чадвар луу нь илүү оруулж байгаа. Унших чадвар гэдэг нь нөгөө минутаар уншдаг асуудал ерөөсөө биш, уншсанаа ойлгодог, ойлгосноо хэрэглэж чаддаг ийм чадварыг хэлж байгаа. Ингээд хөтөлбөрийн шинэчлэл ингээд явагдаж байна. Үнэлгээний шинэчлэл, тэгш хүртээмжийг бий болгох хүртээмжийн шинэчлэл, цахим шилжилт, багшийн хөгжил, ингээд цалингийн ийм шинэчлэлүүд гэсэн ийм иж бүрэн, багшийн багш руу чиглэсэн багшийн 3 тулгуурт бодлого эд нар гээд энэ боловсролын иж бүрэн ийм 6 ийм бодлогыг явуулж байгаа.

Гэхдээ энэ бүхний үндэс цаана нь юу байна вэ гэхээрээ зэрэг ерөөсөө л явж, явж сурлагын боловсролын чанар, хүртээмж, багшийн энэ сэтгэл ханамж, мөн багшийн чадвартай их холбогдоод явж байгаа. Тэгэхээрээ энэ асуудлуудыг бид мэдээж иж бүрнээр нь шийдэхээр ингэж ажиллаж байна. Ер нь математик чадварыг сайжруулахын тулд eduten гэх мэт дэлхийн шилдэг ийм хөтөлбөрүүдийг оруулж ирээд ажиллаж байна. Англи хэлний чадварыг сайжруулахын тулд бид pearson хөтөлбөрийг нэвтрүүлж байна. Ийм ажлуудыг хийж байна.

Энэ 25 оны 3 дугаар сарын 5-ны өдрөөс 5 дугаар сарын 16-ны хооронд PISA-ийн 2 дахь шалгалтад Монгол Улс орсон. Энэ 26 оны 12 дугаар сард энэ мэдээ нь гарна. Ингэхээр бид юугаа сайжруулж чадсан байна, юугаа хийж чадаагүй байна вэ гэдэг энэ асуудлууд эндээс гараад ирнэ. Тэгэхээрээ цахим шилжилт бол хүртээмж, сургалтын амжилт, менежментийг сайжруулахад чиглэж байгаа. Өнөөдөр Мэдлээ сургууль дээр ойролцоогоор 36 мянган ийм хичээл байж байна. Энүүгээр ингээд ахлах сургууль сонголтынхоо хичээлүүдийг үзээд явах ийм боломжтой.

Тэгээд түрүүн би 5 шинэчлэлийг хэлсэн. 6 дахь шинэчлэл нь энэ гүйцэтгэлд суурилсан ийм санхүүжилтийн систем байгаа. Бид зөвхөн PISA-аар 3 жил тутамд боловсролынхоо чанарыг хэмждэг биш, гүйцэтгэлийнхээ үнэлгээгээр ингээд жил болгон өөрсдийнхөө сурлагын чанарыг, багшийнхаа чанарыг давхар хэмжээд явдаг. Сая энэ жил гүйцэтгэлийн үнэлгээ бүрэн явж дууссан. Энэ жилийн хувьд бид цахим шалгалтын журмаар энэ гүйцэтгэлийн үнэлгээгээ хийж дууссан. Тэгээд түүврийн, түүвэрт 700 сургууль орсон, 29689 багш оролцсон, сурагчийн тоо нь 854507 байгаа. Тэгээд ийм байдлаар яваад, ерөнхийдөө бидний энэ гүйцэтгэлийн үнэлгээгээр хийгээд байгаа энэ үнэлгээнүүд энэ зүйл PISA-гийн гараад байгаа энэ ерөнхий энэ дүнтэй мөргөдөг ийм байгаад байгаа. Тэгэхээр зэрэг бид энэ боловсролыг иж бүрнээр нь шинэчлэх ийм ажлыг хийгээд явж байгаа гэдгийг та бүхэнд хэлье. Мөн энэ зарим нэг энэ яг хэсэг бусад яг энэ хэсэг дээр нь л шинэчлээд, бусдыг нь хаяад байна гэсэн ийм гаргаж байгаа бол бид тусгай судалгаа, тайлангаа танд явуулж тайлбарлахад бэлэн байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Би 3 асуулт асууна. Асуултаасаа өмнө Наранбаяр сайд энэ сургалтын хөтөлбөрт энэ хүний эрхийн чиглэл дээр их анхаарч байгаа, энэ

чиглэлээр сурах бичиг хийж байгаад би талархал илэрхийлмээр байна. Яагаад гэхлээр боловсролын асуудал гэдэг улс орны суурь асуудал бөгөөд энэ хүний эрхтэй салшгүй холбоотой. Тэр ч утгаараа бид эрдмийн хэт цахиваас хөгжлийн гал бадарна гэсэн ийм философитой байдаг ард түмэн.

Тэгээд 2 дугаарт нь болохоор энэ цэцэрлэгийн хүүхдийн нөгөө 2475 төгрөг байсан зүйл дээр Улаанбаатар хотод эцэг, эхээс нь мянган төгрөг нэмэгдүүлнэ гэж байгаа. Хөдөө орон нутагт энэ асуудал бүрэн шийдэгдээгүй. Ойролцоогоор 7 орчим мянган төгрөг байхад яг энэ шаардлагатай шим тэжээлийг авах боломжтой гэж үзэж байгаа. Энийг үе шаттайгаар ахиулмаар байгаа.

Асуулт 1.Боловсролын ерөөсөө энэ хүртээмжийн ялгаа бол хамгийн том асуудал болчхоод байгаа юм. Бид нар ингээд боловсролтой холбоотой төсөв ч гэдэг юм уу ярихаар аль нэг сумын сургуулийн байр, дотуур байр ч гэдэг юм уу ингээд хатуу дэд бүтцийн асуудлууд яриад байдаг. Гэтэл яг энэ тэгш хүртээмжийн ялгааг бууруулах чиглэлээр ямар бодлого ер нь явж байгаа юм бэ? Ямар хугацаанд, ямар үр дүн гаргах бодлого явж байгаа юм бэ? Жишээлбэл манай Төв аймаг, Дархан, Сэлэнгийн хувьд 24-өөс 25 оны хичээлийн жилд 69369 хүүхэд 1-ээс 12 дугаар ангид суралцсан. Бүх хүүхдэд захиа бичсэн 4 мянга гаруй хариу авсан. Нийт 4 мянган захианд хариу бичсэн хүүхдийн 70 орчим хувь нь сургууль орчмын аюулгүй байдал, дээрээс нь тэр дэд бүтэцтэй холбоотой саналуудыг ирүүлж байгаа жишээтэй. Тэгэхээр энэ асуулт байна.

2 дугаарт нь яг энэ сургуулийн дэд бүтэц улсын хэмжээнд ер нь бүтэн шийдэхэд дундын хугацаандаа ямар хэмжээний санхүүжилт хэрэгтэй бөгөөд энэ онд хэчнээн нь, аль, хэчнээн хувь нь энд орж чадаж байгаа вэ? Мөн чанар хүртээмжийн харьцаа, өөрөөр хэлбэл боловсролын төсвийн хэчнээн хувь нь яг энэ чанарыг ахиулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа вэ? Нөгөө талаасаа хэчнээн хувь нь яг энэ дэд бүтцэд чиглэж байгаа вэ? Энэ харьцааг мэдмээр байна.

3 дугаарт боловсролыг дэмжих жил гэж яваад байгаа. Ерөнхий байгаад байна, энийг сайдууд өмнө нь хэлсэн. Тухайлбал яг энэ чанар хүртээмжийг ахиулах жил ч гэдэг юм уу, яг тодорхой, магадгүй багш нарын нийгмийн асуудлыг шийднэ ч гэдэг юм уу яг ийм тодорхой зорилтуудыг тавимаар байгаа юм. Ерөнхий байвал их ойлгомж муутай байгаад байна.

Дараагийн асуудал нь болохлоороо энэ ДНБ-ээрээ тэргүүлж байгаа 10 орон тутмын 8 нь боловсролын реформыг амжилттай хийсэн орнууд байгаа. Тэгэхээр таны хувьд яг энэ боловсролын реформыг хийх тулгуур 3 үзүүлэлтийг юу гэж харж байна вэ? Эдгээр асуултуудыг асууя.

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд хариулт өгье.

П.Наранбаяр: Энэ маш оновчтой ийм асуулт тавьж байгаад баярлалаа. Тэгэхээрээ бид энэ хүний эрхийн чиглэлээр сурах бичиг лавлах ийм материалуудыг, гарын авлагыг гаргахаар яг ажлаа эхлүүлээд явж байна. Мөн энэ жил сургуулийн өмнөх боловсролд нийслэлд мянган төгрөгийг эцэг, эхээс ингэж төлүүлж эхэлсэн нь эерэг үр дүн авчирсан. Ялангуяа цэцэрлэгийн хүүхдүүдийн ирцийн бүртгэл эрс сайжирсан. Мөн эцэг, эхчүүдийн цэцэрлэгийн үйлчилгээнд тавьж байгаа хяналт, мөн цэцэрлэгийн өөрөө удирдах зөвлөл сургуулийн зөвлөлүүдийн ийм юу удирдлага сайжирсан ийм эерэг үр дүн гарч байгаа гэдгийг танд дуулгая. Цаашдаа

бид энэ боломжтой аймгийн төвүүд дээр, зарим нэг хотууд дээр энэ бодлогыг хэрэгжүүлээд явна гэж үе шаттай явуулна гэж ингэж үзэж байна.

Хүртээмжийн ялгааг бууруулах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухайд хувьсах зардлын бүрэлдэхүүнд сургуулийн орчинд хүүхэд хамгааллын зардлыг тусгасан байгаа. Хүртээмжийн ялгааг арилгахад 1 дүгээрт бид түрүүнд яриад байгаа сургуулийн хүртээмжийг Монгол Улсад хүүхэд хаана сурах нь хамаагүй сайн багшаар, сайн сургуульд суралцах ийм боломжийг л хангах ёстой. Хамгийн сайн сургууль гэрийн ойр сургууль байх энэ бодлогыг хэрэгжүүлэх юм. Энэ хүрээндээ бид энэ сургуулийн хүртээмжийг бүрдүүлэх хөрөнгө оруулалтыг шийдчихье л гэж ингэж яриад байгаа. Энэ яахад бол нийтдээ 3,9 их наяд төгрөг энэ 2 дугаар асуудалтай их холбоотой зөвхөн хөрөнгө оруулалт дээр бид тооцож байгаа. Үүнээс эхний жилд нь 1,7 их наяд төгрөг хэрэгтэйгээс улсын төсвөөс 1 их наядыг нь, тэгээд үлдсэнийг нь нийслэлийн болоод орон нутгийн төсвөөс, тэгээд 160 орчим тэрбум төгрөгийг бид Дэлхийн Банк болон Азийн хөгжлийн банкны ... буюу Монгол Улсад үзүүлэх хөнгөлөлттэй зээлийн хүрээнд шийдэх ийм боломжтой гэж харж байгаа.

Боловсролын бид чанарын ялгааг арилгахад энэ цахим шилжилтийг ихээхэн ач холбогдолтой гэж харж байгаа. Энэ цахим шилжилт бол орон зайн дарангуйлалд үл өртөж, хүүхэд өөрийнхөө үзье гэсэн хичээл энэ зүйлүүдийг шууд үзэж харж ингэж болох ийм зүйл гэж харж байгаа. Мөн IA буюу хиймэл оюуны хичээлд ашиглах тал дээр бид зөвлөмж, чиглэл өгч явуулах нь зүйтэй гэж харж байгаа. Гагцхүү хөдөө орон нутагт ялангуяа алслагдсан сумдад интернэтийн хурдны асуудал байдаг. Энийг яаралтай шийдвэрлэхээр бид энэ Цахим хөгжлийн яам, мөн Сонгуулийн ерөнхий хороо зэрэг Старлинк ашигладаг газруудтай хамтран ажиллаж захаасаа шийдэж байгаа. Энэ дээр энэ Улсын Их Хурлын дарга их санаачилгатай ажиллаж, манай яамтай хамтран ажиллаж байгааг энд цохон тэмдэглэе.

Юуны хувьд тодорхой зорилтуудыг та 3 дахь асуулт асууж байна. Боловсролын реформд мэдээж тэгш хүртээмж, багшийн хөгжил, хамгийн чадварлаг хэсэг нь багш болдог ийм л боловсролын салбартай болох хэрэгтэй. Агуулга буюу хөтөлбөрийн энэ шинэчлэлийг би хамгийн ач холбогдолтой гэж харж байна. Сайн хөтөлбөр, сайн багш, яг тэгш хүртээмжтэй ийм сургуулийн орчин, аюулгүй орчин энийг шийдчихсэн байгаа цагт бид энэ ер нь ойрын 4, 5 жилдээ, цаашдаа энэ боловсролын тал дээр илүү өндөр түвшний, илүү чанарын, илүү ирээдүйг харсан ийм шинэчлэлийг ярих ийм боломжтой болно гэж ингэж харж байна.

Таны хэлдэг яг үнэн. Яг боловсролын чиглэлээр хөрөнгийг нь оруулчихсан ийм улсууд хамгийн сайн хөгждөг. Ер нь өнөөдөр хэрвээ бид боловсролдоо сайн хөрөнгө оруулж чадсан бол өнөөдрийнхөө эдийн засгийн өсөлтийг ямар ч байсан 20-оос 30 функтээр өсгөчихсөн байх ийм боломжтой байсан гэдэг нь судалгааны үр дүн гардаг. Хүүхдийн хоолыг түрүүн би хэлсэн. Иймэрхүү байдлаар хариулъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Боловсролын салбарын асуудал дээр ерөнхийдөө 2017 оноос хойш л миний ярьж байгаа ганцхан сэдэв байгаа. Энэ бол багшийн цалинг нэмэх гээд. Өнөөдөр мянган сургууль барилаа гэж ярина, ярьж байна. Сая 200 гаруй сургууль, цэцэрлэг нэмж барьж байна гээд. Энэ сайн хэрэг, энийг би үгүйсгээгүй. Тэгээд энэ барьж байгаа сургууль, цэцэрлэгүүд

чинь ажиллах боловсон хүчин байна уу? 20 гаруй мянган багшийн дутагдалд орно гээд сая Наранбаяр сайд хэлж байна шүү дээ. Тэгэхээр бид нар энэ Монгол Улсын ЗГ-аас 2026 оныг боловсролыг дэмжих жил болгоно гэсэн энэ сайхан юу гаргалаа шүү дээ санаачилгыг. Тэгэхээр сая манай Эрдэнэболд гишүүн зөв санаачилга гаргаж байна л даа. Нэг тийм ерөнхий байна, яг юу руу чиглэсэн тийм тодорхой амлалт баймаар байна гэж байна. Тэгэхээр ер нь боловсролын энэ 26 оны боловсролыг дэмжих жилийг багш нарынхаа, багш ажилчдынхаа нийгмийн асуудлыг сайжруулна гэсэн ийм бодитой бөгөөд тодорхой зорилго тавихгүй юм бол зүгээр л нэг дэмжинэ, тэгнэ гээд бид сүүлийн 30 жил дандаа нэг ийм үлгэрийн юм ярьж явлаа шүү дээ. Тэгэхээр энэ боловсролын салбар дээр багшийн хомсдоллоо яаж арилгах гээд байгаа юм бэ гэхээр сургууль, цэцэрлэг яриад байх юм. Улам л багшийн хомсдолд орно шүү дээ. Сургууль, цэцэрлэгийн барилга нэмлээ гээд багшийн хомсдол арилахгүй. Багшийн хомсдолыг юугаар арилгах вэ гэхээр багшийн цалин хөлсөөр л арилгана. Багшийн цалин хөлсөө яаж нэмэгдүүлэх юм бэ, ямар бодлого барих юм бэ гэдгээ л яримаар байна бүгдээрээ.

Тэгээд нөгөө өмнө нь би Байнгын хороон дээр хэлж байсан. Дандаа л нэг тийм тулга тойрсон байгаа оноогүй юм л яриад байна бид. Одоо яг нэг бодитой 2026 оныг үнэхээр боловсролын жил болгоё гэж бүгдээрээ хүсээд байгаа бол тэр багш нарын хүсээд байгаа Монголын мянга мянган багш нарын хүсээд байгаа цалинг нь мянган долларт хүргэ. Тэгээгүйгээр өнөөдөр 1 сая 400 мянган төгрөгийн цалин өгөөд, гар дээрээ 900 мянган төгрөгийн цалин авч байгаа энэ боловсролын салбар чинь боловсон хүчний хомсдолд орчихлоо. Сайн чанартай хүүхдүүд ирэхээ больсон. Хамгийн сурлага муутай хүүхдүүд л энэ багшийн сургуулийг сонгож орж байгаа үнэн шүү дээ. Энийг нуугаад байх юм ерөөсөө байхгүй.

Дараа нь энэ багш нараас ирж байгаа маш олон саналууд байгаа, 20 гаруй санал байна. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын улсын төсвийн дутуу баригдсан 960 хүүхдийн сургуулийг 2026 онд багтааж яг дуусгах уу гэдгийг Наранбаяр сайдаас асууя. Та өмнө нь дуусгана гэж ярьж байсан. Тэгээд 2026 онд энэ багтаж дуусах уу? Нэг сургууль нь нураад уначихсан, одоо ерөөсөө дэгэн догонттой хүнд байна гээд багш нар яриад байна. Танд ч гэсэн энэ юу чихэнд чинь очсон байх гэж бодож байна. Тэгээд багш нарынхаа нийгмийн асуудлыг л ярья. Хэдүүлээ нэг их худлаа хиймэл оюун ухаан, сансрын, сансрын юм битгий ярь, хөрсөн дээрээ буусан юм, амьдралтай юм ярья гэж би бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд хариулт өгье.

П.Наранбаяр: Юуны хувьд бид энэ Мөнхтуяа гишүүний хэлээд байгаа энэ цалин өсөх асуудлыг бүгд дэмжиж байгаа. Өнөөдөр энэ цалингийн өсөлтийг эсэргүүцэж байгаа хүн их ховор. Зүгээр юуны хувьд өнөөдөр байж байгаа энэ цалинг өсгөхийн тулд бид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтайгаа, гэр бүлийнхээ энэ яамтайгаа ярилцаж, Засгийн хэмжээнд нь шийдэх ёстой. Энэ жил 6 хувиар үндсэн цалин өссөн. Би үндсэн цалинг өсгөх ёстой гэдэг хатуу байр суурьтай байгаа. Үндсэн цалинг ер нь 2028 он гэхэд таны хэлээд байгаа мянган доллар буюу 3 сая руу оруулж ирэх, 3,4 сая руу оруулж ирэх ийм боломжийг бий болгох нь зүйтэй гэж. Энэ бол өөрөө эдийн засгийнхаа өсөлттэй уялдаж явдаг ийм тоо. Тэгэхээр ер нь үндсэн цалинг нь өсгөж байж, чадварлаг ийм боловсон хүчин энэ салбар луу орж ирэх таны энэ хэлээд байгаа санаатай би 100 хувь санал нэгдэж байна. Үндсэн цалинг нь өсгөхгүй бол өнөөдөр энэ жилийнхээ 6 хувийн нэмэгдэлтэйгээ 1 сая 485 мянга л болчихсон үндсэн цалин нь. Ийм нөхцөл байдалд байгаа. Жил бүр бид 6 хувиар

нэмэгдүүлнэ гэж үзвэл нэмэгдлүүдийг нь нэмсэн дүн шүү нэмэгдлүүдийг нь үндсэн цалинг яриагүй байна, үндсэн цалингаар нь хэлээгүй байгаа гэдгийг би дахин хэлье. 2028 онд багшийн гар дээр очих цалин тухайн багшийн ажилласан жил гүйцэтгэл байршлаасаа хамаараад 2,6-аас 3,5 сая төгрөгийн хооронд болохоор байна. Энэ дээр би нэмэгдлүүдийг нь орон нутгийн нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл гээд бүгдийг нь нэмж хэлж байгаа шүү. Ийм нөхцөл байдалтай байна. Гэхдээ бид үндсэн цалинг нь нэмэгдүүлж байж л энэ салбарт чадварлаг боловсон хүчин орж ирнэ гэдгийг дахин хэлье.

Цогтцэций сумын энэ сургуулийн тухайд орон нутгийнхаа төсвөөр нэг сургууль барьж байгаа 960 хүүхдийн суудалтай. Нөгөө сургуулийнх нь тухайд шүүхдээд явж байгаа юм. Энэ шүүхийн шийдвэр нь ямар, хэзээ гарах нь яг хэлэхэд хэцүү байна. Бид Улсын Их Хурал ингээд 26 оныхоо төсвийг ярилцахдаа энийгээ баталж чадвал 26 ондоо энэ сургуулийг бүрэн ашиглалтад оруулах боломжтой гэж харж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.11-д заасны дагуу намын бүлэг тус бүрээс гишүүн төлөөлж Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн асуултуудыг асууна. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Их Хурлын гишүүн Цэндсүрэнгийн Мөнхтуяа асуулт асууна. Асуулт хариулт 20 хүртэл минут үргэлжилнэ.

Ц.Мөнхтуяа: D.parliament дээр байрласан багш нарын асуултуудыг сонсгоё. Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дээр 2024 онд зохион байгуулагдсан Монголын багш нарын 8 дугаар их хурлын мянга гаруй төлөөлөгчид санал нэгтгэйгээр багш нарын тэтгэвэрт гарах насыг өөрөө хүсвэл эмэгтэй 50, эрэгтэй 55 настай гарч болдог хуулийн зохицуулалт шаардлагатай байгааг онцолж тус их хурлын шийдвэрт тусгасан. Үүнийг хэрэгжүүлэх талаар ЗГ-аас ямар арга хэмжээ авч байна вэ гэдгийг би Амарсайхан сайдаас асууя?

2 дугаарт багш нарын үндсэн цалин 50 хувиар нэмэх шаардлагатай байна. Гүйцэтгэл багш нарын нэр хүндийг унагааж байгаа тул нэг ангид суралцах сурагчдын тоогоор анги даалтын мөнгийг өгөх боломжтой юу гэсэн асуулт байна. Энийг Наранбаяр сайд хариулах байх.

Боловсролын салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх үндсэн гарц бол дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 4,7 хувь байгааг 7 хувьд хүргэнэ. Эсвэл төсвийн нийт зардлын 13 хувийг 20 хувьд хүргэх явдал юм. ЗГ боловсролыг дэмжих жил 2026 оны хүрээнд энэ чиглэлд бодитой ажил хиймээр байна. Энэ чиглэлээр ямар ажил хийгдэх вэ гэдгийг Амарсайхан сайдаас асууя.

Бямбадаш гэдэг багш асуусан байна. Монголын багш нарын дийлэнх нь орон сууцын нөхцөл маш тааруу, хөнгөлөлттэй зээлийн орон сууцад орох хүсэлтэй байдаг. Гэвч цалин хөлс багаас шалтгаалаад ипотекийн зээлийн шаардлага хангахгүй байна. Иймд ЗГ-аас багш нарт зориулсан үнэ хямд, хүү бага, урьдчилгаагүй орон сууцжуулах талаар ямар хөтөлбөр хэрэгжүүлж байна вэ гэсэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүн хэдэн асуулт байгаа вэ нийт?

Ц.Мөнхтуяа: 10-аад асуулт байна. Би ингээд багцлаад 5-ыг л асуучихъя. Анхбаяр гэдэг багш асуусан байна. Үндсэн цалингаа нэмбэл өөр давхар ажил хийх шаардлагагүй болж, үндсэн ажилдаа анхаарлаа бүрэн хандуулж чадна. Улмаар сурлагын чанар эрчимтэй сайжирна гэж бодож байна. Одоогоор цалин мөнгө хаанаа ч хүрэхгүй байдаг учир багш нар нэмэлт орлого олох гэж зүдэрч байна. Ажлаасаа гарч, өөр ажил хийх хүсэлтэй болон шийдвэр гаргасан багш нар маш их байна. Энэ тал дээр ямар бодлого барьж ажиллах вэ гэсэн байна.

Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт гэж нэг маш их алдаа завхралтай юм явагдаж байна. Энэ гүйцэтгэлийн үнэлгээг үндсэн цалин руу оруулах арга хэмжээг авч өгөөч. Ингээгүй тохиолдолд багш нар бараг намар ажил хаялт хийнэ гэсэн шүү. Энэ гүйцэтгэлийн үнэлгээ дээр чинь.

Багш нарын цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах, ажиллах боломж нөхцөлөөр хангах, техник хэрэгсэл, интернэт сүлжээг чанартай, хүртээмжтэй болгох, сургуулийн төсөв, түүний зарцуулалтыг нээлттэй, ил тод болгох, сургуулийн удирдлагыг 5 жил тутамд аттестатчилан сэлгэн ажиллуулдаг байх шаардлагатай байна. Эдгээр асуудлын хүрээнд ямар арга хэмжээ авч ажиллах вэ гэсэн байна. Ийм 5 асуултыг тоймлоод асууя.

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайдын микрофоныг өгье.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ иргэдээс ирсэн асуултыг хариулъя. Багш нарын их хурлын тухайд бид энэ дээр Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор 24 онд байгуулагдсан энэ хурлын үеэр багш нар 50-аас 55 наснаас ингээд тэтгэвэрт гарах боломжтой болгох хуулийн зохицуулалтын талаар ярилцсан. Энэ яах вэ энэ чинь тэтгэврийн насыг тусгай хуулиар зохицуулдаг, тэгээд багш нар энэ 50 болон 55 наснаас сонголттойгоор шүү дээ энэ чинь яг шууд биш тийм ээ, хүсвэл өөрөө хүсвэл гэсэн байгаа. Тэгэхээр энэ Үйлдвэрчний эвлэл болоод холбогдох талуудтай бид хамтраад судалгаагаа хийгээд явж байна. Тэгээд багшийн ажлын норм нормативыг шинэчлэх судалгааг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн дээр эхлүүлчихсэн байгаа. Багшийн туршлага, мэргэжлийн зэргээс шалтгаалаад норм нормативыг шинэчлэн тогтооно гэж.

2 дахь асуултын тухайд энэ багшийн орон сууцын асуудлыг та хөндөх шиг боллоо. Энэ тэгэхээрээ бид энэ орон сууцыг ипотекийн зээлд хамруулахаар энэ чинь хуулийн заалттай. Тэгэхээр бид энэ орон сууцыг ипотекийн зээлд хамруулахад онцгой анхаарах ёстой гэж харж байна. Юуны хувьд багшийн нийгмийн асуудлыг бид үе шаттайгаар шийдэхдээ ЗГ-аас 25 онд иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд 13 мянга орчим иргэдийг ийм ипотекийн зээлийн хөтөлбөрт хамруулах, түүнээс 50-аас доошгүй хувийг орон нутагт олгоход зориулаад улсын төсвөөс 123,5 тэрбум төгрөгийг, бусад эх үүсвэрээс 1,3 их наяд төгрөгийг зарцуулахаар тусгасан. Орон нутгийн ипотекийн 3 хувийн зээлийг үргэлжлүүлэн олгож, амины орон сууцыг ипотекийн зээлд хамрагдах боломжтой болгохоор ажиллаж байгаа.

3 дахь асуулт нь цалин хүрэхгүй байна. Энэ гүйцэтгэлийн үнэлгээгээ үндсэн цалиндаа шингээж болохгүй юу гэсэн ийм асуулт. Тэгэхээр энэ гүйцэтгэлийн үнэлгээг шингээх ийм судалгааг бид хийж үзсэн. Тэгээд гүйцэтгэлийн үнэлгээнд оролцсон бүх багш нарт ямар ч байсан 5 хувийн ийм нэмэгдлийг нь олгодог болчихъё гээд ингээд ярилцаж үзсэн боловч зарим нэг яг энэ санхүүгийн асуудал

хариуцсан байгууллагатайгаа тохиролцож чадаагүй гэдгээ хэлье. Зүгээр энэ гүйцэтгэлийн үнэлгээг ор тас шууд үгүйсгэж болохгүй. Энийг харин илүү хялбар, нүсэр биш ийм төсөр болгох тал дээр ийм шинэчлэлийг бид хийж байгаа. Ирэх намар гэхэд гаргаад ирнэ. Энэ жил бид анх удаа бүрэн цахимаар зохион байгуулсан. 6 дугаар ангиас дээших энэ шалгалтууд цахимаар зохион байгуулагдсан. Цаашдаа илүү багшдаа таатай, хүүхдүүддээ ч ээлтэй ийм байдлаар зохион байгуулж, илүү сайн гүйцэтгэлтэй байгаа багш нарыг урамшуулдаг энэ тогтолцоогоо үргэлжлүүлэх шаардлагатай гэж харж байгаа.

Харин багш хүн ажилласныхаа төлөө, ажлаа хийчихсэн л юм чинь энэ гүйцэтгэлийн үнэлгээнээсээ тодорхой хэмжээнд тэгш хүртэх ёстой гэдгийг би тантай санал 100 хувь хуваалцана.

Юуны хувьд үндсэн цалингаа нэмэгдүүлье, цалингаа нэмэгдүүлье гэсэн энэ шаардлагын тухайд бүрэн ойлгож байгаа. Багшийг энэ цалинг нь нэмэхгүй бол энэ салбар өөрөө сайн багшгүй болох гээд байна шүү. Улсын Их Хурлын гишүүдээ энэ ирэх төсөв дээр цалин нэмэх асуудлыг дэмжээд өгөөрэй. Боловсролыг дэмжих жилийн хүрээнд боловсролынхоо, багш нарынхаа хөгжлийг дэмжих жилийн хүрээнд та бүхэн энэ салбарын үндсэн цалинг нь нэмэгдүүлэх тал дээр та бүхэн маань анхаараад өгөөрэй. Ерөөсөө бусад салбартай харьцуулахад манай энэ салбар чинь доогуур байгаа шүү гэдгийг би хэлье. Ийм нөхцөл байдалтай байгааг манай судалгаа харуулдаг.

5 дахь асуудал нь, уучлаарай юу ярилаа. 5 дахь асуудал нь, 4, 5 нь нийлээд ингээд хариулчхаж болж байгаа байх. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхтуяа: Наранбаяр сайдаа гүйцэтгэлийн үнэлгээг багш нар буруушаагаад байгаа шүү дээ, болохгүй байна гээд. Тэгэхээр та гүйцэтгэлийн үнэлгээ байлгана гэж яриад байх юм. Гүйцэтгэлийнхээ үнэлгээг болио, болиулаач гэдгийг маш олон багш нар шаардаж байгаа шүү дээ. Ер нь манай энэ групп дотор яг энэ гүйцэтгэлийн үнэлгээгээр л шаагаад байгаа. Тэгэхээр энэ дээр та мэдрэмжтэй хандаад, судлаад байна, судлаад байна гээд л бараг бүтэн жил ярилаа шүү дээ. Тэгэхээр энийгээ нэг чиг рүү нь хандуулахгүй бол багш нар энэ намар ажил хаялт хийнэ гэж байна лээ шүү. Энэ гүйцэтгэлийн үнэлгээгээр.

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Энэ гүйцэтгэлийн үнэлгээг бид журмыг нь шинэчилж байгаа. Тэгэхээрээ жишээлбэл багш хүн өөрөө өөрийнхөө яг мэргэжлийн хичээлээрээ зааж байгаа хичээл, судлагдахуунаараа үнэлгээгээ жишээлбэл 40 орчим хувийг нь аваад, хүүхдүүдээс авч байгаа энэ асуулга, хүүхдүүдийн сурлагын энэ чадварыг нь түүврийн аргаар аваад, ингээд сургуулийн удирдах зөвлөлөөс нь үнэлгээгээ өгөөд ингээд явах илүү ойлгомжтой, өөрийгөө тооцоолж болох, өөрийнхөө ажлыг шударгаар үнэлүүлж байгаа эсэхээ харж болох ийм боломжийг бий болгосон байдлаар бид зохицуулж байгаа. Тэгээд мэдээж багш нар хэрвээ энийг ойлгохгүй бол ойлготол нь ярилцъя л даа. Хамтдаа ярилцъя. Заавал ажил хаяна, заавал жагсана, заавал энэ таалагдахгүй байна гээд бид нар асуудалд ингэж хурц хандмааргүй байна. Ярилцаад явъя, сайжруулаад явъя.

Тэгээд энэ салбарт гүйцэтгэлд суурилсан үнэлгээ бол боловсролын салбарт орж ирснээр олон дэвшлийг авчирч байгааг үгүйсгэж болохгүй. Энэ салбарын энэ үнэлгээний ажил чинь ингээд бусад салбаруудад орж ирж байгаа. Ер нь төрийн албан хаагчийн энэ ажлыг мэдээж амьдрах зардал нь, амьдралынх нь зардалд бүрэн хүрэхүйц ийм үндсэн цалин байх ёстой. Түүнийхээ зэрэгцээ илүү сайн ажиллаж байгаа ийм хүн дээр нь илүү үнэлгээнийх нь ийм шударга үнэлгээ нь орж ирж, орлого нь нэмэгдэж байдаг ийм боломжийг бий болгох нь манай боловсролын салбарт хэрэгтэй байгаа. Би дахин хэлье, үндсэн цалин хүрэлцээтэй байж дээр нь нэмж гүйцэтгэлийн үнэлгээ авах ёстой юм. Ингэж би боддог. Тэгэхээр ийм байдлаар намар тэгнэ, ингэнэ гэдэг байдлаар энэ танхимд яриад байх нь жоохон зохимжгүй болов уу гэж би бодож байна. Баярлалаа.

Ц.Мөнхтуяа: 20 минут тийм ээ? Наранбаяр сайдаа энэ танхимд миний юу хэлэхийг та заахгүй. Би өнөөдөр дураараа зохиогоод яриад байгаа юм биш. Энэ чинь боловсролын салбарын олон мянган багшийг төлөөлж байгаагийн хувьд тэднийхээ дуу хоолойг би энэ индэр дээрээс хүргэж байгаа юм. Тэрнээс өөрийнхөө дур зоргоор энд ярьдаг газар биш, энэ олон мянган багш нарын хүслийг би энд дамжуулж хэлж байгаа юм гэдгийг танд дахин сануулъя. Та өмнө нь миний дууг хориод ингэж ярихгүй гээд байсан. Би танаар дуугаа хориулахгүй хэлэх ёстой юмаа хэлээд явна гэдгээ танд дахин давтан хэлье. Тэгээд энэ гүйцэтгэлийн үнэлгээ чинь сая завхарсан шүү дээ Наранбаяр сайдаа. Ингээд цахимаар авна гээд бүүр гацчихсан, сүлжээ нь гацаад багш нар өөрсдөө орж чадахаа больсон, энийгээ мэдэж байгаа юу? Тэгэнгүүтээ үнэлгээнийхээ төвийн даргыг солиод, өөрийнхөө намын улс төржилт хийгээд, өөрийнхөө намын хүнийг боловсролын салбарт ажиллаж байгаагүй хүн авчраад тавьчихсан. Тэгээд энэ удаагийн гүйцэтгэлийн үнэлгээг чинь холион бантан жонхуу болсон гэж бүх багш нар хэлж байна.

2 дугаарт тэр судалгааны хүрээлэнгийн Итгэл захирлыг солиод, ямар ч тийм доктор, профессор зэрэг байхгүй, боловсролын бус хүн авчраад тавьчихсан та. Тэгээд өнөөдөр тэр хөтөлбөр шинэчилнэ гэдэг асуудал чинь failed-чихсэн байгаа. Энийг чинь би зохиогоод яриад байгаа юм биш, бодитой.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүн дэгээрээ энэ 20 минутын цаг дээр Улсын Их Хурлын албан ёсны веб хуудсанд байршуулсан иргэдийн асуултыг асуух дэгтэй. Ингээд асуултаа асууж, хариултаа авч дууссан. Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах асуулт асууна.

Ж.Галбадрах: Энэ өдрийн мэндийг хүргэе. Юуны түрүүнд 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгож санаачилж, энэ жилээ зарласан ЗГ-ын тэргүүн Оюун-Эрдэнэ, Боловсролын сайд Наранбаяр нарт олон мянган багш, ажилчид, сурагч, оюутнуудынхаа нэрийн өмнөөс талархал илэрхийлж байна. Бэлтгэлээ сайн хийх ажил үлдлээ. Хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байгаа. Гэвч 26 оны хөгжлийн төлөвлөгөөнд дөнгөж боловсролд оруулж байгаа хөрөнгө оруулалт 5 хувь байгааг та бүхэн анхаарна биз дээ.

Ингээд дэгийн дагуу нийт энд Мөнхтуяа гишүүн бид хоёрт өгсөн юм байна. Ингээд 14 иргэнээс 22 асуулт ирсэн. Би 11 асуултыг нь асуух юм байна. Яг энэ дагуу иргэдийнхээ юуг хэлье гэсэн, тэгээд Мөнхтуяа гишүүн маань хаанаас нь, аль асуултуудыг нь ингээд түүгээд дээрээс нь явсан, араас нь ч явлаа. Тэгэхээр би үлдсэн асуултыг нь л ингээд түүж харж байгаад боломжоороо хэлээд явах асуудал

үүрэгтэй боллоо. Тэгээд асуултаа асууя. Төгсгөлд нь надад минут үлдвэл би өөрийн санал бодлоо хэлэх ийм бодолтой байна. Тэгж болдог уу, үгүй юү? Би олонх болчихоороо үг хэлж болохгүй юм байна.

Д.Амарбаясгалан: 2 гишүүний үүрэг веб сайтаар дамжиж иргэдээс ирүүлсэн асуултыг мэдээлэл хийсэн албан тушаалтнаас асууна л гэж байгаа.

Ж.Галбадрах: Би болж өгвөл Наранбаяр сайд гээд байхаас илүү энд юуны ажлын хэсгийнхэн яг мэргэжлийн хүмүүс ирсэн байна. Энэ хүмүүсийг хариулж өгөөсэй гэж хүсэж байгаа. Тэр Бямбадаш гэж хүний нэр нэг их дурдаад хэрэггүй юм байна. Багш нарын дийлэнх нь орон сууцын нөхцөл маш тааруу, хөнгөлөлттэй зээлийн орон сууцад орох хүсэлтэй байдаг. Гэвч цалин хөлс багаас шалтгаалан ипотекийн зээлийн шаардлага хангахгүй байна. Иймд ЗГ-аас багш нарт зориулсан үнэ хямд, хүү бага, урьдчилгаагүй орон сууцжуулах талаар ямар хөтөлбөр хэрэгжүүлэх вэ, хэрэгжүүлж байна вэ гэдэг асуулт байна.

Дараагийн асуулт багш нарынхаа цалин хөлс, нийгмийн хангамжийг сайжруулах, ажиллах боломж нөхцөлийг нь хангах, техник хэрэгсэл, интернэт сүлжээг чанартай, хүртээмжтэй болгох, сургуулийн төсөв, түүний зарцуулалтыг нээлттэй ил тод болгоход сургуулийн удирдлагыг 5 жил тутамд аттестатчилах, сэлгэн ажиллуулдаг байх шаардлагатай байна. Эдгээр асуудлуудын хүрээнд ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ? Энхбаяр гэж хүн. Дөнгөж төгссөн залуу багш нар ямар ч нэмэгдэлгүй 1 сая 484 мянган төгрөгийн цалин нь татвар, шимтгэлээ хасаад, гар дээрээ 1 сая төгрөг авч байна. Энэ мөнгөөр амьдралаа авч явах ямар ч боломжгүй байгаа учраас багшийн ажлаас шантарч байна. Багшийн цалинг хэзээ мянган ам долларт хүргэх вэ?

Дараагийн асуулт анги удирдалтын хөлсийг нэмэх, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчилсөн багш, ажилтан нарт дэмжлэг, туслалцаа үзүүлэх талаар ямар хууль дүрэм, тушаал, заавар зөвлөгөө байна вэ? Энэ талаар асуусан байна.

Дараа нь цэцэрлэгийн багш маш олон хүүхдийн дуу чимээнд нэн хүнд нөхцөлд ажилладаг. Иймээс хөдөлмөрийн нөхцөлийг хүнд гэж авч үзээд, хүнд нөхцөлийн нэмэгдэл олгох, мөн 50 настай тэтгэвэрт гарах шаардлагатай байна. Энэ талаар судалсан уу?

Дараагийн асуулт би 50 хүүхэдтэй 1 дүгээр анги даасан багш байна. Анги удирдсан багшийн нэмэгдэл 10-хан хувь байдаг. Хөдөө орон нутагт 20 хүрэхгүй хүүхэдтэй ангийн багш адилхан 10 хувь авч байна. Ажлын ачаалал, үүрэг хариуцлага гээд аль ч талаасаа бодоход энэ шударга бус санагддаг. Анги удирдсан багшийн нэмэгдлийг хүүхдийн тоотой уялдуулан олгох шаардлагатай. Энэ талаар ямар арга хэмжээ авч байна вэ? Сумын багш 40 хувь, аймгийн багш 20 хувийн нэмэгдэлтэй ажиллаж байхад стандартаас давсан хүүхэдтэй, хүүхдүүдтэй ангид хичээл заадаг, амьжиргааны өртөг өндөртэй нийслэл хотод байгаа багш нарт ямар ч ийм нэмэгдэл байдаггүй. Мөн хөдөө орон нутгийн багш нарт эхний 5 жил болон дараагийн 3 жил тутамд 6 сарын цалинтай тэнцэх урамшуулал олгодог. Ийм учраас багш нараа хот, хөдөөгөөр нь давхар ялгаварласан маш болчимгүй үйлдэл гэж үзэж байна. Энэ ялгаварлан гадуурхах үйлдлээ зогсоож, нийслэлийн багш нарт зориулсан ачааллын нэмэгдэл эсвэл түүнтэй дүйцэх тэтгэмж урамшуулал олгох боломжтой юу?

Манай гэр бүл бид хоёр хоёулаа багш. Ипотекийн шаардлага хангадаггүй, 12 жил багшлаад өөрийн гэсэн байр сууцгүй л байна. Би ажлаасаа түр чөлөө аваад өндөр цалинтай ажил хийж байна. Эндээ гайгүй бол үндсэн ажлаасаа гарна. Яагаад гэвэл багшийн ажил цалин хөлс бага, нийгмийн баталгаа байхгүй, ажлын ачаалал их байдаг. Гүйцэтгэлийн үнэлгээ гэж хачин заваарсан юмаа болих хэрэгтэй. Энэ тал дээр ямар арга хэмжээ авах вэ? Энэ давхардсан бол уучлаарай түрүүний давхардуулаад энэ гүйцэтгэлийг ярьчихсан байна. Энд гүйцэтгэлийн үнэлгээ түрүүн Мөнхтуяа гишүүнийхэд гарсан гэж бодож байна. Уртнасан гэдэг хүнийхийг орхичихъё.

Цааш нь Боловсролын ерөнхий хуульд төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, МСҮТ, коллежид тасралтгүй 15-аас дээш жил ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг төрийн өмчийн их, дээд сургуульд эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр үнэ төлбөргүй сургана гэсэн заалт байдаг. Манай хүүхэд мэргэжлээрээ суралцдаг, тэр нь эрэлттэй, тэргүүлэх мэргэжилдээ багтаагүйгээс өөрсдөө төлбөрөө төлөөд суралцаж байгаа. Ер нь энэ эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр тасралтгүй 10 жил ажилласан гэсэн хэт хатуу заалтаа хасаж болохгүй юу?

Дараагийн асуулт бага ангийн сурагч бүр ямар сургуульд сурч байгаагаас үл хамаарч улсын төсвөөс олгогддог үдийн хоол, хөтөлбөрт хамрагдах ёстой. Ялангуяа орон нутгийн төлбөр багатай хэдхэн сургуулийн эцэг, эхчүүд төлбөртэй сургуульд хүүхдээ сургасныхаа төлөө энэ хөтөлбөрт хамрагдаж чаддаггүй байна. Иймд нэг ч хүүхэд ялгаварлагдах ёсгүй тул энэ тал дээр ямар арга хэмжээ авч байна вэ?

Үндэсний цөөнхийн 12 дугаар ангийн зарим төгсөгчид тухайн аймаг нь элсэлтийн шалгалтаар сүүл мушгидаг гэх шалтгаанаар элсэлтийн шалгалтад орох эрхээ хасуулах нь боловсролыг тэгш хүртээж байгаа хэрэг гэж та бүхэн үзэж байна уу сайдаа гэсэн байна?

Дараагийн асуулт, сайдын орон нутгийн багш нарт сар бүр олгох хоолны мөнгөний зардал 25 оны төсөвт суусан уу, энэ 26 оных юм болов уу? Мөн өмнөх жилийн хэмнэсэн зардлаас олгох гэсэн нэг заалт журам яваад байна. Төсөв нь хүрэхгүй байгаа боловсролын салбарт хэмнэгдсэн төсөв гэж байдаг уу? Ийм юм байж болох уу гэсэн ийм асуултууд ирсэн байна. Би нөгөө зарим хүний асуултыг нь Мөнхтуяа гишүүнийх дээр асуугдсан гэж үзээд ингээд ирсэн асуултуудыг нь яг байгаагаар нь уншиж сонсголоо. Би 2, 3 минут үг хэлбэл даргаа болох билүү? Хариулт авчхаад хэлчих үү?

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд хариулт өгье. Нэмж хариулт өгөх албаны хүмүүс 4 дүгээр индэр дээр очно шүү.

П.Наранбаяр: Энэ манай, тэгэхээр би энэ олон асуулт байгаа учраас зарим нэгийг нь хариулахгүй үлдээхэж магадгүй. Тэр тохиолдолд манай ажлын хэсгээс хариулж өгөхийг хүсье. Тэгэхээр унаа, хоолны энэ хоолны мөнгө 25 оны төсөвт суусан уу гээд. Унаа, хоолны нөхөн төлбөр нь нэг хүүхдэд ноогдох нь хувьсах зардлын бүрэлдэхүүн хэсэгт тусаагүй. 25 оны батлагдсан төсөв болон сургалтын байгууллагуудын 24 оны жилийн эцсийн үлдэгдэл эх үүсвэрийг дайчлах замаар олгох чиглэлийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн. Унаа, хоолны нөхөн төлбөрийг орон нутагт 5 мянган төгрөг, нийслэлд өдөрт 8 мянган төгрөгөөр тогтоож олгоход жилд 154,4 тэрбум төгрөгийн төсвийн нөлөөтэй байгаа юм. 24 онд

сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад нийт 150,9 тэрбум, үүнээс цалингийн сан нь 132,1 тэрбум төгрөг. Ерөнхий боловсролын сургуулиудад нийт 227,5 тэрбум төгрөг, үүнээс цалингийн сан нь 196,5 тэрбум төгрөгийн үлдэгдэл үүссэн байгаа. Тэгэхээр эндээсээ бүрэн санхүүжүүлэх боломжтой. Харин зарим нэг сургууль дээр хүүхэд цөөтэй сургууль дээр асуудал үүсэж байгааг бид нар ойлгоод, тэрийг яамны зүгээс шийдвэрлэхээр ингээд ажиллаж байгаа гэдгээ хэлье.

Үндэсний цөөнхийн 12 дугаар ангийн зарим төгсөгчид аймгийн элсэлтийн шалгалтаар сүүл мушгидаг шалтгаанаар элсэлтийн шалгалтад орох эрхээ хасуулсан гээд ийм юм яригдсан уу тийм сая? Тэгэхээр энэ бол Монгол хэл бичгийн шалгалтыг жилд 2 удаа зохион байгуулж байгаа. Ямар ч хүүхдийг сурлагын байдлаас нь шалтгаалаад элсэлтийн шалгалтад оруулахгүй байх нь өөрөө шууд хүний эрхийн зөрчил. Тийм учраас ийм бол байж болохгүй гэдгийг яамнаас хэлж байгаа, чиглүүлж байгаа. Баян-Өлгий аймгийн хүүхдүүд, мөн Ховд аймагт байгаа энэ казах болоод тува хэлтэй ийм хүүхдүүдийн сурлагын чанарыг сайжруулахад саяхан гаргасан хос хэлний боловсрол сургалтын талаар баримтлах чиглэл чухал арга хэмжээ болж байгаа гэж, ирэх хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлнэ.

Энэ бага ангийн сурагч өмчийн хэлбэрээс үл хамаараад энэ үдийн хоолны зардлыг олгох нь зүйтэй гэсэн ийм санал ирсэн байна. Энэ бол хуулийн заалттай. Боловсролын ерөнхий хуулийн 38.5.6-д төрийн болон орон нутгийн өмчийн ЕБС-ийн үдийн хоолны зардлыг улсын төсвөөс бүрэн хариуцахаар зааснаар 24 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн бус өмчийн сургуулийн бага ангийн суралцагчийн үдийн хоолны зардлыг олгохоо больсон. Өнөөдөр төрийн өмчийн 705 сургуульд суралцаж байгаа бага ангийн 343289 суралцагчийн үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж байгаа. Төрийн бус өмчийн 180 сургуульд бага ангийн 3658 суралцагч сурч байна. Бага ангийн суралцагчийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолоор 2500 төгрөгөөр тогтоож, 25 оны улсын төсөвт 150 тэрбум төгрөгийг батлан зарцуулж байна.

Энэ юуны төрийн өмчийн 15-аас тийм, төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, МСҮТ-д коллежид тасралтгүй 15-аас дээш жил ажилласан багш, ажилтны нэг хүүхдийн асуудал дээд сургуульд, их, дээд сургуульд суралцахад нь төлбөргүй хөнгөлөлттэй ингэж яах энэ асуудлыг хөндсөн байна. Энэ дээр Боловсролын ерөнхий хуулийн хуульд маш тодорхой заачихсан. Ерөнхий хуульд эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр тасралтгүй 15 жил гээд заачихсан байгаа. Тэгээд энэнээсээ болж энэ хохирч байгаа багш нар байгааг үгүйсгэхгүй. Энэ ерөөсөө энэ хуулийн 13.3.6 дээр байж байгаа энэ заалтаас болж байгаа гэдгийг танд тайлбарлаж хэлье. 24 оны 103 дугаар тогтоол энэний дагуу гарсан байдаг ЗГ-ын. 24 онд 571 суралцагчид 2 тэрбум, 25 онд 587 суралцагчид 1,5 тэрбум төгрөгийн дэмжлэгийг төгрөгийг тус тус үзүүлээд байна.

Ипотекийн зээл авах хүсэлтэй боловч цалин орлого хүрэхгүй байна гэсэн ийм асуулт байна түрүүн би энэ асуулт дотроо энийг хариулсан учраас явчихъя. Энэ цалин хүрэхгүй байгаа асуудлаа түрүүнд ярилцсан. Гүйцэтгэлийн үнэлгээний тухайд түрүүнд ярьчихсан. Эхнэр бид хоёр хоёулаа багш болохоор гээд тэр багш ипотекийн зээлийн шаардлага хангадаггүй 12 жил багшлаад өөрийн гэсэн байр сууцгүй байна гэсэн энэ асуултын тухайд аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээний 3.5.2-т мэргэжлийн багшийн хомсдолыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах, орон сууцын болон нийгмийн асуудлыг

шийдвэрлэх чиглэлээр Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх талаар тусган ажиллаж байна.

Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль багшийн түрээсийн орон сууц, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр хамруулах хөтөлбөрийг Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх гэж заасан байгаа. Энэ заалтыг хэрэгжүүлэхээр ажиллана. Ер нь 8 айлын орон сууц гээд нэг хөөрхөн шийдэл байгаад байгаа. Мөн багшийн нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр Үйлдвэрчний эвлэлтэй холбогдож, хамтран багш нарын орон сууцын хөнгөлөлттэй зээл болон орон сууцаа сайжруулах нөхцөлийг судлах судалгааг 25 онд хийхээр төлөвлөсөн байгаа.

Юуны хувьд тэр сумын багш нарт 40 хувь, аймгийн төвийн багш нарт 20 хувийн нэмэгдэлтэй ажиллаж байхад нийслэлийн багш нарт болохгүй өгөхгүй байгаа, ингэж багш нараа ялган яаж болохгүй, ялгаварлаж болохгүй гэсэн ийм зүйл дээр энэ нийслэлийн багш нарын цалин хөлсний судалгааг бид хийж, саналаа танилцуулна. Гэхдээ нэг зүйл бол хөдөөд багш нар их дутагдалтай байгаа. Ялангуяа англи хэл, математик, физик, хими гээд мэргэжлийн багшийн дутагдал маш их байгаа. Тэгээд энэ дутагдлыг арилгахын тулд явж байгаа хөдөөд энэ суурьшлыг бий болгох зорилгоор явуулж байгаа ийм бодлого гэдгийг та бүхэн ойлгож хандаарай.

Энэ хүүхдийн тооноос хамааруулж анги удирдсан багшийн ачааллыг бууруулах тухайд энэ зорилгоор бид нар 44-өөс дээш хүүхэдтэй бүлгүүдэд энэ хичээлийн жилээс эхлээд багшийн туслах ажиллуулах ийм шийдвэрийг гаргаад ажиллаж байна. Анги даалтын нэмэгдлийг 30 хүртэлх хүүхэдтэй ангийн багшид 10 хувь, 30-аас 40 хувь хүүхэдтэй ангийн багшид 15 хувь, 40-өөс дээш хүүхэдтэй ангийн багшид 20 хувь байхаар тооцоход жилдээ 15,7 тэрбум төгрөгийг нэмэлтээр шаардлагатай гэсэн тооцоо гарсан. Энийгээ бид хувьсах зардал руугаа оруулж чадвал энэ асуудлыг шийдэх боломжтой гэж харж байна.

Цэцэрлэгийн багшийн хүнд нөхцөлийн тухай дурдсан. Тэгэхээр 50 наснаас дээш, 50 настай болсон тэтгэвэрт гарах шаардлагатай гэсэн ийм юм ярьж байна. Энэ бол сонголтоороо гарах боломжийн талаар бид судалж үзэхээр ингээд яригдаж байгаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөс 2019 онд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмжийн хүрээнд цэцэрлэг, сургуулийн багш нарын хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийсэн. Энэ 19 онд хийсэн судалгаа шүү. Энэ үр дүнгээр цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын байр бол хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр өнөөдрийн байдлаар үнэлэгдээд байгаа.

Боловсролын салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх тухайд энэ 4,7 хувь байгааг 7 хувьд хүргэх, эсвэл төсвийн зардлын 13 хувь байгааг 20 хувьд хүргэх явдал гэж байгаа. Энэ дээр бид энэ дэмжих жилийнхээ хүрээнд энэ жил хэрвээ нэмж чадвал ДНБ-ий 5,7 хувь, төсвийн нийт зардлын 15,5 хувь байхаар тооцож Сангийн яам руу явуулсан байгаа. Эдийн засгийн хөгжлийн яаманд бас хүргүүлсэн. Салбарын төсвийг дотоодын нийт бүтээгдэхүүний 7 хувьд хүргэхэд 2025 онд батлагдсан төсвийг 2,5 их наядаар нэмэгдүүлэх ийм шаардлага үүснэ гэж. Ингээд анги удирдах хөлсийг нэмэх талаар түрүүнд хариулсан.

Дөнгөж төгссөн залуу багш ямар ч нэмэгдэлгүй гээд ингээд авч байна. Тэгэхээрээ залуу багш нарын шилжилт хөдөлгөөн, ажлаас гарах шалтгаануудын үндсэн нэг шалтгаан нь багшийн цалин хөлс байгаа. Өнөөдрийн байдлаар ЗГ-аас

тогтоосны дагуу цэцэрлэгийн багш нэг аравны, 1 сая 559 мянган төгрөгийн үндсэн цалин авч байна. Шинээр ажилд орсон багш бүх боломжит нэмэгдлээ оруулаад гар дээрээ 1 сая 992 мянгаас 2 сая 600 мянган төгрөг авч байгаа бол 20-оос дээш ажиллаж байгаа багш байршлаасаа хамаараад 2,6-аас 3,3 саяын хооронд авч байна. Энэ нэмэгдлүүдийг нэмсэн дүн шүү. ЕБС-ийн хувьд шинэ багш нь 1 сая 494 мянган төгрөгөөс 2 сая 681 мянган төгрөгийг гар дээрээ авч байгаа бол 20-оос дээш ажиллаж байгаад багш нар 2582950-аас 3206550 төгрөг авч байна.

Багш нарын шилжилт хөдөлгөөн, ажлаас гаралтад сургуулийн удирдлага, зохион байгуулалт ихээхэн нөлөө үзүүлдэг. Иймээс сургууль, цэцэрлэгийн менежментийг сайжруулах арга хэмжээг 2023 оноос эхлээд хэрэгжүүлж байгаа. Салбарын сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай Боловсролын салбарт хамтран ажиллах гэрээ энэ орон нутгийн удирдлага мэргэжлийн багшийн хомсдолыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, цэцэрлэг, багшийн, ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах, орон сууцын болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх асуудлыг тусган хэрэгжүүлж байна. 3 дугаар сарын байдлаар энэ оны багшийн дундаж цалин нь 2809191 төгрөг байгаа энэ нэмэгдлүүдийг бүгдийг нь оруулсан тоо гэдгийг дахин хэлье. Энэ хэмжээг 3 сая төгрөг хүргэхэд 418,1 тэрбум төгрөг нэмэлтээр шаардлагатай байна. Мөн интернэт сүлжээг чанаржуулах, багш нарынхаа цалин хөлс, нийгмийн хангамжийг сайжруулах тал дээр улсын хэмжээнд 2024 оны 4 дүгээр улиралд ажиллагчдын сарын дундаж цалин 2,3 сая, 2332400 төгрөг байхад боловсролын салбарт ажиллагчдын сарын дундаж нь 2018100 төгрөг ийм байгаа. Энэ улсын дунджаас доогуур байгааг би түрүүн дурдсан. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн цалинг жил бүр 6 хувиар нэмэгдүүлнэ гэж үзвэл бид цаашдаа энэ цалин нэмэгдээд явах ийм боломжтой гэж харж байгаа юм.

Боловсролын салбарын цахим дэд бүтцийг бүрэн шийдвэрлэж, боловсролын нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, дэд бүтцийг боловсролын танхим бүрд утастай болон утасгүй сүлжээнд холбогдох боломжийг бий болгох, сургууль бүрд хүүхдийн тоо, хүчин чадлаас хамааруулан орчин үеийн цахим танхим байгуулах, цахим хуваагдлыг арилгах үүднээс суралцагч бүрд зөөврийн төхөөрөмж олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар цахим сургалтын орчин бүрдүүлж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангана.

Сургуулийн удирдлагыг сэлгэн ажиллуулах журам гарсан. Энэ нь нийслэл болоод аймгийн төв дээр л байгаа гэдгийг та бүхэнд анхааруулж хэлье. Энэ хичээлийн жилд Улаанбаатар хотод нийт 18 сургуулийн захирлыг сэлгэн ажиллуулсан байгаа. Цаашдаа энэ ер нь сургуулийн удирдлагуудыг аттестатчилах, шалгаж үзэх, 5 жил тутамд сэлгэн ажиллуулдаг шаардлагыг бид хүлээж авч байна. Нэг сургууль дээр олон жил хадагдаад ингээд байхаараа эерэг биш сөрөг үр дүн нь давамгайлах ийм хандлага байдгийг бүрэн хүлээн зөвшөөрнө. Үндсэн цалингийн, энэ цалингийн асуудал.

Орон сууцжуулахад бид энэ олон ийм асуулт ирсэн учраас дахиад энэ дээр харъя. Боловсролын ерөнхий хуулийн 13.4 дээр багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ гэж заасан байгаа. Тэгэхээрээ зэрэг Монгол Улсын ЗГ-аас 25 онд иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд 13 мянга орчим иргэдийг хөтөлбөрт хамруулах ба үүний 50-аас доошгүй

хувийг орон нутагт олгоход зориулан улсын төвөөс 123,5 тэрбум төгрөг, бусад эх үүсвэрээс 1,3 их наяд төгрөгийг зарцуулахаар тусгасан. Орон нутгийн ипотекийн 3 хувийн зээлийг үргэлжлүүлэн олгож, амины орон сууцыг ипотекийн зээлд хамаарах энэ боломжийг олгохоор ажиллаж байна. Түрүүнд энэ юуг бол тэтгэврийн асуудлыг хариулсан. Багш нарын үндсэн цалинг нэмэх асуудал дээр бид энэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хугацаа дууссан байна 20 минут. Нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын боловсролын салбартай холбоотой асуудлаар мэдээллийг сонсож, иргэдээс ирсэн албан ёсны асуултад асуулт асууж, хариулт авч дууслаа.

15.45 цаг

Дөрөв.Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт

Дараагийн асуудалд орно. Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцсэн талаар БОХХАА-н Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсоно. БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд танилцуулна. Индэрт урьж байна.

С.Эрдэнэболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар иргэдээс гаргасан өргөдлийг цахим системээр хүлээн авч болно гэж заасны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр иргэн Батбаатарын Мөнгөнхишиг Нийтийн өргөдөл гомдол гомдлын систем petition.parliament.mn цахим хуудсанд ЗГ-ын 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоолоор баталсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр болон бусад холбогдох үйл ажиллагааны төсөв, гүйцэтгэл, түүний ил тод байдалд үнэлгээ хийж, цаашид хэрэгжих төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг сайжруулахыг шаардаж утааны сонсгол хийцгээе, төсвийн зарцуулалтад хяналт үнэлгээ хийж сайжруулцгаая сэдэвт өргөдлийг үүсгэн, иргэдээс гарын үсэг цуглуулж эхэлсэн бөгөөд энэхүү өргөдөлд 71452 иргэн гарын үсэг зурсан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2-т заасны дагуу 70 мянга ба түүнээс дээш тооны иргэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах саналыг дэмжсэн тул Монгол Улсын Их Хурал авч хэлэлцсэн БОХХАА-н байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7 дугаар тогтоолоор Агаарын, бохирдол утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн, ТББХ-ны дарга Ж.Бат-Эрдэнэ, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар, ХЗБХ-ны дарга Дамдины Цогтбаатар, Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Цэндийн Баатархүү, П.Батчимэг, Б.Бат-Эрдэнэ, А.Ганбаатар, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, С.Замира, Ж.Золжаргал, С.Лүндэг, М.Мандхай,

Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, Б.Найдалаа, А.Ундраа, Б.Уянга, О.Саранчулуун нар ажилласан.

Ажлын хэсэг ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах ажлын төлөвлөгөөг баталж, бэлтгэл ажлын хүрээнд дараах 4 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд эдгээр хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 194 иргэн, төрийн байгууллагын 93 албан тушаалтан оролцож, 75 иргэдийн төлөөллийн холбогдох төрийн байгууллагаас асуулт асууж, хариулт авч, 28 иргэнд танилцуулга хийсэн байгаа. Үүнд, 1.2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Агаарын бохирдол хүн амын эрүүл мэнд, амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, салбарын эрдэмтэн судлаачид, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл зэрэг нийт 90 гаруй хүн оролцож, хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд удирдан явуулсан.

2.2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Утааны асуудал, стандарт, хяналт, зуух, түлшний технологи сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, салбарын эрдэмтэн, судлаачид, иргэд, ТББ-ын төлөөлөл бүхий нийт 120 гаруй хүн оролцож, хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан удирдан явуулсан.

3.2025 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Утааны асуудал, эрх зүйн орчин, бодлого, шийдвэрийн хэрэгжилт, санхүүжилт, хариуцлага сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт төрийн байгууллагын холбогдох албан тушаалтнууд, салбарын эрдэмтэн, судлаачид, иргэд, ТББ-ын төлөөлөл бүхий нийт 90 гаруй хүн оролцож, хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар удирдан явуулсан.

4.2025 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Утааны асуудал, зуух, түлшний технологийн шийдлүүд сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт 70 гаруй иргэн оролцож, 28 аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн төлөөлөл өөрсдийн шийдэл, шинэ санаачилга, бүтээлээ танилцуулж хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал удирдан явуулсан. Тус хэлэлцүүлэгт оролцсон 28 аж ахуйн нэгж байгууллагаас танилцуулсан танилцуулга, мэдээллийг Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлсэн.

БОХХАА-н Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 8 дугаар тогтоолоор Агаарын бохирдол, утааны асуудлаар зохион байгуулах ерөнхий хяналтын сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнг томилж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан журмыг баримтлан ерөнхий хяналтын сонсголыг 2025 оны 2 дугаар сарын 3, 4-ний өдөр Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл сэдвээр зохион байгуулахаар тогтож, тус Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 10 дугаар тогтоолыг баталсан. Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд Утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл, сэдвийн хүрээнд ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын БОХХАА-н байнгын хороо,

Улсын Их Хурлын Тамгын газар 2025 оны 2 дугаар сарын 3, 4-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Сонсголд Улсын Их Хурлын гишүүдээс гадна төрийн бус байгууллага төлөөлөл 6, иргэд 94, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл шууд дамжуулах 2 телевиз нийт 4 оролцогч бүртгүүлснээс төрийн байгууллагын төлөөлөл 64, ТББ-ын 64 иргэн оролцсон. Сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.4-д заасны дагуу нээлттэй явуулсан бөгөөд хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах, тэдний оролцоог хангах зорилгоор МҮОНРТ-ээр дохионы хэлмэрчтэйгээр шууд дамжуулсан. Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын тайланг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.4-д заасны дагуу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст тэмдэглэлийн хамт байршуулсан болно.

Байнгын хорооноос зохион байгуулсан 4 удаагийн хэлэлцүүлэг, 2 өдрийн ерөнхий хяналтын сонсголын үр дүнгээс үзэхэд агаарын бохирдол, утааны асуудлыг бууруулахад одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн орчин, салбар дундын нэгдсэн уялдааг хангахгүйгээр цаашид өнөөдрийн үүссэн нөхцөл байдал, бэрхшээл арилахгүй болохыг тодорхойлсон.

Тайлангийн дүгнэлтээс тоймлон үзвэл, 1.2010 оноос хойш агаарын бохирдол болон агаарын орчны бохирдол буюу бохирдолд анхаарал хандуулан олон хөтөлбөр, төслийг хэрэгжүүлсэн хэдий ч эдгээр төсөл, хөтөлбөрийн хамрах хүрээ хэт өргөн тусгагдсан, өртөг зардал өндөр, бодит үр дүнд хүрэх санхүүжилт, институтын чадавх, салбар хоорондын уялдаа муу, хяналт, хариуцлагын эргэх холбоо сул байсан.

2.Байгаль орчны салбарт мөрдөгдөж байгаа 30 орчим хууль, мөн 200 орчим эрх зүйн акт, дүрэм, стандартын давхардал, зөрчил, хийдэл ихтэй. ЗГ-аас 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн цаг хугацааны мөчлөгөөр оновчтой, хэмжигдэхүйц, биелэгдэхүйц, ач холбогдолтой шалгуураар үнэлэх шаардлагатай байгаа юм.

3.2023 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн Б 25 89 дугаартай Эрчим хүчний яамны ТНБД-ын тушаалаар баталсан Сайжруулсан хатуу түлш, техникийн шаардлага, MNS 56 79 20 22 стандартыг яаралтай шинэчлэх шаардлагатай байна.

4.Агаарын чанарын бүс рүү зөвшөөрөлгүй түүхий нүүрс оруулж байгаа эсэх, бүсэд зөвшөөрөлгүй түүхий нүүрс болон бусад зүйлс түлж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, хэрэгжилтийг долоо хоног бүр тайлагнаж, холбогдох шийдвэр гарч байгаа хэдий ч хэрэгжилт хангалтгүй гэж үзсэн.

5.Сайжруулсан шахмал түлшний хэрэглээ Улаанбаатар хотын гадаад, дотоод агаарын орчны PM10, PM2,5 агууламжийг бууруулсан боловч хүн амын эрүүл мэнд, амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх хэмжээнд байсаар байгаа юм. Түүхий нүүрсний хэрэгцээний үед өвлийн улирлын агаарын чанарын найрлага нь найрлага дахь PM10, PM2,5, CO, SO2 хэмжээ нэмэгдэхэд ургийн зулбалтын давтамж нэмэгдэж, үр хөврөл бүрэлдэх байдал буурах хандлага ажиглагдсан. Монгол Улсад агаарын бохирдлын эрсдэлт хүчин зүйлийн нөлөөгөөр уушгины хавдраар гадна, элэгний хавдарт нөлөөлж, хавдрын өвчлөл жилээс жилд нэмэгдэж

байна. Олон улсад хийсэн судалгаагаар түүхий нүүрсний хэрэглээний улмаас уушгины хавдрын тохиолдлыг нэмэгдүүлж байгааг тогтоосон.

6.Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайкагаас гаргасан 2022 оны тайланд гэр хорооллын 198840 яндангаас гарч буй утаа агаарын бохирдлын 55,6 хувь, 804656 автомашины утаа 28,9 хувь, Дулааны цахилгаан станцын үнсэн сан зэрэг бусад үүсгүүр 15,5 хувийг эзэлж байна.

7.Улаанбаатар хотын төвийн дүүргийн гэр хорооллын өрхийн тоо 2000-аас 2022 он хүртэл 2,4 дахин нэмэгдсэн нь агаарын бохирдол нэмэгдэх үндсэн шалтгаан болсон байна.

8.Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 онд хийсэн Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын бохирдлын эх үүсвэрийн судалгааны дүнгээр гэр хорооллын болон усан халаалтын зуух 80 хувь, авто тээврийн хэрэгсэл 10 хувь, ДЦС 6 хувь, хог, шороо, хөрсний бохирдол 4 хувьтай гарсан байгаа.

9.Түлшний горим алдагдаж, дутуу шаталтын явцад угаарын хий, дэгдэмхий органик нэгдлүүд үүсэх эрсдэл гарсан. Сайжруулсан шахмал түлш хэрэглэснээр түүхий нүүрсний хэрэглээг 60 хувиар бууруулж, илчлэгийг нэмэгдүүлж, хэрэглээг 54 хувиар бууруулснаар энэ хэмжээгээр агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулсан гэж үзэх боломжтой. Чийг болон дэгдэмхий хийн үзүүлэлтийг бууруулсан сайн талтай ч үнслэг болон хүхрийн хэмжээ нэмэгдсэн сөрөг үр дүн гарсан байна.

БОХХАА-н байнгын хороо Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байгаа юм.

Үүнд, Агаарын тухай хууль болон Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг Улсын Их Хуралд танилцуулах. Агаарын бохирдлыг бууруулах салбар дундын цогц бодлогыг богино, дунд хугацаагаар боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг хамтад нь боловсруулж иргэд, олон нийт, төрийн бус байгууллагуудын хөндлөнгийн хяналт хийх үр дүнтэй оролцоог хангах. Бодлогын уялдаа, зохион байгуулалтыг сайжруулах хүрээнд холбогдох нарийн мэргэжлийн судлаач, эмч нарын төлөөллийн оролцоог хангасан төр, бизнес, хувийн хэвшил, иргэд судлаачдын багийг байгуулан ажиллах. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог Ерөнхий сайд ахалж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог хангах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг Улсын Их Хурлын хавар, намрын чуулганы хугацаанд тогтмол тайлагнах. Агаарын бохирдлыг бууруулахад зарцуулсан санхүүжилт, зарцуулалтын талаарх мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, БОХХАА-н байнгын хорооны дэргэд байнгын ажиллах Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороог байгуулж, хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагын тайлан мэдээллийг сонсох Монгол Улсын Засгийн газарт үүрэг чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах шаардлагатай байна гэж үзлээ.

Байнгын хорооны хуралдаанаар ажлын хэсгийн тайланг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулах иргэдийн хүсэлтийг Улсын Их Хурал авч хэлэлцсэн Утааны сонсголыг Байнгын

хорооноос зохион байгуулж, тодорхой асуудлаар ЗГ-т чиглэл өгөх асуудлыг хэлэлцэж байгаатай уялдуулан утаанд хордож амь насаа алдсан иргэдэд нөхөн төлбөр олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх боломж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан сонсголын үеэр иргэдээс алдаа зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах асуудлыг хөндөж байсан бөгөөд хариуцлагын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар, сайжруулсан түлшний стандартыг шинэчлэн батлуулах ажлыг нэн яаралтай хийх, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар хөдөө орон нутгийн ялангуяа уул уурхайтай аймаг, сумдын агаарын бохирдуулагч эх үүсвэрийг тогтоосон судалгаа, тайлан байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат шахмал түлшний мидлингийн технологийн горим алдагдсан шалтгааныг тодорхойлсон эсэх, хариуцлага алдсан албан тушаалтанд авах арга хэмжээний талаар дүгнэлтэд тусгасан эсэх, хатуу түлшийг халж, дараагийн хийн шугам болон цахилгаан эрчим хүчээр хангахад хэр хугацаа зарцуулагдах талаар судалгаа гарсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан өнгөрсөн хугацаанд утааны асуудлаар хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд батлагдсан хэдий ч хэрэгжилт хангалтгүй, нэлээдгүй төсөв, санхүүжилтийг зарцуулсан боловч тодорхой үр дүн гараагүй байгааг анхаарч, сонсгол зохион байгуулсантай холбогдуулан ЗГ-т чиглэл өгөх тогтоолын төсөлд дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар тусгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг угаарын хийнээс болж амь насаа алдсан иргэдийн ар гэрт олгох нөхөн олговрын асуудлыг хэрхэн шийдвэрлэх, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороог Засгийн газрын тэргүүн эсвэл Шадар сайдаар ахлуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Улаанбаатар хотын агаар солилцооны багтаамж, цахилгаан, дулаан хангамжийн эх үүсвэрийн талаарх нарийвчилсан судалгаа хийгдсэн эсэх, энерги, цахилгаан, дулаан хангамжийг нэмэгдүүлэх, стандарт, техникийн зохицуулалт, хяналт, мониторингийн асуудлыг Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд цогцоор нь тусгаж хэрэгжүүлэх талаар тус тус асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг танилцуулж дууслаа. Та бүхэнд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Үндэсний аудитын газар Гантөмөрийн Жавхлан Чанарын удирдлагын газрын ахлах аудитор, Батсуурийн Ариунзаяа Тамгын газрын хууль, эрх зүйн менежер, Лувсандашийн Эрдэнэчулуун Эрсдэлийн удирдлагын газрын менежер. Улсын онцгой комисс Түвшинсайханы Баярхүү Нарийн бичгийн дарга, хурандаа. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо Санжаагийн Даваасүрэн Ажлын албаны дарга, Сандагийн Төмөрбат Бодлого, төлөвлөлтийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Амгаланбаярын Амартүвшин Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч, Даваасамбуугийн Мөнхбаатар Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга, Болдын Амартүвшин Нийслэлийн боловсролын дарга. Батсайханы Баттулга Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв орон өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга, Чимэдийн Буянжаргал тус газрын ерөнхий менежер. Тавантолгой түлш хувьцаат, хязгаарлагдмал хариуцлагатай компаниас Цэдэндамбын Эрдэнэбаяр гүйцэтгэх захирал, Доржбаатарын Өлзийбат ерөнхий менежер, Хишигтогтохын Ариунзаяа Санхүүгийн

газрын дарга, Экологийн цагдаагийн албанаас Минжүүрдоржийн Батсайхан Ажлын албаны дарга, цагдаагийн хурандаа, Гөлгөөгийн Батжаргал Эрүүгийн цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, судлаач Батбаатарын Сувд орчны эрүүл мэндийн судлаач, анагаах ухааны доктор, профессор.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж болно. Нэрээ өгье? 7 гишүүнээр тасаллаа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Агаарын бохирдлын сонсгол хийгдсэн. Салбар хоорондын уялдаа холбоотой асуудлууд, хууль, эрх зүйн орчин дээр зөрчилдөөнтэй гэдэг агуулгаараа ч гэдэг юм уу ерөөсөө явахгүй байна. Өнөөдөр утааны асуудлыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд харьяалуулж ирсэн. Буруутан нь Байгаль орчны яам юм шиг дайрдаг. Гэхдээ энэ чинь дулаан үйлдвэрлэлийн асуудал. Би маш олон удаа хэлж байгаа юм. Агаарын бохирдлын сонсголттой холбоотой асуудал зөвхөн Улаанбаатар хоттой холбоотой асуудлыг л энэ удаа хөндсөн. 21 аймагт байгаа аймгийн төвүүд бол, сумын төвүүд утаандаа нэрвэгдчихсэн л байгаа. Бид нар энэ дээр яг ний нуугүй хэлэхэд салбар дундын зохицолдлогыг хангаж, эрх зүйн орчин дээр тодорхой хэмжээний маш шийдэмгий өөрчлөлтүүдийг хийхгүй бол хэнбугай ч энийг хариуцаад ямар ч үр дүн гарахгүй үргэлжилсээр л байна.

Би энийг яагаад хэлж байгаа вэ гэхээр тодорхой хэмжээнд эрчим хүчний хангалтыг бид нар хийхгүйгээр өнөөдөр халаалтын асуудлыг яаж шийдэх юм бэ? Түлсээр байвал утаа гарсаар л байна. Дулаалгын асуудлыг бид нар шийдэхгүйгээр дулаан алдагдалтай байгаа тохиолдолд, байгаа дулаанаа алдаж байгаа тохиолдолд бид өдөр болгон 3, 4, 5, 6, 7-гоороо гал түлсээр байна. Энэ ойлгомжтой асуудал. Шийдэл дээр уул нь шийдэл гаргасан шүү дээ 2022 онд. Ялангуяа Эрдэнэс Тавантолгой компани дээр хагас коксын үйлдвэр барих ТЭЗҮ нь хийгдээд, тухайн үеийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам руу хүргүүлээд, ингээд нүүрсний хулгай гараад, асуудал үүсээд ингээд тухайн ТЭЗҮ-г зогсоогоод. Уг нь тухайн ТЭЗҮ-гээрээ үйл ажиллагаа явж байсан бол 2024 оны 1 дүгээр улиралдаа багтаад хагас коксын үйлдвэр ашиглалтад ороод, өнөөдрийн дэгдэмхий сайжруулсан шахмал түлш буюу дэгдэмхий 22 хувь биш, 8 хувь руу орчих байсан боломж байсан.

2 дугаар асуудал улс төржилт. Нэг дарга ирдэг бүх хүмүүсээ сольчихож байгаа юм. Ерөнхий инженерээсээ авхуулаад. Тэгээд нөгөө хүмүүс нь юмтайгаа танилцаар байгаад утааны улиралтай золгоцхож байгаа юм. Бэлтгэл ажил байхгүй, яагаад утаа гараад байгаагаа ойлгодоггүй ийм дарга нарын бүлэг бий болчихсон. Түүн дээр асуудлууд явж байгаа юм. Тэгэхээр бид нар цаашдаа энэ эрх зүйн орчинтой холбоотой асуудлыг зөв зүйтэй, татварын бодлогыг хүртэл оруулж ирэх шаардлагатай гэж харж байгаа. Өнөөдөр нийслэлийн утааны асуудал зөвхөн нийслэлийн утаа, нийслэлийн холбоо бүхий асуудал биш шүү. Энийг ерөөсөө нийслэлийн асуудал гэж бид нар хаяж болохгүй. Аймагтай холбоотой асуудлуудыг байгаль орчин аялал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам хариуцах ёстой гээд бас хаяж болохгүй. Би Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамыг энэ дээр байнга хамгаалж байгаа, дуугарч байгаа энэ яамны төлөө. Учир нь утаагүй болох нь үр дүн болохоос биш, буруутан хайх нь үр дүн биш байхгүй юу.

Өчигдөр Улсын Их Хурлын чуулган дээр бас л яригдлаа. Цөлжилт гээд л Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамныхан нөгөө талдаа энэ

агуулгуудаа Улсын Их Хурлын гишүүддээ ойлгуулж чадахгүй байна. Ерөөсөө ойлгуулж чадахгүй байна. Энэ Цөлжилтийн конвенцын хурал чинь 2021 оноос авах тухай асуудал яригдаад, 2024 онд Цөлжилтийн конвенцын хурлыг Монгол Улсад зохион байгуулъя гэж яваад, харин ч би очоод 2026 он болгож, 2 жилээр хойшлуулж ирсэн шүү дээ. Тэгээд 400 тэрбум төгрөг гээд төсөвлөчихсөн хаанаас гараад ирсэн мөнгө нь мэдэгдэхгүй. Өнөөдөр сонсох нь барилга байшин барих тухай асуудал яригдаад байгаа. Яг ийм байдлаар төрийн үйл ажиллагаа үргэлжилж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ажлын хэсгийнхэн маань эрх зүйн орчин дээр ажиллах тал дээр голлон анхаарч ажиллаач. Хаана эрх зүйн орчин дээр ямар юм байна гэдгийг гаргаж ирээд, энэ Улсын Их Хурал парламентаар асуудлуудыг нь шийдүүлээд яваач гэдгийг хүсэх гэж байгаа юм. БОХХАА-н байнгын хорооны дэргэд Агаарын бохирдлын дэд хороо 2006, 2020 онд байсан. Энэ 2024 оноос байхгүй болсон, энийг дахин байгуулахаар нэр бүхий 12 гишүүн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Доржзовдын Энхтуяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Энхтуяа: Энэ өдрийн мэнд хүргэе. Надад 4 асуулт байна. Ер нь энэ агаарын бохирдолтой 10, 20 жил тэмцэж байна. Тэгээд харамсалтай нь бидний тэмцэл үр дүнд хүрэхгүй байгааг өнөөдрийн нөхцөл байдал харуулж байгаа. Энэ тэмцлээс гадна улс татварын мөнгөөр маш олон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн. Харамсалтай нь энэ төсөл, хөтөлбөрүүд бас л амжилтгүй явж байна.

11 сард Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн байнгын хорооны гишүүд Тавантолгой түлш ХК дээр ажилласан байгаа. Бидний ажиллах үед дөнгөж ажлаа аваад долоо хонож байсан удирдлага байсан. Энэ дээр агаарын сонсгол дээр ирж та бүхэн асуудлуудаа ярьж байсан. Одоо ингээд харьцангуй цаг хугацаа өнгөрлөө. Тэгээд та бүхний ажил ямаршуухан шатдаа явж байна вэ гэдэг дээр эргэж 4 асуулт асууя. Таван толгой түлш ХК-ийн сайжруулсан шахмал түлшний одоогийн мөрдөж байгаа энэ стандарт MNS 56 79 20 22 гэсэн стандарт байгаа. Тэгэхээр энэ стандарт бол энэ ажлын хэсгийн дүгнэлт гарч байгаа. Ахуйн хэрэглээний шахмал түлшний олон улсын стандартад нийцэхгүй байна гэсэн ийм анхан шатны дүгнэлт гарсан байгаа. Тэгэхээр та бүхэн тухайн үед дүгнэлтийг ярьж байсан. Энэ дүгнэлт дээр та бүхэн ямар зүйл хэлэх вэ? Ер нь энэ шахмал түлшний одоогийн энэ мөрдөж байгаа стандартыг өөрчилсөн үү? Ирэх 11 сараас эхэлж гал түлж эхлэхэд энэ стандарт хэвээр мөрдөгдөх юм уу, эсхүл шинэ стандарт гаргаж тавьж байна уу гэсэн 1 дүгээр асуулт байна?

2 дугаар асуулт энэ Эрдэнэс Тавантолгой ХК-аас эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлээр 1,5 их наядаар санхүүжүүлсэн байгаа. Энэ Тавантолгой түлш компанийн хувьцаа. Тавантолгой түлш компанийн үйл ажиллагааг. Тэгэхээр энэ 1,5 их наяд төгрөгийн өртэйгөө Нийслэл Улаанбаатар хотод шилжсэн байгаа. Тэгэхээр энэ өр төлбөрийн асуудлыг та бүхэн ямар хэмжээнд төлөгдөх хэмжээнд явж байна вэ? Нийслэл Улаанбаатар хот бол бид асуудлаа шийдвэрлэнэ гээд иймэрхүү байдалтайгаар хүлээлгээд өгчихсөн байгаа, ЗГ-ын тогтоол гаргаад, юу Их Хурлын тогтоол гаргаад.

3 дахь асуулт 2024 оны байдлаар ажлын хэсэгт ирсэн мэдээллээр 817 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай байсан Тавантолгой түлш компани. Тэгээд энэ алдагдлын асуудлыг хааш нь шийдэгдэж байгаа вэ? Түрүүний 1,5 их наяд бол үйлдвэр байгуулахад хэрэглэсэн мөнгө байгаа. Одоогийн 2024 оны байдлаар 817

тэрбумын ийм алдагдалтай явж байгаа. Тэгэхээр энэ өвлийн, өвөлд бэлэн үү та бүхэн? Энэ мөнгө төгрөгийнхөө асуудлыг ямар байдлаар шийдэж байгаа вэ гэсэн 3 дахь асуудал байна.

4-д нь болохоороо Тавантолгой түлш ХК-ийн үйл ажиллагаатай холбоотой нүүрс баяжуулах үйлдвэр, хагас коксын үйлдвэр, нунтаг кокс бэлтгэн нийлүүлэх төсөл мэтээр санхүүжүүлсэн нийт хөрөнгийн зарцуулалтад холбогдох хяналт шалгалтыг хийнэ гэсэн мэдээллийг 11 сард өгч байсан. Энэ хяналт шалгалт хийгдэж эхэлсэн үү? Эхэлсэн бол ямаршуухан хэмжээнд явж байгаа вэ гэсэн 4 дэх асуулт.

Хотынхон ирсэн учраас хийн түлшинд орно гэсэн ийм зүйл яригдаж байсан. Хийн түлшний ганц, хоёр компаниудтай гэрээ хийж байгаа гэсэн л мэдээлэл өгсөн. Өнөөдөр чинь ингээд 6 сар болж байна. Бид нар 5 сарын дараа хүйтний улиралтай золгох гэж байна. Энэ хийн түлшний асуудал хэр зэрэг явцтай явж байна, хийн түлшээр хэдэн айл өрхийг хангах юм, энэ хийн түлшинд бэлтгэх ажил хэр зэрэг явж байна вэ? Яагаад гэвэл энэ хийн түлш нь бэлэн биш байгаа болохоор дахиад хүний амь нас эрсдэх, аюулгүй ажиллагааны энэ зүйлийг одоогоос эхэлж хийж эхэлмээр байна. Тэгэхээр энэ дээр хотын захиргаа ирсэн учраас хотоос би асууж байна. Ингээд энэ 5 асуултад хариулт өгөөч.

Д.Амарбаясгалан: 5 асуултад хариулъя. 4 дүгээр индрээс хариулт өгнө. Энэ асуудлыг Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу 1 цагийн дотор хэлэлцэж дуусахаар байгаа, сунгах хугацаа байхгүй. Тийм учраас одоо 35 минут үлдсэн, 5 гишүүн асуулт асууна, хариулт авна. Маш товч, тодорхой хариултууд өгнө шүү.

А.Амартүвшин: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Гишүүний асуултад хариулахад хийн түлшний судалгаа ажил ерөнхийдөө хийгдээд дууссан байгаа. Одоо гүйцэтгэлийн ажил дээр бид нар орсон байгаа. Хийн түлшний ажлын зэрэгцээгээр бид нар цахилгаан, мөн цаашлаад дулаалга гээд ийм 3 фронтоор нийслэл ажлаа хийгээд явж байгаа. Эхний ээлжид бид Байгаль орчны яам, Байгаль орчны яамтайгаа хамтраад ногоон бүс, шар бүсээр нийслэл хотоо хуваагаад, ингээд шар бүс дээр нийтдээ 67 мянган айл, ногоон бүс дээр 103 мянган өрхөөр хуваагдаад. Энэ жилдээ бид нар ногоон бүсийнхээ 103 мянган айлынхаа 52 мянган айлыг ингээд цахилгаан болон хийн түлш рүү шилжүүлэх бэлтгэл ажлаа хангаад, мөн 52 мянган айлын дулаалгын асуудлыг хийх бэлтгэл ажлаа хангаад явж байна. Хийн түлшинд бид нар нийтдээ 30 мянган айл өрхийг хамруулна. Цахилгаанд Эрчим хүчний яамтай бид ярилцаад, Эрчим хүчний яамнаас судалгаагаа хийгээд, энэ жилийн өвөл 25-аас 26 оны өвөл нийтдээ нэмэлтээр дахиад 17600 айл өрхийг цахилгаанд холбож, цахилгаанаар тасалдахгүйгээр хангах боломжтой гэдэг үндэслэл дээр бид 17 мянга гаруй айлыг цахилгаанд холбоно.

Бусад 30 мянган айлыг бид нар хийн түлштэй ингээд холбоод явна. Эд нар хийн түлштэйгээ бид нар холбохтойгоо зэрэгцээ мэдээж бид нээлттэй тендер зарлана, нээлттэй тендерээ зарлаад бид компаниуд шалгараад явна. Энэ дээр гол тавигдаж байгаа шаардлага нь гэвэл хийн түлшнээсээ бид нар карбон кредитээ авна. Карбон кредитээ бол зарах энэ асуудлууд явж байгаа. Одоогийн байдлаар Бүгд найрамдах Хятад Улсын 2 компани манай 52 мянган айлаас гарч ирж байгаа карбон кредитийг худалдаж авах саналаа нийслэлд хүргүүлээд ирсэн байгаа. Ямар ч байсан бид хууль ёсны дагуу тендер зарлаж, энэ компаниудыг шалгаруулаад явна. Тендер дээр мэдээж мөн нөгөө цахилгаанаар халаах цахилгаан халаагуур, мөн цаашлаад нөгөө дулаалгууд бүгд тендерээр явна. 6 сарын, дараа долоо хоног

гэхэд бид нар тендерээ зарлана гэж төлөвлөөд явж байгаа. Тэгээд ямар ч байсан 6 сардаа багтаагаад энэ 3 ажлыг гурвууланг нь хийгээд явна.

Аюулгүй байдлын асуудлаар гишүүн асуулаа. Аюулгүй байдлын асуудал дээр бид нар газны аюулгүй байдлын асуудал, Азийн сантай бид нар хамтарч ажиллаж байгаа. Азийн сан бол яг энийг бие даагаад, хариуцаад нийслэлтэй хамтарч явна. Эхний шатдаа бид төрийн байгууллага бол цагдаа, онцгой байдал ийм хүчний байгууллагууд дээр газын хэрхэн аюулгүй байдлыг хангах, газын аюулгүй байдлын талаар олон улсын түвшинд сургалтуудыг нь оруулаад, гаднын мэргэжилтэн, экспертүүдийг авчирч хуралдана. 2 дахь шат нь 8 сард бид нөгөө дүүрэг, нийслэл, дүүргийн ажилтан, хорооны ажилтнууд дээр сургалтууд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

А.Амартүвшин: Тэгээд 9 сард, бид 8 сарын сүүлээс эхлээд 9 сар дээр иргэдэд яг үзүүлэнгээр нь ингээд явна. Одоогоор ингээд яг аюулгүй байдлын сургалтууд нь ороод явахаар яг ямар газын төхөөрөмж, яаж, ямар газын төхөөрөмжийг бид ашиглах гэж байгаа гэдэг нь яг тендерээр шалгагдаад, батлагдаагүй болохоор бид шууд ийм, ийм аюулгүй байдлыг хангаж явна шүү гэдэг шууд сургалтыг явахад хууль, эрх зүйн хувьд хүндрэлтэй, асуудалтай байгаа. Газын хувьд тийм байгаа.

Гэр мөн гэр дулаалга, газ тэгээд цахилгаан, дулаалга энэ гурвуулаа хамтдаа явж байгаа. 6 сар гэхэд ингээд тендерүүд нь зарлагдаад, 6 сарын сүүлээр бүх ажил эхэлнэ гэсэн төлөвлөгөөтэй явж байгаа. Судалгаа шинжилгээг бүгдийг нь бид хийгээд дууссан. Нийтдээ бид нийтдээ дулаалгын хувьд гэвэл нийтдээ бид судалгаанаас нийтдээ 2052000 мянган м² гэр дулаалгыг бид энэ жил хийх ёстой. Мөн дээврийн 1,3 сая дээврийн дулаалга хийж байж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одонтуяа сайд нэмж хариулт өгье.

С.Одонтуяа: Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ айл өрхөд хэрэглэгдэх хийн зуухны тоног төхөөрөмж гээд байгаа. Тэгэхээр энийг яах вэ янз бүрийн хүмүүс ингээд зарим нь энэ чинь их дуутай ч гэдэг юм уу, шаардлага хангахгүй, гэрт тохиромжгүй гээд янз янзын асуудал яригдаж байгаа. Тэгэхээр өнгөрсөн Үндэсний хорооны хурал дээр энэ айл өрхөд хэрэглэгдэх хийн зуухныхаа тоног, төхөөрөмжийг Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны дэргэдэх эрдэмтдийн зөвлөлийн хурлаар заавал оруулах ёстой. Энэ дээрээсээ зөвлөмж гаргуул гэдгийг шийдвэрлэсэн байгаа.

2 дугаарт энэ сайжруулсан шахмал түлшний асуудал олон жил зөвхөн нөгөө төрийн өмчит байгууллага дээр хийгдээд, энэнээс болоод бүх хувийн хэвшил хаагдсан, хувийн хэвшил нийлүүлэх боломжгүй болсон. Тэгэхээр Үндэсний хороон дээр ерөөсөө энэ ААН-үүдийг ерөөсөө бүгдийг нь татан оролцуулъя. Үнэхээр шаардлага хангасан сайжруулсан түлшийг гаргаж ирж байгаа тийм газруудыг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

С.Одонтуяа: Шаардлага хангасан байвал энэ нь төрийнх байна уу, хувийнх байна уу, импортынх байна уу энэ бүх асуудлыг гол нь түлшний чанарыг л 1 дүгээрт

тавья. Тийм учраас энэ асуудалд энэ хувийн ААН-үүдийг татан оролцуулах ажлыг Тавантолгой түлшинд даалгасан байгаа.

Дээрээс нь нэг асуудлыг зайлшгүй хэлэх ёстой. Бид өмнөх үйлдвэрээ шаардлага хангахгүй гээд хаачихсан. Гэтэл энэ Эрдэнэс Тавантолгойн олборлож буй тэг давхаргын нүүрсний баяжуулсан нүүрсний чанарын үзүүлэлт бол уг түүхий эдээр үйлдвэрлэсэн түлшний үзүүлэлт бол стандартын шаардлага хангаагүй, өнөөдрийг хүртэл яг энэ түлш шаардлага бол хангачихлаа гэсэн ийм түлшгүй сууж байгаа. Дээрээс нь Эрчим хүчний сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн туршилт, судалгааны ажлууд ч гэсэн тайланд энэ шаардлага хангахгүй гарсан. Тийм учраас энэ дээр Үндэсний хороо хуралдаж, шаардлагатай боломжит бүхий л.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя, үг хэлье.

Х.Баасанжаргал: Би Үндэсний хороог 2 зүйлд анхаарлаа хандуулаасай гэж бодож энэ асуултыг асууж байгаа. Юу вэ гэвэл 1 дүгээрт угаарын хий мэдрэгчийн асуудал дээр. Энэнтэй холбоотой тоо статистик мэдээлэл тун бага олдсон.

2 дугаарт иргэдийн өөрсдийнх нь зан үйлтэй холбоотой асуудал гээд. Бид ямар ч түлш хэрэглэсэн бай тухайн ашиглаж байгаа иргэдийн өөрсдийнх нь зан үйлд хэр нийцтэй юм бэ, хэр ашиглаж чадах юм бэ гэдгээ бид ерөөсөө урьдчилж тооцоолохгүйгээр яг энэ шахмал түлш рүү шилжсэнтэй холбоотой маш олон иргэдийг бид угаарын хийд алдсан. Тэгээд би нэлээн олон газраас тоон мэдээ цуглуулж, нэлээн ийм статистикуудыг хооронд нь тулгах гэж үзлээ. Бүгд хоорондоо маш их зөрөөтэй гарч ирж байна. Ялангуяа энэ нөгөө нийслэл дээр чинь нэг агентлаг байдаг юм уу, нийслэл дээр агентлаг байж болдог юм уу, үгүй юм уу мэдэхгүй. Тэгэхдээ ямар ч байсан нийслэлийн нэг эрүүл мэндийн агентлаг гээд газраас ирсэн тоо, Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын тоо гээд ингээд энэ бүх тоонуудыг тулгаж үзлээ. Тэгээд хамгийн сүүлд энэ Ерөнхий прокурорын газраас ирсэн тоо нэлээн баримттай тоо ирсэн. Нийтдээ 5613 иргэн угаарын хийн хордлогод өртсөн дуудлага, мэдээлэл ирсэн байгаа юм. Эдгээрийн 95,6 хувь нь дан шахмал түлш байгаад байгаа юм. Шүүхийн шинжилгээний тоонууд болохоор шахмал түлшнээс гадна нөгөө автомашинд, гал түймэр гээд өөр бусад аваар осолтой холбоотой нас барсан иргэдийн тоог шүүхийн шинжилгээний тоо дотроо оруулаад тоолчихдог юм байна. Тэгэхээр бид их төөрөгдөөд байдаг ийм зүйл байгаад байгаа юм байна гэдгийг анхаарах гэсэн.

2 дугаарт яг энэ тоонуудыг ингээд хараад үзэхлээр яг энэ нас барсан нийтдээ 358 иргэн гээд ингээд он оноор нь харвал 2020 оноос хойш яг энэ угаарын хий хордлого, ялангуяа шахмал түлштэй холбоотой нас барсан иргэдийн тоо эрс нэмэгдэж байгаа. Тэгээд 2023 онд 69, 2024 онд 75 иргэн ингээд нас барсан гээд. Дийлэнх нь Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг жишээ нь байх жишээтэй. Тэгээд эргээд эдгээр иргэдийн нас барсан иргэдтэй холбоотой ялангуяа хяналт мөрдөн байцаалтын ажиллагаа хийх явцад угаарын хий мэдрэгч нь ажиллаагүй байсан тохиолдолд дийлэнх нь байсан. Тэгэхээрээ ерөөсөө энэ угаарын хий мэдрэгч гэдгийг тарааж өгчхөөд, тэрэнтэй холбоотой сургалт явуулах, угаарын хий мэдрэгчээ шалгах ч гэдэг юм уу ингээд нөгөө эргэж угаарын хий мэдрэгчээ байнгын ажиллагаатай байх энэ хяналт ерөөсөө энэ хороон дээр зайлшгүй анхаарах хэрэгтэй байна. Энийг та бүхэн ирэх өвөл гэхэд анхаарахгүй болохгүй нь гээд.

2 дугаарт гэвэл тэр ялангуяа угаарын хий мэдрэгчийн хувьд батарей нь дуусчихдаг юм байна. Иргэд ихэвчлэн батарейг нь дууссаныг мэддэггүй юм байна. Дээрээс нь ажиллаж байгаа эсэхээ шалгаж мэддэггүй юм байна. Би энэ хавар зөндөө олон айлаар нэлээн хэдэн айлаар ороод ингээд асуугаад ярилцаад явж байхад яг бараг ихэнх нь ингээд ажиллахгүй энэ ерөөсөө ажилладаггүй гээд ингээд цааш нь ингээд аваад тавьчихсан. Гэтэл угаарын хий мэдрэгчид бид багагүй мөнгө зарцуулчихаад байгаад байдаг. Тэгэхээр энэ зүйл дээрээ анхаараач анхаараач гэж хүсэх гэсэн юм.

Тэгээд хамгийн сүүлд асуулт юу вэ гэвэл ирэх жил, одоо угаарын хий мэдрэгч ханган нийлүүлээгүй нэлээн хэдэн айлуудын тоо нэлээн өндөр гарч байна. Нийслэлийн зүгээс яг энэ угаарын хий мэдрэгчтэй холбоотой цаашдаа авах арга хэмжээ, төлөвлөгөө юу байгаа вэ? Үндэсний хороо энэ дээр яаж анхаарч байгаа вэ? Хамгийн сүүлд орон нутаг дахь агаарын бохирдлын асуудлыг яах вэ? Өвөрхангай аймаг байна, Баянхонгор аймаг байна маш өндөр агаарын бохирдолтой аймгууд байна. Эдгээр энэ аймаг, орон нутгууд дээр ямар үйл ажиллагаа төлөвлөж, ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа вэ гэдэг ийм асуулт. 2 асуулт.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. 4 дүгээр индэр. Эхлээд Одонтуяа сайд хариулт өгье.

С.Одонтуяа: Энэ 21 аймгийг асууж байна. Тэгэхээр энэ түрүүн Бат-Эрдэнэ гишүүн хэллээ л дээ. Энэ ер нь энэ Үндэсний хороо гээд ингээд эхлээд л орчны бохирдлынх гээд л байж байснаа хаалаа, Эрчим хүчинд хариуцууллаа, нийслэлд хариуцууллаа, одоо Байгаль орчинд гээд. Тэгэхээр ер нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд энэ агаарын бохирдлыг хариуцуулах нь өөрөө туйлын буруу гэж хэлж байгаатай би санал нийлж байна. Байгаль орчны яам бол хяналт тавьдаг газар. Стандартаа өгөөд л, танайх ямар ч газар бай төрийнх байна уу, хувийнх байна уу ерөөсөө танайх энэ утаа, энэ угаар чинь стандартаас хэтэрсэн байна энийг бид ажиллуулахгүй гэдэг энэ салбарын хяналт нь очоод, энэ стандартаа мөрдүүлэх ёстой газар байхгүй юу. Гэтэл өөрсдөө дотор нь хэрэгжүүлэгч болоод эрчим хүчний ажлыг барьж хийх гээд, нийслэлийн ажлыг хийх гээд. Тэгэхээр энэ бол туйлын буруу. Тэгэхээр энийг өөрчлөх ёстой юм байгаа юм.

Автомашин утаа маш их байгаа. Тэгэхээр энэ дээр манай Үндэсний хороо нийслэлтэй хамтраад маш амжилттай ажиллаж байгаа. Жишээлэхэд өчигдөр бид нар энэ автобус бааз 5 дээр очсон. Зорчигч тээврийн 5 дээр очиход нийт 110 гаруй автобусандаа тэр мэдрэгч, утаа мэдрэгч, утаа багасгагч төхөөрөмжүүдийг суулгасан. Бид эргээд түргэний машин, энэ төрийн өмчит компаниудаа ингээд түргэн шуурхай хийгээд ингээд дуусгана. Дээрээс нь хувийн хэвшлүүдэд уриалга гаргана. Та нар энэ утааныхаа асуудлыг энэ стандартын дагуу болох ёстой гэдгийг.

Угаарын хий мэдрэгч, энэ зан үйлтэй холбоотойг ерөнхийдөө нийслэл яг айл өрхөөр нь бүгдийг нь мэдэж байгаа учраас хариулах хэрэгтэй. Манай бид ажлаа яг нарийвчилж хувааж авахдаа энэ 173 том уурын зуухыг манай Үндэсний хороо хариуцаад шинэчлэлээ хийгээд эхэлсэн. Айл өрхийг 100 хувь нийслэл хариуцаж байгаа учраас нийслэл энэ дээр хариултаа өгсөн нь зөв байх.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт 4 дүгээр индэр.

А.Амартүвшин: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Манай Улаанбаатар хотод өнгөрсөн өвөл нийслэлээс тооллого хийсэн байгаа. Нийтдээ яг өнөөдрийн байдлаар 171976 айл өрх гэр хороололд амьдарч байна. Үүнээс яг өнөөдрийн байдлаар 109 угаар мэдрэгч ажиллаж байна. 109 угаар мэдэрч 109 мянган угаар мэдрэгч ажиллаж байгаа. Энэ нь ямар угаар мэдрэгч вэ гэвэл үндсэн нэгдсэн систем дээр холбогдсон, угаарын дохио мэдээлэл байвал манай мэдээллийн нэгдсэн систем дээр хяналтын баг дээр тэр мэдээлэл нь ингээд дэлгэц дээр ингээд гараад, гарч ирдэг. Тэгээд дэлгэц дээр гарч ирэнгүүт нь тухайн айл өрхийн хаяг address, холбогдох утасны дугаар, ах дүү, хамаатан хамаатнуудын мэдээлэл нь гарч ирнэ. Манай мэдээллийн системээс шууд эд нарыг холбогдох хүмүүстэй нь ингээд холбогддог. Тухайн үед нь ингээд холбогдох боломжгүй байгаа бол манай Нийслэлийн түлш хэрэглэгчдийн үйлчлэх төв дээр улирлын чанартай яг галлагааны улиралд ажиллаж байгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

А.Амартүвшин: 500 улирлын чанартай ажиллаж байгаа 500 ажилтан ажиллаж байгаа. Эдгээр ажилчдыг тухайн байршилд хамгийн ойр байгаа ажилтанд мэдээлэл хүргэж, энэ ажилтан тухайн болж байгаа угаартлын үүсэж байгаа газар дээр нь очиж, нөхцөл байдалтай нь дүгнэлт хийгээд ажилладаг байгаа. Энэ дээр ингэж явж байгаа. Энэ жил нийслэлээс бүх айлыг энэ смарт дугаар мэдрэгч дээр холбохоор ажиллаж байгаа. Одоо нэмэлтээр үлдэгдэл 60 мянган угаар мэдрэгчийн ингээд тендер зарлагдчихсан, дараа долоо хоногт ингээд тендерийн нээлт нь хийгээд, энэ 9 сарын галлагааны сезон эхлэхэд ингээд бүх айлууд маань ингээд угаар мэдрэгчтэй ингээд холбогдоно. Нас баралт нөгөө угаартаж байгаа иргэд болон угаараас болон нас баралттай холбоотой асуудал мэдээж юун дээр яригдсан. Та бол эрхэм гишүүн та бол дурдаж хэллээ. Хэлэлцүүлгийн дараагаар ингээд Эрүүл мэндийн яам.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Баярлалаа. Тэгэхээр энэ ерөнхий хяналтын сонсголд 2 ч удаа оролцсон, санал онолоо хэлж л байсан. Чухам яаж анхаарч авсан нь мэдэгдэх юм алга. Саяын Байнгын хорооны санал, дүгнэлт дээр ч дурдсан юм алга. Тэр нь ч яах вэ. Ер нь энэ агаарын бохирдлыг бууруулах асуудал хамгийн хурцаар тавигдаж шийдвэрлэсэн үе бол энэ 2017 оны 1 дүгээр сард Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж гараад, БСШУС-ын сайдаар ахлуулсан ажлын хэсэг гарсан юм байгаа юм. Тэгээд тэр ажлын хэсэгт миний бие дэд ахлагчаар нь ажиллаж байсан юм. Тэгээд энэ ажлын хэсгээс үндсэндээ агаарын бохирдлыг бууруулахад 4 чиглэл барьж явах нь зүйтэй байна гэсэн дүгнэлт гарсан.

Саяын сонсголын үед ингээд хараад байхад тэр 4-өөс өөр шинэ юм ерөөсөө шинээр гарч ирэхгүй байгаа юм. Яагаад вэ гэхээр зэрэг урьд нь байсан энэ ажлын хэсгийн тайланг үзэж, хараад, дүгнэлт тооцоог нь анзаарсан хүн байгаагүй гэж би бодоод байдаг. Тэгэхээр энэ тайланг энэ ЗГ-т хүлээлгэж өгсөн тайланг 2017 оны 4 дүгээр сарын дундуур хүлээлгэж өгсөн. Энэ тайланг та нар нэг авч цаашдынхаа ажиллагаанд анхаарч үзээч. Энэ тайлан дотор агаарын бохирдлыг бууруулахад 1 дүгээрт түлш зуухаа сайжруулах, 2 дугаарт дулаалгаа сайжруулах, 3 дугаарт цахилгаанаар халаах, 4 дүгээрт алсдаа орон сууцжуулах гэсэн энэ 4 санал бүгд тооцоо шинжилгээтэй. Ингээд давын өмнө хамгийн түрүүн хийж болох ажил бол гэрийн дулаалгын асуудал. Манай Лувсанжамц гишүүн энэ асуудлыг яриад байгаа.

Гэрийн дулаалгыг манай ажлын хэсэг Тосонцэнгэл, Улаанбаатар хотод 5 ханатай Монгол гэр дээр хийж үзээд, дулаалгыг зүй ёсоор нь хийчихэд эрчим хүчээр халаах зардал 60 орчим хувь буурах нь. Дулааны алдагдал 60 орчим хувь буурах нь гэдгийг тогтоогоод өгчихсөн. Монголын зах зээл дээр байдаг материалаар гэрийн дулаалга хийж болох юм байна, тэр бүгд тогтчихсон байгаа юм. Гэх мэтчилэн тэр тайлантай ажиллаж байгаад та бүхэн маань энэ ажлын хэсгийнхэн дараагийнхаа ажлыг үзвэл их мэдээлэл байгаа. Энэ дээр бид нар нэг ойлголт, харах зүгээ нэг чигт хандуулмаар байгаа юм.

Түлшний стандартыг нэлээн шүүмжилсэн. Саяын сонсгол дээр. Тэгэхээр түлшний стандарт гэдэг чинь түүхий эддээ тохируулж хийдэг эд гэдгийг ерөөсөө ойлгох хэрэгтэй. Ямар түүхий эдээр түлш хийнэ тэр тийм л түлш гаргана. Махаар бууз хийвэл махан буузны стандарт гэдэгтэй адилхан. Тэгэхээр түлшний стандартыг түүхий эддээ тааруулж хийлээ, хүндээ тааруулж хийсэнгүй гэж шүүмжилж байгаа улсуудын шүүмжлэл бол ямар ч шинжлэх ухааны үндэслэл байхгүй. Ямар түлшээр модоор хийвэл модон түлшиндээ тааруулсан, модон түүхий эддээ тааруулсан ийм л стандарт гарах юм байгаа юм. Энийг хэлэхэд одоо модон шахмал түлшний асуудлаар та бүхэн маань юу гэж бодож байгаа юм бэ? Энэ хувийн хэвшлүүдийн зарим нэг саналыг харахад өнөөдөр Тавантолгой түлш компанид зориулж энэ түлшинд зарцуулж байгаа зардлын 50 хувиар цэвэр модны үртсэн шахмал түлшийг гаднаас авч хангах боломжтой гэж танилцуулаад байгаа. Энийг судалж үзсэн үү? Ингэвэл агаарын бохирдол эрс буурах нь маш тодорхой юм байгаа юм 1 дүгээрт.

Нөгөө талаасаа Тавантолгой түлш компанид ажиллаж байгаа тэр улсынхаа эрүүл мэндийг бид нар бодох ёстой. Тийм нөхцөлд хэдэн жил ажиллаад силикозтой болно угаасаа ажиллагсад. Тэгээд дараа нь тэд нарыг эмчлэх зардал гээд дахиад л цаашаа яваад өгнө. Тэгэхээр түлш солих тал дээр та бүхэн маань ямар бодолтой байна вэ гэдэг нэг ийм юм байна.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Одонтуяа сайд.

С.Одонтуяа: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ утааны сонсголын дараа манай Агаарын бохирдлын үндэсний хороо нэлээд ачаалалтай ажилласан. Яагаад гэхлээр маш олон иргэд ирээд би ийм зуух ийм юм зохион бүтээсэн энийг үзээч гээд. Эрдэмтдийн зөвлөл байгуулаад, Эрдэмтдийн зөвлөл дээр энэ бүх асуудлыг бүгдийг нэг бүрчлэн сонссон. Тэгээд зарим нь шаардлага хангаагүй, үнэхээр энэ шинжлэх ухааны үндэслэлгүй юм байна гэж үзсэн зүйл бий. Зарим нь энэ хэрэглэж болох юм байна, тэнд янз бүрийн цахилгаан халаагуурууд байна, хий халаагуур, агаарын pump энэ тэр гээд янз бүр. Таны асуусан тэр модон шахмал түлш дээр бид Оросын Холбооны Улсад үйлдвэрлэсэн ийм модон шахмал түлш өөрсдөө Эрхүүд, Улаан-Үдэд хэрэглэдэг юм байна. Энийг авчраад бид нар олон дахин туршилт хийж үзсэн. Харамсалтай нь энэ түлшний угаар нь их өндөр гарсан, стандарт зөвшөөрөгдөх хэмжээнээс маш өндөр гарсан. Тэгээд энийг түрдээ энэ асуудлыг хаасан байгаа. Яагаад гэхлээр ер нь зүгээр бид ч гэсэн ингээд нэг шорлог энэ тэр хийж байхад нэг л их утаа их гардаг шүү дээ. Түүн шиг мэдээж экологи талаасаа хүний биед хор багатай байгаа. Тэгэхдээ хэмжилтээр маш олон удаа хэмжсэн, олон улсын лабораторид хэмжсэн, манай энд хэмжсэн, Хятадад аваачиж, тэгэхээр угаар нь их өндөр гараад байгаа учир тэр асуудлыг тэгээд орхисон байж байгаа.

Дулаалга дээр сая талбай дээр олон яамд, Үндэсний хороо хамтраад үзэсгэлэн гаргасан. Энд иргэд дулаалахад бэлэн байна, ААН-үүд дулаалах материал хангалттай байна, өөрсдөө хийж байна, оруулж ирж байна. Гагцхүү юун дээр бүгд гацаж байна гэхээр ногоон хөнгөлөлттэй зээл дээр бүгд гацаж байна. Үгүй ээ энэ дээрээ та нар ногоон хөнгөлөлттэй зээл өг л дөө гэхээр банкнуудынх нь ногоон зээл гэж байгаа нь хүү асар өндөр. Тэгэхээр бид энэ Улсын Их Хурлаар, ер нь ЗГ-аар энэ хөнгөлөлттэй ногоон зээлийн асуудлыг шийдвэл зүгээр энийг иргэд ч, ААН-үүд өөрсдөө хийчих ийм боломж байгаа. Цахилгаан халаагуур ер нь манайд маш тохиромжтой. Яагаад гэхээр ерөөсөө дэлхийн улс орнууд салсан 2 арга л байгаа шүү дээ. Газ, цахилгаан. Тэгэхээр газ өөрөө их зарим үед эрсдэлтэй, аюултай. Тийм учраас манайд цахилгаан халаагуурууд хамгийн тохиромжтой. Тийм учраас бүсчлэлээр нь ер нь ангилсан, аль хэсэгт цахилгааны ачаалал даахаар байна, аль хэсэгт ер нь цахилгааны ачаалал даахааргүй байна гэж ангилаад, энэ цахилгааны халаагуурууд бол Эрдэмтдийн зөвлөлөөр орсон. Олон улсад угаасаа хүлээн зөвшөөрөгдчихсэн юунуудыг стандартыг нь дэмжээд ингээд явж байгаа.

Би сая дахиад хэлэхэд нэг ноцтой зүйл юу вэ гэхээр манай одоо гарсан өнөөдрийг хүртэл хийсэн манай Тавантолгойн туршилтуудаар стандартын шаардлага хангасан түлш гарч ирэхгүй байна. Гэхдээ сүүлийн үед хэд хэдэн хувийн хэвшил бид нарт нэг аятайхан мэдээ дуулгаад байгаа нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

С.Одонтуяа: Манай энэ Тавантолгойд жишээ нь тэг давхаргын нүүрсийг Хятадад аваачаад том химийн үйлдвэрүүд дээр тэндэх барьцалдуулагчтай нь холбоод ингээд гаргахад эхний туршилтууд маш амжилттай байна гэдэг ийм мэдээллүүдийг бидэнд ирүүлсэн. Тэгэхдээ энэ бол хараахан яг бид нар дахиад өөрсдөө стандарт яагаад манай Эрдэмтдийн зөвлөлөөр ороогүй байгаа. Тэгэхээр бид нэг болгоомжлол нь ингэсээр байгаад нөгөө хүйтний улирал эхэлчих вий гэж байгаа учраас Нямбаатар дарга ямар шаардлага тавьж байгаа вэ гэхээр шаардлага хангасан тодорхой хэмжээний импортын түлш оруулж ирэхэд бид бэлэн байя гэдэг ийм зүйл байгаа. Тэгээд би түрүүн хэлсэн зөвхөн төр гээд байхаар болохгүй учраас хувийн хэвшлийг нээлттэй болгож өгөөд, энэ дээр идэвхтэй оролцуулж, тэр тендерт нь хувийн хэвшил чөлөөтэй орох ийм боломжуудыг нь нээж өгье гэсэн ийм зүйлүүд байна.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя хотоос.

А.Амартүвшин: Рэгдэл гишүүний асуусан асуултад нэмэлт хариулт өгье. Дулаалгын асуудал нийслэл дээр нийтдээ гэр дулаалга, байшин дулаалга гэж 2 хуваагаад ажлын хэсэг гараад явсан байгаа юм. Нийслэлийн засаг даргын А/482 дугаар захирамжаар бид 5 дүүргийн 35 хорооны 474 хорооны албан хаагчдыг дайчлаад, 4 сарын 23-наас 5 сарын 9-ний хооронд энэ гэр дулаалга, байшин дулаалгынхаа бүх тоог эцэслээд, дээрээс нь байшин дулаалгынхаа хэмжилтийг хийж дуусгасан. Үүн дээрээс ингээд харахад гэр дулаалга дээр бид нийтдээ 4 ханатай 1531 гэрийг бид дулаалах төлөвлөгөөтэй байна. 5 ханатай 13395, 6 ханатай 849, тэгээд 8 ханатай 223 гэрийг бид энэ ногоон бүс дээр энэ жил дулаалахаар төлөвлөж байна. Дулаалга дотроо давхар дулаалгатай 7285 айлыг бид давхар дулаалах шаардлага байна. Дан дулаалгатай.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

А.Амартүвшин: Дан дулаалах 8138 айлыг ингээд дан дулаалаад, ингэснээр 51080 айлынхаа гэр хорооллынхны гэрийн дулаалгыг ингээд шийдээд явж байгаа. Байшинд бид тоосгон, мод, хөнгөн бетон, шавар болон бусад гэдгээр нь судалгаа гараад тэдний дулаалгыг нь яг энэ баригдсан материалаар нь ялгарч ялгаж, энд дулаалгын материалуудыг сонгон шалгаруулалтаа зарлагдана. Нийтдээ 22667 байшинг энэ жил бид дулаалахаар төлөвлөж байна. Үүнээс тоосгон байшин 7477, мод 5778, хөнгөн бетон 4221, шавар 3051 тэгээд бусад 2120 ийм байшингуудыг бид дулаалахаар ингээд төлөвлөөд тоо статистик нь бүгд гараад, судалгаа нь хийгдээд дууссан байгаа.

Д.Амарбаясгалан: Дүгэрийн Рэгдэл гишүүн тодруулж асууя.

Д.Рэгдэл: Тодорхой хариулт өгч байгаа явдалд баяртай байна. Тэгэхдээ зэрэг энэ гэрийн дулаалга дээр ерөөсөө гэрийн дулаан хаагуураа алдаж байна вэ гэдгийг маш сайн тооцож байж хийхгүй бол бүрээсийг нь солиод сайхан юм болчихгүй. Гэрийн дулаалгыг шалаараа хэдэн хувиа дулаанаа алдаж байна, тооноороо хэд, хаалгаараа хэд вэ гэдэг хийгдчихсэн, зөндөө туршилтаар тогтоочихсон тэр бүхнийг сайн тооцох хэрэгтэй.

2 дугаарт модон шахмал дээр угаар ихтэй байна гэдэг бол нэгэнт шинжилгээгээр гарч байгаа бол тийм л гэсэн үг. Тэгэхдээ энэ нь тэр модон шахмал угаар ихтэйдээ биш. Модон шахмалыг түлж байгаа зуухны жишээ нь агаарын солилцоо хүрэхгүй, хүчилтөрөгч нь дутаад байгаатай холбоотой. Тийм учраас хүчилтөрөгч агаарын солилцоо сайтай зууханд түлбэл энэ угаар багасах бүрэн боломжтой.

3 дугаарт би юу хэлэх гэж байна вэ гэхээр зэрэг энэ Тавантолгой түлшний түлшийг сайжруулсан шахмал түлш гэдгээ больё л гэх гээд байгаа юм. Энэ бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ө.Шижир: Баярлалаа. 2008 оноос хойш улсын төсөв болон нийслэлийн төсөв дээр энэ утаатай холбоотой асуудлуудыг шийдэх байдлаар мөнгө тавьж ирсэн юм байна лээ. Анх 2008 оноос. Тэгээд ер нь энэ утаа бол өөрөө ядуурлын утаа л даа. Тэгээд дээр нь төрийн буруу бодлогын утаа. Өнөөдрийг хүртэл 2014 оноос л статистик бүртгэл дээр бүртгэж эхэлсэн гэж үзвэл 4 мянга орчим иргэн угаартаж, түүнээс 790 орчим нас барсан. Үүн дээр ямар нэгэн хариуцлага, тодорхой шийдсэн шийдэл өнөөдөр хүртэл байдаггүй.

Тэгээд би Үндэсний аудитын байгууллага байгаа гэсэн учраас хэдэн юм асуух гэсэн юм. 2018 онд жишээ нь Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр гэж батлаад, 336 тэрбум төгрөг төсөвлөөд, энийг зарцуулсан. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх гээд 243,6 тэрбум төгрөг зарцуулсан. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулаад Цэвэр агаар санг байгуулаад 111,9 сая төгрөг зарцуулсан. Цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт, зээлийн ногоон хүүгийн татаас гээд нийтдээ өнөөдрийг хүртэл 46,1 тэрбум төгрөг бас зарцуулжээ. Агаарын чанарын бүсэд айл өрх, ААН-д хийсэн нөлөөллийн арга хэмжээ гээд 36,1 тэрбум төгрөг зарцуулжээ. Орчны бохирдлыг бууруулах ажлын албаны үйл ажиллагааны зардалд гээд 2,4 тэрбум

төгрөгийг зарцуулжээ. Нийслэлийн агаарын чанарын бүсэд чиглэсэн хөрөнгө, төсөл, арга хэмжээ гээд 44,6 тэрбумыг зарцуулжээ. Тавантолгой түлш хувьцаат компанийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэл, түгээлттэй холбоотой 67,8 тэрбумыг бас санхүү зарцуулжээ. Хяналт шалгалтын хүрээнд агаарын бүсэд түүхий нүүрс оруулахыг хориглох тухай гээд 16,3 тэрбумыг зарцуулжээ. Үүн дээр нэмэх нь Эрдэнэс Тавантолгой төсөл гээд, Эрдэнэс Тавантолгой компанид биш ээ, Тавантолгой түлш компанид Эрдэнэс Тавантолгой компаниас эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр 1,5 их наяд төгрөгийн зээл олгожээ. Ингээд ил байгаа нь 2,4 их наяд төгрөгийг 2008 оноос миний мэдэж байгаа мэдээллээр та бүгдийн хийсэн сонсголын тайлан дээр зарцуулсан байна. Тэгэхээр 2008 оноос хойш улс, нийслэл, орон нутаг, гадаадын зээл тусламж, гаднын тусламж өөр юунууддаа нийт яг утаанд хэдэн их наяд төгрөг зарцуулсан юм бэ гэдэг эхний асуулт Үндэсний аудитаас?

Хоёрдугаарх нь сая Нийслэл хотын орлогч дарга 4, 5, 6, 8 ханатай гэр, 10 гаруй хэдэн модон байшин гээд миний ерөнхий тооцоолсон 30 гаруй мянган гэр, байшинг дулаалах юм байна. Энэ дулаалгын санхүүжилт, түүний эх үүсвэр нь хаанаас санхүүжиж байгаа вэ, нийт төсөвт өртөг нь хэд вэ гэсэн ийм 2 асуулт. Яагаад энийг асуугаад байна вэ гэхээр 2008 оноос хойш бид нар улсын төсөв дээр мөнгө тавиад, яг бодитойгоор 2018, 2019 онуудад утаа бодитойгоор буурах нь буурсан. Түүнээс хойш алдчихсан. Тэгээд бас л та бүгдийн тайлан дээр мидлинг болон хагас коксоор үйлдвэрлэсэн сайжруулсан түлшний техникийн үзүүлэлтийг харьцуулахад дэгдэмхий нь 51,9, хүхэр нь 57,7, үнслэг нь 37,2 бага байсан нь агаарын түлшний чанаргүй болгохыг туршилтаар тогтоосон гэж байгаа юм. Тэгээд 2, 3 жил ийм чанаргүй мидлинг болон хагас коксоор бид шатахуун үйлдвэрлээд байгаа нь өнөөдөр энд тухайн саруудад жирэмсэн болсон эмэгтэйчүүд, хүүхдүүдэд энэ бол шууд бид хүүхэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэдэг Үндсэн хуулийн зөрчлийг шууд утгаараа бий болгож байгаа юм. Тэгэхээр би саяын 2 асуултдаа Үндэсний аудитын газраас, тэгээд нийслэлээс тодорхой хариулт аваад, дараа нь тодруулъя.

Д.Амарбаясгалан: Нийслэл, нэмээд Аудитын газраас хариулт өгье. 4 дүгээр индэр.

А.Амартүвшин: Шижир гишүүний асуултад хариулъя. Бид бол санхүүжилтийг босгохын тулд Олон улсын байгууллага болон Дэлхийн банк зэрэг байгууллагуудтай харьцаад энэ асуудлыг тавиад явж байгаа. Тэгэхдээ нийслэл ямар нэгэн өр зээл тавих гэхээсээ илүү өөрийнхөө боломжийн хүрээнд энэ асуудлыг өөрийгөө нийслэлийнхээ санхүүжилтийн хүрээнд энэ асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөөд явж байгаа. Нийслэл дээр ингээд суухаар тооцоо судалгаа нь одоо гараад явж байгаа. Бид өнгөрсөн 3 сарын хугацаанд хэмжилт судалгаа бүх юмаа хийгээд дууссан. Одоогоор бид бүх бараа материал, тэндээс гарах холбогдох зардал гэдэг судалгаанд хийгдээд явж байна. Энэ судалгааны үнийн дүнгүүд гараад дууссангуут Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулагдаад, нийслэлийн төсөв дээр ингээд суулгах төлөвлөгөөтэй бид ажиллаад явж байна.

Д.Амарбаясгалан: Аудит 3 дугаар индэр.

Л.Эрдэнэчулуун: Сайн байцгаана уу. Шижир гишүүний асуултад хариулъя. Таны хэлсэн тооноос бидний гаргаж байгаа энэ сонсголд зориулж бэлтгэсэн ажлын хэсгийн хүрээнд ажлын даалгаврын хүрээнд бэлтгэж гаргасан тоо бол зөрөөтэй байгаа. Яагаад гэвэл 2024 оны үйл ажиллагаа санхүүгийн тайлан дүгнэлт гараагүй

учраас бид баталгаажуулж тоо баримтыг орхисон. Тийм учраас таны саяын асуултдаа дурдсан тэр тоонд хараахан хүрээгүй. Ер нь 2 мянга, энэ 25 онд Төсвийн байнгын хороогоор баталсан аудитын сэдэвт агаарын бохирдолтой холбоотой санхүүжилтийн үр дүн, арга хэмжээний үр дүн, гүйцэтгэлийн талаар манай Үндэсний аудитын газраас аудит хийгдэнэ.

Д.Амарбаясгалан: Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Аудитаас эхэлчихье. 2024 оны жилийн эцсийн дүнгээр эцэслэгдээгүй байгаа юм бол 2023 оны жилийн эцсийн дүнгээр 2008 оноос хойш агаарын бохирдол, утаанд яг хэчнээн төгрөг зарцуулсан юм бэ? Энэ дээр та тодорхой хариулт өгөөч? Та ингээд тодорхой хариулахгүй байна.

Хоёрдугаарх нь нийслэлээс дахиад тодруулъя. Олон улсын байгууллага, олон улсын банк, Дэлхийн банк зэрэг юунууд дээр санхүүжүүлэхээр ажиллаж байгаа, нийслэлийн санхүүжилтээр шийдвэрлэхээр бид ажиллаж байна, үнийн дүн гараагүй байна гэдэг чинь тодорхойгүй зүйлийг Улсын Их Хуралд оруулж ирж танилцуулга хийж байна шүү дээ. Одоо тэгээд нийслэлийн чинь төсөв батлагдчихсан байхгүй юу 2025 оных. Та нар хэрэгжээд зарцуулаад эхэлж байгаа. Энэ жилээс, энэ чинь 2026 оноос эхлээд явах ажил юм уу, энэ жилээс эхлээд явах ажил юм уу? Хэрвээ энэ жилээс эхлээд явах ажил юм бол төсөвгүй, төсөв нь тодорхойгүй байгаа ажлыг ямар үр дүнд хүрнэ гэж бид дараа нь юугаар хэмжих юм бэ?

Д.Амарбаясгалан: Одонтуяа сайд хариулт өгье.

С.Одонтуяа: Шижир гишүүний асуултад хариулъя. Агаарын бохирдлын үндэсний хороо 2025 оны 12 сарын 25-нд байгуулагдсан. Намайг Үндэсний хорооны даргаар томилсон. Ингэхдээ нөгөө өмнөх 25 оны төсөв батлагдсан байсан учраас Агаарын бохирдлын үндэсний хороонд 1 төгрөгийн ч төсөв төсөвлөгдөөгүй, зарцуулагдаагүй улсын төсвөөс гэдгээ хэлье. Агаарын бохирдлын үндэсний хороо 10 гаруй хүнтэй. Сая өнгөрсөн 5 сар өдөр, шөнөгүй ажиллалаа. Энд өөрсдөө бид яамныхаа төсвөөс ингээд зохицуулаад явсан.

2 дугаар нэг чухал асуудлыг хэлэхийг хүсэж байна. Энэ бидний хариуцаж авсан энэ 173 уурын зуух 2262 ААН байгаа, энэ ААН-ийг технологийн шинэчлэл хийхэд бас 1 ч төгрөгийн улсын төсөв байхгүй. Бид яаж энийг шийдэж байна вэ гэхээр ААН-ийн нөгөө орлогын 1 хувийн татварыг зарцуулж болохоор оруулж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одонтуяа сайд гүйцээж хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ 1 хувийн татварыг ерөөсөө ААН-үүдээс яваад гуйлга гуйж л хийж байгаа шүү дээ. Танайх 1 хувийнхаа өгчхөөч энэ агаарын бохирдлын зуух ингээ гээд. Энэ ажлууд бол ерөөсөө дан 1 хувийн гуйлгаар явж байгаа. Бид энэ дээр ямар нэгэн төсөв хөрөнгө улсын төсвөөс зарцуулаагүй байгаа. Би нэг зүйл дээр маш их шүүмжлэлтэй ханддаг. Аялал жуулчлалын байгууллагуудад жилийн 6 хувийн хүүтэй л гэнэ, хөдөө аж ахуйн байгууллагад хөнгөлөлттэй зээл гэнэ. Яг энэ агаарын бохирдлыг бууруулах гэж байгаа ААН-д ямар ч хөнгөлөлттэй зээл олдохгүй байгаа. Ногоон зээл гээд нэртэй боловч энэ зээл нь байхгүй. Тийм учраас Улсын Их Хурал энийг гартаа аваад, энэ ногоон зээлээ

шийдээд, агаарын бохирдлыг бууруулахад энэ хүн ногоон зээл, хөнгөлөлттэй зээлээ өгөхгүй бол бид энэ бохирдлоос салахад хэцүү байгаа шүү. Зүгээр нэр нүүрээрээ гуйлгын маягаар л энэ зуухнуудыг чинь шинэчлээд явж байна. Тэгээд одоо угаасаа Ардчилсан нам засгаас хөөгдөж байгаа, хөөгдөж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут үлдсэн байна. Золжаргал гишүүн 1 минутад үг хэлэх үү?

Ж.Золжаргал: Сонсгол хийсэн ажлын хэсэг гаргаад, дүгнэлтээ танилцуулах гээд бэлдсэн байгаа. Тэгээд саяын сайдын яриад байдаг зүйлс яг тусгагдсан. 1 дүгээрт нь мөнгө зараад, зарж байгаа мөнгө нь хүнд наалдацтай, дараа нь нэг утаанд юунд зарсан нь мэдэгдэхгүй алга болчихгүйн тулд гэрт нь наалдчихсан дулаахан сууцтай тохилог байлгахад нь зарцуулъя.

2 дугаарт нь утаа гаргадаг зуух түлшинд төсвөөс мөнгө зарцуулахгүй гэсэн үг орно.

3 дугаарт нь энэ үйл ажиллагааг Ерөнхий сайд ахална. Энэ олон талыг хамарсан зүйлс гээд. Тэгээд ийм зүйл Улсын Их Хурлаас орж ирэх гэж байхад Үндэсний хороон дээр тэр Хятадаас боловсруулсан нүүрсээр түлш худалдаж авна гэж юугаа яриад байна вэ? Энэ өнгөрсөн жил нэг ийм сонин юм хагас кокс, хөх нүүрс Хятадаас оруулж ирнэ гэж байгаад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ингээд сонсголын тогтоолыг дэгээрээ 1 цагийн дотор асуулт асууж, хариулт авч, үг хэлж хэлэлцэж дуусгахаар, сонсож дуусгахаар дэгтэй байгаа. Сунгах боломжгүй. Золжаргал гишүүн үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Нэгдсэн хуралдаанаар Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонслоо.

16.45 цаг

Тав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалд орно. Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоол. Ажлын хэсэг хэвээрээ, сууж байна. Сонсголтой холбоотой Засгийн газарт чиглэл өгөх Улсын Их Хурлын тогтоол хэлэлцэнэ. Засгийн, төслийн талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

М.Мандхай: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 7 дугаар сарын тогтоолоор, 7 дугаар тогтоолоор ерөнхий хяналтын сонсголыг агаарын бохирдлыг бууруулах хүрээнд Утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл гэсэн сэдвээр 2025 оны 2 дугаар сарын 3, 4-ний өдөр зохион байгуулсан. Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэнгээр ахлуулсан Ажлын хэсгээс Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд Утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл сэдэвт ерөнхий хяналтын сонсголыг

зохион байгуулсантай холбогдуулан ЗГ-т тодорхой асуудлаар чиглэл өгөх нь зүйтэй гэж үзсэнийг Байнгын хороо хүлээн авч дараах Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Төсөлд Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр 2025 онд дуусаж байгаатай холбогдуулан агаарын бохирдлын эх үүсвэр бүрд жигд анхаарч, салбар, салбар дундын оролцоог хангасан агаарын бохирдлыг бууруулах богино, дунд, урт хугацааны цогц төлөвлөгөөг боловсруулах, 2025-аас 2028 оны хугацаанд багтаан нийслэл болон төвлөрсөн суурин газрын агаарын чанарыг Монгол Улсын стандартын жилийн дундаж үзүүлэлтэд бүрэн нийцүүлэх, агаарын бохирдлын өндөр эрсдэлтэй бүсийг тодорхойлж, тухайн бүсэд байрлах сургууль, цэцэрлэг, эмнэлгийн дотоод орчны агаарын чанарыг тогтмол хянах, дотоод орчны агаарын чанарыг сайжруулах арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, угаартаж амь насаа алдсан иргэдийн мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, шалтгааныг тогтоох, нотолгоонд тулгуурлан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах, ахуйн орчинд угаартаж амь насаа алдсан иргэдэд нөхөн төлбөр олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо нь холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог хангах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг тогтмол тайлагнах, санхүүжилт, зарцуулалтын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох зэрэг 16 заалтыг тусгасан.

БОХХАА-н Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т заасныг баримтлан 2025 оны 4 дүгээр сарын 15, 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийг хэлэлцлээ. Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатар тогтоолын төсөлд утааны асуудлаар богино, дунд, урт хугацааны хэрэгжүүлэх тодорхой ажлыг тусгах, Улсын Их Хурлын гишүүн Идэрбат утаанд хордож, амь насаа алдсан иргэдэд нөхөн төлбөр олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх боломж байгаа эсэхийг судлах, иргэн, ААН-ийн үүрэг хариуцлагыг нь нэмэгдүүлэх, утаа мэдрэгчид зарцуулагдаж буй санхүүжилтийг яндангүй болгоход чиглэгдсэн цахилгаан, газ, сайжруулсан түлшний технологийн асуудалд зарцуулах, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлд Улаанбаатар хот төдийгүй агаарын бохирдол ихтэй аймаг, сумдыг хамруулах, тогтоолын хэрэгжилтийн явцыг тогтмол сонсох, Улсын Их Хурлын гишүүн Замира сайжруулсан түлшний үйлдвэрт тавих хяналтыг сайжруулах, БОХХАА-н байнгын хорооны харьяанд Агаарын бохирдлыг бууруулах дэд хороо ажиллах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан төр технологийн сонголт оролцохгүй байх, зах зээлийн зарчмаараа иргэд өөрт ашигтай байх сонголт хийх боломжийг нь бүрдүүлэх, Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулах асуудлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Батчимэг угаарын хийнээс болж амь насаа алдсан иргэдийн ар гэрт олгох нөхөн олговрын асуудлыг хэрхэн шийдвэрлэх, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороог Ерөнхий сайдаар ахлуулах, ЗГ-т чиглэл өгөх тогтоолын биелэлтийг ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Уянга агаарын бохирдлыг бууруулах асуудал нь бүх яамнуудтай хамаатай учраас Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороог салбар хоорондын уялдаа холбоог хангаж ажиллаж байгаа Ерөнхий сайд эсвэл Шадар сайдаар ахлуулах, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дуусаж байгааг анхаарч, цаашид авах арга хэмжээний талаар санал, төслийг боловсруулж танилцуулах, мөн дэд хэлэлцүүлгийн үеэр технологийн олон шийдэл танилцуулагдсаныг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллээр хангах

ажлыг ЗГ-аас зохион байгуулах, Улсын Их Хурлын гишүүн Ундраа тогтоолын төслийг дэмжиж, Тавантолгой түлш хязгаарлагдмал хариуцлагатай компанийн, ХХК-ийн нэрийг Улаанбаатар түлш болгож өөрчлөх талаар, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр гэр хорооллын өрх, ААН-д гэр, байшингийн дулаалгын норм, нормативын нэгдсэн стандартыг шинээр батлуулах, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар стандартын шаардлага хангасан цахилгаан халаалт, хий болон бусад түлшийг ахуйн орчин нөхцөлд нь тохирсон технологийн шийдлүүдийг нэвтрүүлэх, иргэд өөрсдөө сонгох эрхтэй байхаар зохицуулах, хатуу түлшний хэрэглээг халах ажлыг зохион байгуулахдаа үе шаттай, төлөвлөгөөтэй шилжих, Улсын Их Хурлын гишүүн Найдалаа тогтоолын төслийн бодлогын болон техникийн чанартай асуудлуудыг эрэмбэлэх, утааны асуудлыг хариуцах эзнийг тодорхой болгох, Тавантолгой түлш ХХК-ийн үр ашигтай ажиллах тал дээр анхаарч, менежмент, бүтэц зохион байгуулалтад анхаарах, угаарын хийнд хордож, амь насаа алдсан иргэдэд олгох нөхөн олговор болон хариуцлагын тогтолцооны эрх зүйн орчныг бий болгох талаар асуулт асууж, санал хэлсэн болно.

Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Алга байна. Сая хэлэлцчихсэн. Гишүүд, ирц бүртгэл нэг явуулъя. Санал хураалтад орох юм байна. Ингээд хэлэлцэх асуудал үндсэндээ, тогтоолын сонсох асуудлыг бид 3 сарын дотор, сарын сүүлийн долоо хоногийн баасан гарагт сонсох Дэгийн хуультай. Тэгээд өнөөдөр Байнгын хороо сонсголоос гарсан тогтоолын талаар Улсын Их Хурал сонслоо. Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төслийг ирэх долоо хоногийн чуулганы хуралдаан дээр санал хураалтыг явуулна.

16.53 цаг

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА